



ГАРЧИГ

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Улс төр-гэмт хэргийн нэгдэл, төрийн хууль ёсны байдлын асуудал. 3
С.Энхчимэг
2. Объектын судалгаа явуулах эрх зүйн үндэс, түүнийг бүрдүүлэхэд анхаарах асуудал. 14
Г.Бямбадорж

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Уголовная ответственность за уклонение от уплаты налогов в законодательстве ряда зарубежных стран 18
Лапшин Валерий Фёдорович

ЭРХ БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Нотлох баримтын шинж чанар: хамааралтай байдал, болохуйц байдал, баттай байдал. 22
Д.Мөрөн
2. Гэмт этгээдийг шилжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал. 25
Ц.Шийтэрчулуун

КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Гэмт хэргийг илрүүлэхэд криминалистикийн хэрэгцээ, шаардлага 30
Б.Жаргалсайхан
2. Технологические приемы обучение студентов юристов методике раскрытия преступления в учебных заведениях Монголии 34
Садыков Николай Будаевич

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Цагдаагийн байгууллагын хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн эрх зүйн уламжлал, шинэчлэл 37
Б.Баянмөнх
2. Жагсаал, цуглааны үед нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа, түүнийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж буй Их Британи улсын цагдаагийн байгууллагын туршлага 43
Ш.Чулуун
3. Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ажлын эрх зүйн зохицуулалтын түүхэн хөгжилт 50
Д.Бямбахүү
4. Монгол Улсад дипломат байгууллага, төлөөлөгчийн газруудын хамгаалалтад тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам 54
А.Гансүх
5. Нутгийн захиргааны байгууллага, цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны өнөөгийн хэлбэр, түүнийг шинжлэх нь 57
Ц.Адъяацэрэн

ТӨР, ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Захиргааны хууль бус актаас учирсан гэм хорыг арилгуулахтай холбоотой хэргийн харъяалал Захиргааны хууль бус актаас учирсан гэм хорыг арилгуулахтай холбоотой хэргийн харъяалал 62
Ц.Мөнхдэлгэр
2. Төрийн албан хаагчид оногдуулах хариуцлага: өнөөгийн байдал /төрийн жинхэнэ албан хаагчдад хүлээлгэх сахилгын шийтгэлийн тухайд/ 65
Н.Мөнхзул
3. БНХАУ-аас Хилийн чанадад Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулж буй өнөөгийн нөхцөл байдал, судалгааны ач холбогдол. 68
С.Оргил

ТӨР, ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Цахим үерхэл ба өшөө авалт. 72
Б.Энхжин

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

ЭРХЛЭГЧ

Д.ЗҮМБЭРЭЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Б.БАТ-ЭРДЭНЭ
МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШҮҮГЧ, ДОКТОР (Ph.D),
ПРОФЕССОР

Б.БОЛДБААТАР
МОНГОЛЫН КРИМИНОЛОГИЧДЫН ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Ж.ДОЛГОРСҮРЭН
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР

Н.ЖАНЦАН
МОНГОЛ УЛСЫН ГАВЪЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

А.ЛХАГВА
МОНГОЛ УЛСЫН ГАВЪЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D)

Б.ЭНХБОЛД
ДОКТОРАНТ

ЭРХЛЭН ГАРГАСАН:

С.ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D)

Б.МӨНХЗУЛ
МАГИСТР

**КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ****УЛС ТӨР-ГЭМТ ХЭРГИЙН НЭГДЭЛ, ТӨРИЙН
ХУУЛЬ ЁСНЫ БАЙДЛЫН АСУУДАЛ**

Судалгааны ажлын удирдагч:

АНУ-ын Терроризм, үндэстэн дамнасан гэмт хэрэг, авлигын судалгааны төвийн захирал, Жорж Мэйсон их сургуулийн Төрийн удирдлагын сургуулийн хүндэт доктор, профессор Луйз Шэлли

Авторын тухай:

Сэнгээгийн Энхчимэг нь бие даасан хараат бус судлаач бөгөөд ЗТАЖЯ, Хүйсийн тэгш эрхийн төв ТББ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, АНУ-ын Вашингтон хотын Терроризм, үндэстэн дамнасан гэмт хэрэг авлигын судалгааны төвд эрдэм шинжилгээний ажилтан, Вашингтон дахь Дэлхийн банкны Төв оффист Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах санаачилга хөтөлбөрт зөвлөхөөр тус тус ажиллаж байсан олон улсын туршилагатай эксперт юм. Одоо Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албад ажиллаж байна.

Тэрээр АНУ-ын Вашингтон хотын Жорж Мэйсон их сургуулийн Төрийн удирдлагын сургуульд эдийн засаг, төрийн бодлого, үндэстэн дамнасан гэмт хэрэг, мөнгө угаах чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан.

“Улс төр-гэмт хэргийн нэгдэл нь өөрийн санхүү, эдийн засгийн ашиг сонирхлыг ард иргэдийн эсвэл төрийн урт хугацааны зорилтын дээр тавьдаг тул уг холбоо нь бүхий л нийгэмд хор хөнөөл үчруулдаг”¹

¹ Menace to Society, chap. 7, Хуудас 199.

“Улс төр, гэмт хэргийн хоёр бүлгийн хүчний харьцаа нь гурван ангиллын хүчин зүйлсээс хамааран хэлбэлздэг, үүнд улс төр, эдийн засаг, нийгмийн соёл орно.”²

“...Зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл нь улсын улс төр, эдийн засаг, нийгмийн аппаратад нэвтэрч, тэдгээрийг хувийн ашиг сонирхолдоо ашиглах зорилгоор төрийн эрх баригчидтай үүсгэсэн, хамтын ажиллагааны харилцаа холбоо”³-г улс төр-гэмт хэргийн нэгдэл гэнэ. Уг нөхцөл бүрдэх шалтгаан, үүсэл нь тухайн орны онцлогоос хамааран харилцан адилгүй байдаг. Улс төр-гэмт хэргийн нэгдлийг үүсгэх нөхцлийг гуравангилдаг бөгөөд үүнд тухайн улсын улс төр, эдийн засаг, нийгмийн соёлтой холбоотой нөхцөл орно⁴.

ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтдаг байсан ихэнхи орнууд хамгийн өндөр түвшний улс төр-гэмт хэргийн нэгдэлтэй байдаг. Учир нь ЗХУ-ын улс төр, эдийн засаг, нийгмийн

² Menace to Society, 8–17.

³ National Strategy Information Center, “The Political-Criminal Nexus,” Trends in Organized Crime 5, no. 2 (December 1, 1999): 1, doi:10.1007/s12117-999-1032-3.

⁴ Menace to Society: Political-Criminal Collaboration Around the World (New Brunswick, N.J.: Transaction Publishers, 2003), 8–17.

соёлд бий болсон орчин нь улс төрд гэмт хэрэгтнүүд нэвтрэх, уг хоёр бүлэглэлийн бат бэх хамтын ажиллагаа бүрэлдэх нөхцлийг бүрэн үүсгэсэн байжээ. Тааруухан төлөвлөж, боловсруулсан улсын өмч хувьчлал, гадаадын зээл тусламжийг урвуулан ашигласан явдал нь ЗХУ-д үүсээд байсан улс төр-гэмт хэргийн нэгдлийг төрийн институцыг гэмт хэрэгжүүлэх хүртэл шат ахиулан бэхжүүлсэн. ЗХУ-ын жишээ нь улс төр болон мэргэжлийн гэмт хэргийн ертөнцийн нэгдлийн талаарх чухал сургамж өгдөг.

Улс төр-гэмт хэргийн нэгдэл нь улс төрийн тогтолцоо болон зохион байгуулалттай гэмт хэрэг болох хоёр бүлгийн хамтын ажиллагаа юм.⁵ Гэмт хэрэгтнүүд нь хууль бус үйл ажиллагааг ихэнхдээ нууц далд байдлаар эсвэл гэмт хэргийн ертөнцөд хэрэгжүүлдэг. Тэдний үйл ажиллагаа нь нийтээр дагаж мөрддөг нийтлэг зүй тогтол, дэг журмын гадуур явагддаг. АНУ-ын Стратегийн үндсэний судалгааны төв нь гэмт хэрэгтнүүдийг “Хоорондоо тогтмол харилцаа холбоотой

⁵ Menace to Society: Political-Criminal Collaboration around the World (New Brunswick, N.J.: Transaction Publishers, 2003), 7-18.



этгээдүүд бөгөөд нэг болон түүнээс дээш улс орны хууль бус эсвэл гэмт хэрэг гэж тодорхойлсон, ашиг олоход чиглэсэн нууц далд, хуульд харш үйл ажиллагаагаар амь зогоодог хүмүүс⁶ гэж тодорхойлжээ.

Үүний эсрэг, улс төрийн тогтолцоо, байгууламж нь бүх нийтийн сайн сайхныг хамгаалахад чиглэсэн хууль, дүрэм журмыг бий болгох ёстой. Нэгдүгээр түвшний албан хаагчдад “Засгийн газрын гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх засаглал”⁷ орно. Үүнд “аюулгүй байдлын тогтолцоо, цэргийн, хагас цэрэгжүүлсэн, тагнуул болон үндэсний аюулгүй байдлын албад, цагдаа болон хууль сахиулах байгууллага, прокурор, шүүх”⁸ орно. Хоёрдугаар түвшинд дээрх албан хаагчдад дэмжлэг үзүүлдэг мэргэжилтнүүд багтах бөгөөд тэдэрт “Улс төрийн намынхан, олон нийтийн харилцаа холбоо хариуцсан компаниуд (public relations-PR), бизнесийн салбар, хуулийн зөвлөгөө өгөгчид, нягтлан бодогчид болон төрийн бус байгууллагууд”⁹ багтдаг. Гуравдугаар бүлэгт албан хаагчдын албан тушаалд солигдож байдаг улс төрийн эсрэг хүчнийхэн ордог.¹⁰

АНУ-ын Стратегийн үндэсний судалгааны төвийн мэдээлж буйгаар “Төр болон зохион байгуулалттай гэмт хэрэг нь хэзээ ч салангид байгаагүй...” бөгөөд Засгийн газар гэмт хэрэгтнүүдийг мэдээллийн чухал эх сурвалж болгон ашиглах тохиолдол ч байсан. Зохион байгуулалттай гэмт хэрэг нь “ихэнхи улс орнуудын

засаглалын үйл явцын нэгэн хэсэг болоод байна. “2003 оны байдлаар 192 орны 155 улсад улс төр-гэмт хэргийн нэгдэл оршиж байна”¹¹ гэжээ. Улс төр-гэмт хэргийн нэгдэл нь олон улс оронд түгээмэл байгааг онцолж байгаа ч дайн, үймээн самууны үед гэмт хэрэгтнүүдээс стратегийн ач холбогдолтой мэдээлэл авах нь төрийн бодлого боловсруулах үйл явцад тэднийг ашиглах нь гэмт хэрэгтнүүдийн ашиг сонирхолд нийцүүлэн бодлого боловсруулахаас ялгаатай юм.

Засгийн газар нь бослого үймээн дэгдээгч нарын хяналтад орсон бүс нутгийг эргүүлэн хяналтандаа авахад гэмт хэрэгтнүүдийн тусламжийг ашигласан тохиолдлууд түгээмэл байдаг. Тухайлбал, Меделлин хар тамхины картелтай хийсэн дайны үеэр Засгийн газар нь гэмт хэрэгтнүүдийн нөөц боломж, мэдлэгт ихээхэн тулгуурлаж байжээ.¹² Тэр ч байтугай АНУ-ын түүхэнд төр нь зохион байгуулалттай гэмт хэрэгтнүүдтэй хамтран ажиллаж байсан тохиолдол бий.

Дэлхийн II дайны үеэр Нью Йоркийн боомт нь АНУ-д стратегийн ач холбогдол бүхий газар байсан бөгөөд үүнийг Нацистуудын хорлон сүйтгэх ажиллагаанаас хамгаалах нь маш чухал байсан. Тухайн үед уг боомтыг Мафи болон Лонгшормэны холбоо хянадаг байжээ. Мафи нь төрийн хэрэгжүүлэхээс зайлсхийсэн арга хэрэгслийг ашиглах боломжтой байсан. Ингээд АНУ-ын Тэнгисийн цэргийн тагнуулын алба нь тухайн үед шоронд хоригдож байсан Америкийн Мафийн

толгойлогч нарын нэг болох Лаки Лучианотой холбогдож тохиролцоо хийсэн. Хэрэв Мафи нь боомтыг хамгаалахад тусалбал Лаки Лучианог Нью-Йорк мужийн хойд хэсэгт орших Данаморра мужийн шоронгоос Манхатантай ойролцоо орших шорон руу шилжүүлнэ гэж тохиролцжээ. Ингээд боомтыг амжилттайгаар хамгаалж, дайны дараа Лучианог Америкаас Итали руу шилжүүлсэн байна.¹³

Мэргэжлийн зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүд нь төрөөс илүү аюулгүй байдал, нийгмийн халамж үзүүлж байсан тохиолдлууд ч бий. Улс төр-гэмт хэргийн харилцаа холбоогүй улс төрийн систем орших бараг боломжгүй байдаг. Уг хамтын ажиллагаа нь өөр өөр түвшний албан хаагчдын харилцаа холбооноос бүрддэг. Орчин, нөхцөл байдалд нөлөөлж буй хүчин зүйлс нь энэ хоёр бүлгийн харилцааны хүчний харьцааг хэлбэлзүүлж байдаг. Уг харилцаа холбоо нь хувирамтгай, үргэлж хөдөлгөөнд оршдог. Тухайлбал, төрийн давамгайл байдал нь нийгмийн эмх цэгц, дүрэм журмыг сахиулах чадваргүй байдлаас болж буурч болно. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын хууль ёсны байдал нь их хэмжээгээр буурахад гэмт хэрэгтнүүдийн хяналт давамгайлах хандлагатай байдаг.

Хамгийн гол асуудал нь энэхүү хоёр бүлгийн хүчний харьцаа юм. Уг харилцаа холбоонд төр нь давамгайлсан байр суурьтай байж зөвхөн тодорхой бүлгийн ашиг биш, нийгмийн сайн сайхныг урьтал болгох боломжтой. Энэ нь

⁶ Menace to Society, 6.

⁷ Menace to Society, 3–5.

⁸ Ибид.

⁹ Ибид.

¹⁰ Ибид.

¹¹ Menace to Society, 6.

¹² National Strategy Information Center, “The Political-Criminal Nexus,” 4.

¹³ Annelise Anderson, “Causes of the Political Criminal Nexus,” 2012/12/15 нэвтэрсэн, <http://andrsn.stanford.edu/Other/pcn.html>.



гурван ангиллын хүчин зүйлсээс хамааран хэлбэлздэг, үүнд улс төр, эдийн засаг, нийгмийн соёл орно.¹⁴ Улс төрийн хүчин зүйл нь ерөнхийдөө Засгийн газрын улс төрийн засаглал тогтоох чадавхи болон ард иргэдийн хууль ёсны байдлыг нь хүлээн зөвшөөрч буй үзүүлэлт, түүний удирдан жолоодох чадавхиас хамаардаг. Улс төр-гэмт хэргийн нэгдэл нь төрийн эрх барьж буй улс төрийн намд тавих хяналт тэнцвэр нь дутмаг эсвэл засгийн газартай харьцуулахад сул дорой иргэний нийгэмтэй улс орнуудад цэцэглэн хөгждөг.

Хяналт тэнцвэр (checks and balance) гэдэг нь “Эрх мэдэл төр засгийн гурван салаанд (хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх) хуваагддаг бөгөөд салаа бүр тус тусын эрх үүргийн дагуу бусад салбарт хяналт тавьж тэнцвэржүүлж байдаг. Ийм хяналт тэнцвэр засгийн газраас иргэдийн өмнө хүлээх ба ээлжит сонгуулиар дамжин хэрэгждэг улс төрийн хариуцан тайлагнах тогтолцоог бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг”.¹⁵

Төрд хяналт тавьдаг байгууллагуудын дутагдал нь улс төрчдөд хариуцлага, дагаж мөрдөх, гэм зэмээ хүлээх, үүрэг хүлээх болон тайлагналтын хариуцлагын тогтолцоо бүрдүүлэхэд хүндрэл үүсгэдэг. Үүний улмаас тэд төрийн эд баялаг, засгийн газар доторх хүчний тэнцвэрт байдал, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хувийн ашиг сонирхолдоо ашигладаг. Тэд мөн зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүдийг ч төрийн хяналтын гадуур байлгаж, чухал мэдээллийн эх үүсвэрт нэвтрүүлэх замаар

ашиглаж ч болзошгүй. Иймээс сул дорой институт, улс төрийн ивээн тэтгэх системтэй, Засгийн газар нь хууль журам сахиулах чадваргүй нийгэмд улс төр-гэмт хэргийн нэгдэл өсөн төлждөг. Энэ төрлийн улс төрийн систем нь тогтворгүй бөгөөд олон нийтийн бослого, иргэний дайнд хүртэл өртөмтгий байдаг. Уг нөхцөл нь төрийн гэмт хэргийн бүлэглэлүүдтэй хамтарч “хүссэн эмх цэгц”-ээ бүрэлдүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Энэ төрлийн төрийн бодит шинж чанар нь гэмт хэргийн байх бөгөөд улс төр-гэмт хэргийн нэгдэлд идэгдсэн байдаг.

“Улс төр болон эдийн засгийн шилжилтийн үед буй орчин цагийн төр нь улс төр-гэмт хэргийн нэгдэл хөгжихөд маш өртөмтгий байдаг.”¹⁶ Эрдэмтэн Годсоны онцолж буйгаар “Эдийн засаг болон улс төрийн шилжилтийн байдал нь нийгэмд ямар зан төлвийн хэм хэмжээг зөвшөөрч болох уу гэдэгт тодорхойгүй байдал үүсгэж, хуучин болон шинэ төрийн албан хаагчдад гэмт хэргийн оппортунистуудтай хамтран ажиллах маш таатай орчин бүрдүүлдэг.”¹⁷ Учир нь хяналт нь хуучин тогтолцоо болон шинээр үүсч буй засгийн газар аль алианаар нь баталгаажуулагдахгүй байдаг.

ЗХУ болон түүний харъяанд байсан улс орнуудад коммунизмаас ардчиллын тогтолцоонд шилжих үед институцийн хоосон орон зай үүссэний улмаас улс төр-гэмт хэргийн нэгдэл үүсэх нөхцөл бий болсон. Үр нөлөөгүй засгийн газрын бодлого, тодорхойгүй улс төрийн систем, хяналт тавьдаг

байгууллагуудын дутмаг байдал нь эдгээр сул дорой төрүүдэд авилга өргөжин тэлэх нийгмийн соёлыг бий болгож, улмаар улс төр-гэмт хэргийн нэгдлийг үүсгэсэн.

Дараагийн нөхцөл байдал болох нийгмийн соёлын асуудал нь улс төр-гэмт хэргийн нэгдэл үүсэхэд онцгой үүрэг гүйцэтгэдэг. Гэмт хэрэгтэн ч энгийн иргэн ч тэдэнд аюулгүй байдал, эдийн засаг, хувийн хэрэгцээ шаардлага, тэмцэл зөрчилдөөнд шийдвэр гарц бий болгодог бүлгүүдэд хүлцэнгүй дуулгавартай хандах хандлагатай байдаг. Энэ нь ивээн тэтгэгч-хүлээн авагчийн харилцааг (Patron-Client) үүсгэж улс төрийг хувийн ашиг сонирхолд суурилсан (персоналистик/personalistic) систем болгодог. Мөн соёлын болон гэр бүлийн хүчтэй өв уламжлал нь персоналистик улс төр бүрэлдэхэд нөлөөлдөг.

Ивээн тэтгэгч-хүлээн авагчийн харилцаа нь Латин Америкийн хуучин колони улсуудад түгээмэл байдаг. Колончлолын үед Португалийн колончлогчид нутгийн элитүүдтэй бат бэх ивээн тэтгэлтийн харилцааг үүсгэсэн. Колончлогчид нь өөрсдийн эрх мэдэл, хяналтыг нутгийн элитүүдтэй бий болгосноор тухайн бүсэд хяналтаа тогтоодог байсан бөгөөд үүний хариуд элитүүдэд тусгай эрх дарх эдлүүлж, ховор хомсдолтой нөөц баялагт нэвтрэх онцгой эрхийг олгодог байжээ. Иймээс Латин Америкт колончлолын үеэс үүдэлтэй ивээн тэтгэгч-хүлээн авагчийн нийгмийн соёл бүрэлдсэн.

Авлига хахуулийг олон нийт энгийн үзэгдэл, хүлээн

¹⁴ Menace to Society, 8–17.

¹⁵ Ц.Даваадулам, “Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг”, (Улаанбаатар, 2010), 19.

¹⁶ National Strategy Information Center, “The Political-Criminal Nexus,” 8.

¹⁷ Menace to Society, 11.



зөвшөөрч болохуйц зүйл хэмээн хүлээн авах олон нийтийн үзэл бодол нь улс төр-гэмт хэргийн нэгдэл бий болоход нөлөөлдөг. **Гэмт хэрэг, авлига хахууль хоёрыг нэг зоосны хоёр тал хэмээн авч үзэж болох бөгөөд оршин тогтнол нь бие биеэсээ харилцан хамааралтай.** Мэргэжлийн гэмт хэрэгтнүүд нь өөрсдийн зорилгодоо хүрэхийн тулд хууль журмаас гадуур үйл ажиллагаа явуулах бүхий л боломж бололцоог чадварлагаар ашигладаг оппортунистууд юм. Ингэхдээ тэд авлига хахуульд автсан улс төрийн тогтолцоог ашигладаг. Авлига хахууль нь нийгмийн өдөр тутмын амьдралд нэвчих үед авлига хахуулийн дадал зуршил үүсч, энэ нь энгийн үзэгдэл болон хувирдаг. Улмаар хүмүүс хүлээн зөвшөөрч болохуйц зүйл болон болохгүй зүйлийг ялгахад больдог. **Энэ нь цаашлаад жигшихүйц хууль бус үйл ажиллагаа болон эрхэмлэхүйц шударга ёсны хоорондын ялгааг бүдгэрүүлж эхэлдэг.**

Гэмт хэрэгтнүүдийг үндэсний баатрууд гэж хүлээн зөвшөөрдөг нийгэм нь гэмт хэрэгтнүүдийн авлига хахуулийн дадал зуршлыг “хууль ёсны” болгон хувиргадаг. Засгийн газар нь нутгийнханд хүрч ажиллаж чадахгүй байгаа, нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлж, аюулгүй байдлыг хангаж чадахгүй институцийн хоосон орон зай үүссэн газарт мэргэжлийн гэмт хэрэгтнүүд уг хоосролыг нөхөх хандлага гаргадаг. Ийм нөхцөлд гэмт хэрэгтнүүд нь баатрууд болон хувирдаг. Тухайлбал, Колумбийн Мэдэллин картелийн Кокайны Загалмайлсан эцэг хэмээн нэрд гарсан Пабло Эскобар нь олон нийтэд “Шилийн сайн

эр” эсвэл “Робин Гуд” мэтээр хүндлүүлж байсан.¹⁸ Тэрээр төрийн үйлчилгээ, тусламж хүрдэггүй ядуусын алслагдсан хороололд орон сууц, сургууль, сүм хийд бариулж байсантай холбоотой. Түүнийг нас барсны дараа хүртэл хүмүүс оршуулган дээр нь цэцэг авчирч, түүнд дуу хүртэл зохиож, өнөөг хүртэл дуулдаг байна.

Энэ төрлийн нийгэмд залуус нь баян чинээлэг хүмүүсийг шүтэн бишрэх хандлагатай байдаг. Тэдэнд мөнгөний эх үүсвэр, мөнгө олоход ашигласан арга зам нь чухал биш болчихдог. Тэд мэргэжлийн зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлийг ажил олгогчид, амьдралаа дээшлүүлэх боломж, аюулгүй байдлын баталгаа гэж хардаг. Энэ нөхцөл байдал нь гэмт хэрэгтнүүдэд улс төрийн шийдвэрт нөлөөлөх боломж эсвэл улс төрийн сонгуульд ялах боломжийг ч олгодог тул сайн засаглал, улсыг бүхэлд нь удирдан жолоодох төрийн нэгдмэл чанарт маш сөрөг нөлөөтэй. **Улмаар албан ёсны жинхэнэ Засгийн газрын хажуугаар параллель мэргэжлийн гэмт хэрэгтнүүдийн засаглал бий болдог.** Эрдэмтэн Стрэнж үүнийг “Төрийн ухралт” гэж нэрлэсэн.¹⁹ Энэ нь төрийн албан хууль ёсны байдал нь өөр нэгэн засаглалын хүчнээс болж буурсныг хэлж байгаа бөгөөд энэ тохиолдолд мэргэжлийн зохион байгуулалттай гэмт хэрэгтнүүд юм.

Улс төр-гэмт хэргийн

нэгдэлд нөлөөлөх дараагийн хүчин зүйл нь эдийн засгийн нөлөөлөл юм. Гэмт хэрэгтнүүд нь сөрөг аргаар бизнес эрхлэгчид бөгөөд үүнтэй уялдан ямар ч бизнес үйл ажиллагаатай адил тэдний бизнес нь эрэлт болон нийлүүлэлтийн харилцан уялдаа холбооноос шууд хамаардаг. “Хууль бус бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт болон үүнийг нийлүүлэлтээр хангах ажиллагаа нь зохион байгуулалттай гэмт хэрэг бий болоход онцгой үүрэг гүйцэтгэж, улмаар улс төр-гэмт хэргийн нэгдэл бий болох үйл явцыг хялбарчилдаг”.²⁰ Энэ нөхцөлд зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл нь төрөөс илүү эрх мэдэлтэй болж улсын эдийн засгийг хянах, түүнд нөлөөлөх чадвартай болдог. Тухайлбал, улсын өмчит үйлдвэр, компаниудын хувьчлалыг буруу төлөвлөж явуулсан нь улс төрд гэмт хэрэгтнүүд нөлөөллөө бэхжүүлэхэд хүргэж, төрийг гэмт хэрэгжүүлэх үүд хаалгыг ЗХУ-д нээсэн. “...1993 оны дунд үе гэхэд ОХУ-д 40 мянган аж ахуйн нэгж зохион байгуулалттай гэмт хэргийн байгууллагуудын хяналтанд орсон байсан.”²¹ Үүний уршгаар ОХУ-ын төрийн эрх мэдэл буурч, авлига, хахууль нийгмийн салаа мөчир бүхэнд бүрэлдэж, төрийн институцууд нь гэмт хэрэгжсэн.

“Бүх нийгэмд, улс төр-гэмт хэргийн нэгдэл нь маш хор уршигтай, учир нь энэхүү холбоо нь өөрийн санхүүгийн ашиг сонирхлыг иргэд эсвэл төрийн урт хугацааны ашиг сонирхлын дээр тавьдаг”.²² Гэмт

¹⁸ PBS Frontline - Godfather of Cocaine - Pablo Escobar - Хэсэг 1/4, 2011, http://www.youtube.com/watch?v=gVXSekpHvYM&feature=youtu.be_gdata_player.

¹⁹ Susan Strange, *The Retreat of The State: The Diffusion of Power in the World Economy*, Cambridge Studies in International Relations 49 (New York: Cambridge University Press, 1996), 110–121.

²⁰ Menace to Society, 15.

²¹ Svetlana P. Glinkina, “Privatizatsiya and Kriminalizatsiya: How Organized Crime Is Hijacking Privatization,” *Demokratizatsiya: Journal of Post-Soviet Democratization* 2 (1994), 388.

²² Menace to Society, chap. 7, Хуудас 199.



хэргээс олох их хэмжээний ашиг орлого нь гэмт хэрэгтнүүдийг “эрх баригчид”-ыг авлига, хахуулийн аргаар худалдан авах боломжийг бүрдүүлдэг. **Ингэхдээ тэд шударга ёс, шүүн таслах ажиллагаанаас дархлаажиж, хяналт эрх мэдлийн бүсээ өргөжүүлдэг.** Энэ нь эргээд Засгийн газрын хууль ёсны байдлыг сулруулдаг. Өмч хувьчлал нь ОХУ-д бусад ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнуудаас эрт явагдсан. Өмч хувьчлалыг эхлүүлснээс 5 жилийн дараа ОХУ-ын Засгийн газар нь улсын эдийн засгийн 20 хүрэхгүй хувийг хяналтандаа байлгаж байжээ.²³ Иймд шинэ Засгийн газрын үр нөлөөт байдал нь анхнаасаа л доройтолд орсон.

Түүнчлэн, Үндэсний аюулгүй байдлын төв улс төр-гэмт хэргийн нэгдлийн талаарх дэлгэрэнгүй судалгаандаа гэмт хэргийн байгууллагууд болон тэдний хамтрагчдын хууль ёсны эдийн засгийн нэгжүүдэд үзүүлэх үйлчилгээний түргэн шуурхай байдал нь улс төр-гэмт хэргийн нэгдлийг өргөжин хөгжихөд нөлөөлдөг гэж дурджээ.²⁴ “Хууль бус банк, санхүүгийн байгууллагууд нь хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг банкуудыг бодвол татвараас зайлсхийх, мөнгө угаах ч биш бүр хууль ёсны санхүүгийн гүйлгээнд хүртэл илүү түргэн шуурхай, энгийн, хүнд сурталгүй, найдвартай үйлчилгээ үзүүлж болзошгүй.”²⁵ Иймд бүтцийн алдаа дутагдал, дагаж мөрдөх ёстой процедур нь авлига хахууль зэрэг хууль бус үйл ажиллагааг өргөжихөд нөлөөлдөг. Үүнтэй уялдан хууль ёсны болон хууль бус үйл

ажиллагаа нь хамгийн өндөр эрсдэл бүхий салбаруудад холилдож болзошгүй. Үүнд, сонгуулийн санхүүжилт, сонгууль, банк санхүү, үл хөдлөх хөрөнгө, ачаа тээвэрлэлт, жижиг дунд үйлдвэрлэл зэрэг багтана. Энэ үед зөв хүмүүстэй танил байж, тэдэнтэй сайн харилцаа холбоотой байна гэдэг нь маш чухал болдог. Тэд асуудлын бодит шинж чанар, оролцогчдын ашиг сонирхлоос шалтгаалан өөр өөр төрлийн улс төр-гэмт хэргийн нэгдлийн бүлэглэл бий болгодог.

Улс төр-гэмт хэргийн нэгдэлд оролцож буй талууд нь харилцан адилгүй ашиг хонжоо хүртдэг. Гэмт хэргийн бүлэглэлүүд нь ихэвчлэн нутгийн болон үндэсний хэмжээний улс төрийн эрх мэдэлтнүүдтэй эрсдлээ бууруулах зорилгоор харилцаа холбоо үүсгэдэг. Гэмт хэрэгтнүүдийн нэн тэргүүний сонирхол нь ашиг хонжоог дээд цэгт нь хүргэх ч мөн нийгмийн хүндэтгэл хүлээх, нийгмийн дайснуудаа устгах сонирхолтой байж болно. Улс төрчид нь хөрөнгөжихөөс өөр сэдэлтэй ч байж болно. Улс төрийн эрх мэдэлтнүүдийн хөрөнгөжихөөс бусад сэдэлтийг тодорхойлох нь бодлогын чанартай алдааг илрүүлэхэд ач холбогдолтой. Хэрэв улс төрчид нь сонгуулийн компанит ажлаа санхүүжүүлэх зорилгоор гэмт хэрэгтнүүдтэй хамтарч байгаа бол сонгуулийн санхүүжилтын шинэчлэл нь асуудлыг шийдвэрлэхүйц бодлогын чанартай асуудал байж болох юм.

Дүгнэлт

Улс төр-гэмт хэргийн нэгдлийг үүсгэх орчин болдог улс төр, эдийн засаг, нийгмийн соёлын нөхцөл байдлууд нь

тухайн улсын онцлог шинж чанараас хамааран ялгаатай байдаг. Өөр өөр нөхцөл байдал нь орчиндоо зохицсон улс төр-гэмт хэргийн нэгдлийг бий болгодог. Тэр ч байтугай тухайн нийгэм нь өөрийн онцлогт нийцсэн олон төрлийн зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлийг үүсгэхэд хүргэдэг. Иймд тухайн орны түүх, нийгмийн хэм хэмжээ, үнэт зүйлс болон сэтгэлгээг улс төр, гэмт хэрэг улмаар улс төр-гэмт хэргийн нэгдлийг ойлгохын тулд харгалзан үзэх нь маш чухал юм.

Зарим эрдэмтдийн судалгаанаас үзэхэд, улс төр-гэмт хэргийн нэгдэл нь олон оронд түгээмэл байгааг онцолж байгаа ч дайн, үймээн самууны үед гэмт хэрэгтнүүдээс стратегийн ач холбогдолтой мэдээлэл авч төрийн бодлого боловсруулах үйл явцад тэднийг ашиглах нь гэмт хэрэгтнүүдийн ашиг сонирхолд нийцүүлэн бодлого боловсруулахаас ялгаатай юм.

Судалгааны эцэст дүгнэхэд хоёр өөр зорилготой (улс төр, гэмт хэрэг) бүлгийн харилцаанд хүчний харьцаа нь хамгийн чухал асуудалд тооцогдож байна. Энэхүү нэгдэл, харилцаа холбооноос зайлсхийх аргагүй, эцсийн мухардалд орсон нөхцөлд төр нь өөрийн давамгай байдлыг хадгалах, удирдан жолоодох чадвартай байснаараа өөрийн жинхэнэ үүрэг болох иргэдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалж, урт хугацааны зорилтот ашигтай нөхцлийг бүрдүүлж чадна. Үүнд, улс төр, эдийн засаг, нийгмийн соёлтой холбоотой нөхцөл байдал үндсэн үүрэг гүйцэтгэнэ. Учир нь төр нь хууль ёсны гэж хүлээн зөвшөөрөгдөхийн тулд эдгээр гурван салбарт чадавхиа давхар хангах шаардлагатай.

²³ Menace to Society, chap. 7, Хуудас 201.

²⁴ National Strategy Information Center, “The Political-Criminal Nexus,” 10–12.

²⁵ Ибид., 10.



Уг асуудалд бүтэц, төрийн бодлогын оновчгүй асуудлууд ч авлига хахууль бусад гэмт хэргийг өдөөх, гэмт хэрэгтнүүдийн үйл ажиллагааг хүчээ авахад ч нөлөөлдөг. Иймд тухайн улсын нөхцөл байдал, онцлогт тохирсон төрийн бодлогыг оновчтой хэрэгжүүлэх нь улс төр-гэмт хэргийн нэгдлээс сэргийлэх, гэмт хэрэгтнүүдийн үйл ажиллагаа өргөжин тэлж, эдийн засаг, нийгмийн соёлд тодорхой байр суурь эзлэх, улмаар улс төрд нөлөөлөх боломжийг бууруулахад ач холбогдолтой.

Ном зүй

Annelise Anderson, "Causes of the Political Criminal Nexus," 2012/12/15 нэвтэрсэн, <http://andrsn.stanford.edu/Other/pcn.html>.

Menace to Society: Political-Criminal Collaboration around the World (New Brunswick, N.J: Transaction Publishers, 2003)

National Strategy Information Center, "The Political-Criminal Nexus," Trends in Organized Crime 5, no. 2 (December 1, 1999).

PBS Frontline - Godfather of Cocaine - Pablo Escobar, 2011, <http://www.youtube.com/watch?v=gVXSekpHvYM&feature=youtu>

be_gdata_player.

Susan Strange, The Retreat of The State: The Diffusion of Power in the World Economy, Cambridge Studies in International Relations 49 (New York: Cambridge University Press, 1996).

Svetlana P. Glinkina, "Privatizatsiya and Kriminalizatsiya: How Organized Crime Is Hijacking Privatization," Demokratizatsiya: Journal of Post-Soviet Democratization 2 (1994), 385-394.

Ц.Даваадулам, "Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг" (Улаанбаатар, 2010).





POLITICAL-CRIMINAL NEXUS AND THE ISSUE OF THE STATE LEGITIMACY

Research led by:

Doctor Professor Louise Shelley

Director, Terrorism, Transnational Crime and Corruption Center (TraCCC)

University Professor, School of Public Policy, George Mason University

About the author:

The Author, Ms. Enkhchimeg Sengee (Mahra), is an independent, free-lance Researcher. In Mongolia, previously, she worked for the government ministry, a non-profit organization, as well as the United Nations Development Programme for Development. Ms. Sengee has a graduate degree from the School of Public Policy of George Mason University in Washington DC with a Master's Degree in Economics, Public Policy, and concentration on Transnational Organized Crime and Money Laundering.

In Washington DC, she worked as a Researcher at Terrorism, Transnational Crime, and Corruption Center (TRACCC), and at the World Bank headquarters as a Short-Term Consultant at the Stolen Asset Recovery Initiative.

Currently, Ms. Sengee works at the Financial Information Unit of the Central Bank of Mongolia.

“In all societies, the political-criminal nexus is harmful because this coalition places its financial interests above those of the citizenry or the long-term objectives of the state”¹

The power relation of these two groups fluctuates depending on three groups of factors: political, economic, and cultural².

A political criminal nexus is a “... collaborative relationship of organized crime groups with state authorities to gain access to, and to exploit for their own purposes, the political, economic and social apparatus of the state”³. The cause and occurrence of political-criminal nexus (PCN) are specific to the unique conditions of a given country. In general, the causal conditions of PCN are classified into three main categories: *political, economic, and cultural*⁴.

Most countries of the former Union of Soviet Socialist Republics (USSR) have a medium to strong PCN. The political, economic, and cultural conditions in USSR could not have been better suited to the occurrence of a solid PCN. Due to ill-designed privatization and misguided foreign aid the PCNs in USSR further solidified transforming itself into a criminalization of the state institutions in Soviet Union. Therefore, the PCNs in USSR and Soviet Union provide vital lessons about synthesis of politics and professional criminal world.

A political-criminal nexus

(PCN) is a collaboration of two sets of groups: the political establishment and the organized crime⁵. The *criminals* often conduct their illicit activities in a clandestine manner or in the underworld. Their activities are shielded from a common-set rules and regulations that the rest of the society abides by. The National Strategy Information Center determines criminals in the same vein as “Individuals who have an ongoing relationship with one another, who make their living primarily from a variety of clandestine, profit-making activities deemed illegitimate or criminal by one or more states”⁶.

In contrast, a political establishment creates the rules and regulations in order to safeguard the welfare of overall society. Godson identifies different levels within this establishment. The first level is the *office holders* - the “executive, legislative and judicial branches of government”⁷. This includes “...security bureaucracies, the military, paramilitary, intelligence and security services, diverse police and law enforcement, prosecutors and judges”⁸. The second group is the *front men*

³ National Strategy Information Center, “The Political-Criminal Nexus,” *Trends in Organized Crime* 5, no. 2 (December 1, 1999): 1, doi:10.1007/s12117-999-1032-3.

⁴ Menace to Society: Political-Criminal Collaboration Around the World (New Brunswick, N.J.: Transaction Publishers, 2003), 8–17.

¹ Menace to Society, chap. 7 Page 199.

² Menace to Society, 8–17.

⁵ Menace to Society: Political-Criminal Collaboration around the World (New Brunswick, N.J.: Transaction Publishers, 2003), 7–18.

⁶ Menace to Society, 6.

⁷ Menace to Society, 3–5.

⁸ Ibid.



responsible for supporting office holders. “They include political party officials, public relations firms, businesses, legal advisers, accountants, and NGOs supportive of the parties”⁹. The third group is the *legal opposition* that rotates in and out of official positions¹⁰.

“The state and organized crime have never been separate...” and the Government used criminals as a vital source of information in the past. NSIC reveals that the organized crime has become part of the ‘governing processes in a majority of the countries in the world. By 2003, 155 of 192 states in the world had weak (35) to strong characteristics of political-criminal nexus’¹¹. As mentioned, some literature on the PCN suggest that these coalitions tend to exist in many countries, however it is crucial to emphasize that during civil unrest or war criminals could be used as an important source of intelligence or strategic information to the state. But it is fundamentally different than making a public policy favorable to the criminal world-as in the case of the PCN.

There are many instances that the government sought assistance from criminals to establish control over isolated parts of the country dominated by insurgents. In the war against Medellin cartel, the government often relied on the resources and expertise of the criminals¹². Also, there are cases even in the history of the United States of America (USA) where state apparatus cooperated with the organized crime.

During the World War II, the New York harbor was a strategic

unit to the U.S. and it was essential to protect it from the Nazi sabotage. During that time, the Mafia and the Longshoremen’s Union controlled the harbor and could use techniques that the state was reluctant to use. So, the Naval Intelligence of the U.S. contacted the leading American Mafia figure-Lucky Luciano-who happened to be in a prison. They made a deal that if the Mafia helps protect the harbor, Lucky Luciano will be transferred from the upstate New York (Danamorra State Prison) to location closer to Manhattan. The harbor was protected and at the end of the war Luciano was deported to Italy¹³.

There are other instances where professional organized crime groups provided more protection and welfare to the people than the state. It is almost impossible to find a political system immune to PCN. The cooperation between the political establishment and the criminal underworld consists of interaction between different levels of officials. Factors related to changing conditions contribute to changes in power relations among the groups. The relationship is dynamic and fluid. For example, a dominant role of the government could change due to its inability to maintain order in a society. In other words, criminals tend to dominate PCN if the government legitimacy is substantially undermined.

The vital factor remains the power relation within the nexus or relationship because only if the state is dominant in this relationship, it could safeguard the well-being of the whole society, not only profit-maximization of a certain group (criminal authority).

¹³ Annelise Anderson, “Causes of the Political Criminal Nexus,” accessed December 15, 2012, <http://andrsn.stanford.edu/Other/pcn.html>.

The power relation of these two groups fluctuates depending on three groups of factors: *political, economic, and cultural*¹⁴. *Political factors* are mainly related to the state capacity to govern and its legitimacy to rule over others. PCNs flourish in a society which lack of checks and balance of a major ruling political party or weak civil society in comparison to the government.

Checks and balance means “Power is divided among three branches of the government (legislature, executive, and judiciary), each of which checks-that is restrains-and balances the others. The branches share certain powers but also exercise some exclusive powers. Such checks and balances are essential to complement the political accountability of the government to the population, which is exercised through periodic elections.”¹⁵

The politicians are not held accountable for their actions due to a lack of watchdog organizations. Therefore, they exploit the state funds or a system of balance of power within the government or a free press for their personal gain. They also exploit organized crime in exchange for protection or for providing valuable information to them. Thus, societies with weak institutions, patronage systems, and inability of the government to enforce laws and regulations provide a fruitful environment for PCNs to grow. This type of political system is unstable and vulnerable to popular protest or coup d’états. Therefore, the state tends to cooperate with organized crime to maintain ‘their preferred order’ in the society. These states

¹⁴ Menace to Society, 8–17.

¹⁵ Davaadulam.Ts, “Glossary of Concepts and Terms in Governance”, (Ulaanbaatar, 2010), 19.

⁹ Ibid.

¹⁰ Ibid.

¹¹ Menace to Society, 6.

¹² National Strategy Information Center, “The Political-Criminal Nexus,” 4.



are likely to be both criminal in nature as well as embedded in a strong PCN.

A state in transition is particularly vulnerable to PCN. “Contemporary states in both economic and political transitions appear to be particularly susceptible to the development of PCN”¹⁶. Godson emphasizes that an “Economic and political transitions create uncertainty regarding what norms of behavior are acceptable, and provide an extremely favorable environment for former and current state officials to work with criminal opportunists”¹⁷. The control is neither secured by the former system or the emerging new regime.

This occurred in Soviet Union and its former republics due to an institutional void during the regime change from communism to democracy. Ineffective government policies; incompatible political system; and a lack of watchdog organizations in these weak states have further caused culture conducive to endemic corruption, thereby strengthening PCN.

The following *cultural factors* tend to play a significant role in the PCN. Individuals both criminal and non-criminal tend to be obedient to groups which can provide them security, solutions to economic and personal needs, and to conflicts. This promotes patron-client relations and makes politics *personalistic*. Moreover, strong cultural and family tradition contributes to personalistic politics too.

Patron-Client relationships are common in former colonies of Latin America. During the

colonization period in Latin America, the Portuguese colonizers established a strong patronage relationship with the local elites. The colonizers enforced and maintained their control through their patronage relationships with local elites. These elites enjoyed special privilege and were granted a unique access to scarce resources. Thus, a tradition of patron-client relationships became part of the culture of Latin American former colony states.

A popular public perception of corruption being acceptable and normal contributes to development of PCN. Corruption and crime share a symbiotic relationship. They depend on one another's existence. The professional criminals are extremely skilled opportunists capable of taking advantage of every opportunity to skirt around the law to achieve their goals. In the process, they benefit from crony and corrupt political establishments. When corruption is embedded in everyday life of the society, corrupt practices become accepted by the public as ‘normal’. Then, people fail to distinguish between what is acceptable and what is not. Further, it results in blurring of what is criminal and what is honorable.

A society accepting criminals as national heroes makes criminals and their corrupt practices legitimate. Criminals tend to fill the institutional void where government is unable to reach or to provide welfare and protection to the locals. Thereby, criminals tend to be worshiped like heroes. Pablo Escobar of the Colombian Medellin cartel known as ‘The Godfather of Cocaine’ was respected by people like a ‘folk hero’ or ‘a Robin hood’¹⁸. He built residential houses,

schools, church in slums where people lacked assistance from the state. Even after his death, people kept bringing flowers to his grave and dedicated songs to him. These songs are still sung by locals.

In such societies, young people tend to worship the ‘wealthy’. For them the source of wealth, and methods used to create it are unimportant. They look toward professional organized crime groups as providers of employment, opportunity and protection. This situation has a negative implication on the overall governability of the country because criminals can impact political decisions or even get elected in political-elect posts. Consequently, a parallel government of professional criminals is established along with the formal government. Strange refers to this phenomenon as ‘a retreat of state’¹⁹. It means that the official state's legitimacy is undermined by another governing forces, in this case the professional organized criminals.

The preceding vital factor to development of PCN is the *Economic Factor*. In general, criminals are businessmen who conduct their business by *other means*. Consequently, like any other business activity their businesses are dependent on the *Supply and Demand* dynamics of the market. “The demand for illegal goods and services and the effort to supply the demand can contribute in a significant way to the creation of organized crime, and hence facilitates creation of

¹⁶ National Strategy Information Center, “The Political-Criminal Nexus,” 8.

¹⁷ Menace to Society, 11.

¹⁸ PBS Frontline - Godfather of Cocaine -

Pablo Escobar - Part 1/4, 2011, http://www.youtube.com/watch?v=gVXSekpHvYM&feature=youtube_gdata_player.

¹⁹ Susan Strange, *The Retreat of The State: The Diffusion of Power in the World Economy*, Cambridge Studies in International Relations 49 (New York: Cambridge University Press, 1996), 110–121.



PCNs²⁰. The organized crime tends to gain more power than the state. As a result, they are able to practice control over and influence the economy of the country. For example, ill-designed privatization of the state controlled industries and firms have reinforced the PCN and the criminalization of the state in Soviet Union. "...in mid-1993, there were 40,000 enterprises controlled or established by organized criminal organizations in Russia²¹. This resulted in undermining the state authority; endemic corruption; and the criminalization of state institutions in Russia.

"In all societies, the political-criminal nexus is harmful because this coalition places its financial interests above those of the citizenry or the long-term objectives of the state²². High proceeds of the criminals enable them to 'buy people in power' in a corrupt manner. In the process, they become immune from the justice system and expand their control. It has adverse impacts on the society including on the public confidence in the official government. Thereby, undermines the overall legitimacy of the government. The privatization occurred more rapidly in Russia than any other former-soviet republics. After five years since the inception of privatization, the Russian government controlled less than 20 percent of the state economy²³. Thereby, the new government's effectiveness was largely undermined from inception.

Moreover, National Security Information Center's in-depth

research on PCN revealed that efficiency of services provided to the legitimate economic actors by criminal organizations and their collaborators could be conducive to the growth of a PCN²⁴. "Criminal bankers often provide speed, simplicity, and confidentiality that surpass the services offered by legitimate banks, even for legitimate activities, let alone tax evasion and money laundering²⁵. Thereby, factors related to the structural errors and/or lengthy regulatory processes promote criminal activities like corruption. Consequently, licit and illicit activities could merge in the most high-risk areas like campaign financing, elections, banking, real estate, cargo and shipping, small and medium entrepreneurship, and so on. Then, knowing the right people and having a good relationship with them becomes extremely important. They establish different kinds of PCNs depending on the nature of the issue and the benefits to the parties.

The parties involved in PCN have varying degrees of benefits from the collaboration. The criminal groups usually establish a relationship with local and national level political authorities to mitigate risks. Criminals are primarily interested in profit-maximization, but could be motivated to achieve social respect and to eliminate their social rivals too. In turn, politicians could have other motivations than personal-enrichment. Identifying motivation of political actors other than personal enrichment has a policy implication to it. If politicians are cooperating with criminal groups to secure their campaign financing,

a possible policy remedy could be a campaign finance reform.

Conclusion

The political, economic and cultural circumstances-conducive to PCN differ based on the unique conditions in given countries. Diverse environments form PCNs specific to its conditions. Countries or societies even experience different forms of organized crime due to its 'unique conditions'. Consequently, it is central to consider the history, social norms, common values and mindsets of the public in order to understand politics and crime, thus PCN.

Some literature on the PCN suggests that these coalitions tend to exist in many countries, however it is crucial to emphasize that during civil unrest or war criminals could be used as an important source of intelligence or strategic information to the state. But it is fundamentally different than making a public policy favorable to the criminal world-as in the case of the PCN.

The power relations between these two groups (state and the criminal world), with different roles, are fundamental to defining the ultimate outcome of this coalition. The state can accomplish its decisive goal, responsibility to achieve public well-being or long-term favorable conditions to the people only through maintaining its dominance in the relationship even during the times when it is challenged to avoid the collaboration with the criminal world. In the process, political, economic, and social culture play a vital role in these circumstances. Because the state ought to maintain its legitimacy in all three areas in order to be viewed as

²⁰ Menace to Society, 15.

²¹ Svetlana P. Glinkina, "Privatizatsiya and Kriminalizatsiya: How Organized Crime Is Hijacking Privatization," *Demokratizatsiya: Journal of Post-Soviet Democratization* 2 (1994), 388.

²² Menace to Society, chap. 7 Page 199.

²³ Menace to Society, chap. 7 Page 201.

²⁴ National Strategy Information Center, "The Political-Criminal Nexus," 10-12.

²⁵ Ibid., 10.



legitimate state by its people. The implications related to structural issues and ineffective public policy contribute to corruption and other crimes making the criminals more conducive toward achieving greater power. Therefore, effective implementation of an accurate public policy is not only extremely important to prevent the occurrence of the PCN, but also critical to prevent criminals from achieving greater influence in the areas of economy and social culture, thus in the political arena.

Bibliography

Annelise Anderson, "Causes of the Political Criminal Nexus,"

2012/12/15 нэвтэрсэн, <http://andrsn.stanford.edu/Other/pcn.html>.

Menace to Society: Political-Criminal Collaboration around the World (New Brunswick, N.J: Transaction Publishers, 2003)

National Strategy Information Center, "The Political-Criminal Nexus," Trends in Organized Crime 5, no. 2 (December 1, 1999).

PBS Frontline - Godfather of Cocaine - Pablo Escobar, 2011, http://www.youtube.com/watch?v=gVXSekpHvYM&feature=youtu.be_gdata_player.

Susan Strange, The Retreat of

The State: The Diffusion of Power in the World Economy, Cambridge Studies in International Relations 49 (New York: Cambridge University Press, 1996).

Svetlana P. Glinkina, "Privatizatsiya and Kriminalizatsiya: How Organized Crime Is Hijacking Privatization," Demokratizatsiya: Journal of Post-Soviet Democratization 2 (1994), 385-394.

Ц.Даваадулам, "Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг" (Улаанбаатар, 2010).



ОБЪЕКТЫН СУДАЛГАА ЯВУУЛАХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭС,
ТҮҮНИЙГ БҮРДҮҮЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

Г.Бямбадорж

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн

Цагдаагийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, докторант



Товч агуулга: Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, түүнчлэн нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын гол цөм болох цагдаагийн байгууллагын объектын судалгаа, түүнийг явуулах эрх зүйн үндэс, объектын судалгааг сайжруулах, түүнд түшиглэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх арга, туршлагын талаар энэхүү нийтлэлд дурдав.

Хүний нийгэм, үүссэн үеэс гэмт явдлын улмаас үүсэх хор аюултай нүүр тулж, тэмцэж ирсэн. Хүн төрөлхтөн гэмт явдлыг зөвхөн хатуу чанга ял шийтгэлийн хүчээр хориглон зогсоох боломжгүйг ухаарч, энэхүү нийгмийн сөрөг үзэгдлээс урьдчилан сэргийлэхэд ихээхэн ач холбогдол өгөх болсон.¹

Цагдаагийн байгууллага хуулиар хүлээсэн үүргээ

¹ Г.Даштүдэв. “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй”. УБ. 2007. 123 дахь тал

биелүүлэх нөхцөл нь хариуцсан нутаг дэвсгэрт өөрчлөгдөж буй нөхцөл байдлыг мэдэрч үнэлэх, өдөр тутмын ажлаа төлөвлөж, цагаа үр ашигтай зарцуулах, үйл ажиллагаандаа тохиромжтой тактикийг сонгож хэрэглэх, нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх ажлын сайн туршлагыг нэвтрүүлэх, шинжлэх ухаан, техникийн ололтыг өргөнөөр нэвтрүүлж ашиглах, үр ашигтай хамтран ажиллахад оршдог.

Цагдаагийн байгууллагын үе үеийн ажилтнууд хариуцсан нутаг дэвсгэрийнхээ объектын судалгааг гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглаж ирсэн уламжлалтай.

Цагдаагийн байгууллагын түүхэн хөгжлийн явцад объектын судалгаанд тулгуурлан гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах бодлого, эрх зүйн үндсийг тавигджээ. Тухайлбал, 1916 оны “Нийслэлийн хүрээний тойрон газруудыг цагдан сэргийлэх дүрэм”-д “Аливаа цагдан сэргийлэгчид өөр өөрийн эрхэлсэн газрын доторх аливаа хүний тус тусын аж ахуйн үйлдвэр явдал ямар болох, нэр, зан суртал, байдал дүрсийг нарийвчлан мэдэж бай”. “Бас ч харъяа газрын дотроо орон хаашаа нэмэх, хасах, шилжсн нүүх, гадаад дотоодын олон

хүний орох, гарах, оршин суух зэрэг элдэв учрыг ухан сэмхэнээр тагнан мэдэж, харъяат албаны газраа мэдүүлэх” гэж заажээ.

Ардын хувьсгалын эхэн үе буюу 1921-1940 он, Социализм байгуулахаар замнасан үе буюу 1940-1990 оны Цагдан сэргийлэх байгууллагын дүрмүүд, үйл ажиллагаатай холбоотой заавруудад хариуцсан нутаг дэвсгэрийнхээ объектын судалгааг хийж, гэмт хэрэг илрүүлэх ажиллагаанд ашиглах талаар тодорхой зааж, нийгмийн харилцааны явцад улам баяжуулан хөгжүүлж ирсэн бөгөөд тухайн үед “Онц сэргийлэгчдийн улсын зөвлөгөөн”, “Тэргүүний алба, ажилтнуудын туршлага солилцох уулзалт” зэрэг сургалт хүмүүжлийн төрөл бүрийн ажлуудыг зохион байгуулахдаа объектын судалгааг ашиглаж, гэмт хэрэг илрүүлсэн тэргүүний хэсгийн байцаагч, төлөөлөгчдийн арга туршлагыг бусдад сурталчилдаг байжээ.

Тухайн үед тавигдаж байсан шаардлагын дагуу хэсгийн төлөөлөгч, байцаагч, хорооны цагдаа нар нь гучин долоон нэр төрлийн судалгаа, бүртгэлийг иж бүрэн хийж, ашиглаж байжээ.

1970 онд ЗХУ болон социалист бусад орны цагдан



сэргийлэх байгууллагын туршлагаас суралцах, ЗХУ-ын ДЯЯ-ны тогтмол хэвлэлийг ашиглах зорилгоор хэвлэл мэдээллийн групп байгуулж ажиллах, тэдгээр улсын туршлагыг орчуулж социалист орнуудын хэвлэмэл тойм гэсэн бичмэл эмхтгэл гаргах зэрэг арга хэмжээнүүд авсан нь эрүүгийн хэрэг эрэн сурвалжлах албаны ажилтнуудын ур чадвар нэмэгдэх, гэмт хэрэг илрүүлэх, ялангуяа илрээгүй хэргийг нөхөн илрүүлэхэд эерэгээр нөлөөлж байжээ.

Аливаа түүх, уламжлал өнгөрсөн үйл явдлын практик үйлдэл бүхэн ихээхэн үнэ цэнэтэй туршлага байдаг учраас өмнөх үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны сургамж, туршлагыг өвлөн авч ашиглах, залуу ажилтнуудад эзэмшүүлэх шаардлага улам бүр нэмэгдэж байна.

Цагдаагийн байгууллага гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлыг эрт дээр үеэс төрөл бүрийн арга, хэлбэрээр явуулж ирсэн бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэхэд тухайн газар нутгийн онцлог, хүн амын тоо, гэмт явдлын шинж, чанар, гэмт хэргийн гаралт, төрөл, ангилал, гэмт хэрэг үйлдэгч зэргийг нарийн судлан мэдэж байсан нь гэмт хэрэгтэй тэмцэх нөхцлийг бүрдүүлж байв.

Цагдаагийн байгууллагаас объектын судалгаа явуулж сум, баг, хорооныхоо иргэдийн ахуй амьдрал, гэмт явдлын гаралт, шинж байдал, гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй сэжигтэй этгээдүүд, тэдний явуулж буй үйл ажиллагааг нягтлан тандан судалж, судалгааны мөрөөр төрөл бүрийн арга хэмжээг зохион явуулж, үр дүнг тооцож, дүн

шинжилгээ хийж ажилласнаар цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээг иргэдэд ойртуулж, тэдэнд баталгаатай үйлчилгээ үзүүлэхийн сацуу гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажиллагаанд эерэг үр дүнд хүрэх нөхцөл бүрдэнэ.

Объектын судалгаа явуулах эрх зүйн үндсийг 2013 онд шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хуульд шууд зааж өгөөгүй боловч объектын судалгаа явуулах эрх зүйн үндэс нь Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргээс урган гарч байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлд **“Цагдаагийн судалгааны төв”-ийг ажиллуулах талаар шинээр хуульчилж өгсөн бөгөөд уг хуулийн 16.1.1-т “Цагдаагийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх стандарт, дүрэм, журам, зааврыг боловсронгуй болгох, энэ зорилгоор хууль сахиулах үйл ажиллагаатай холбоотой сан бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх”** гэж заасан нь цагдаагийн байгууллагаас хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлэхэд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, эрэн сурвалжлагдаж байгаа хүн, мал амьтан, эд зүйлийг эрэн сурвалжлах зэрэг өдөр тутмын ажил үйлчилгээг иргэдэд үзүүлэхэд цагдаагийн байгууллагын объектын судалгаанд түшиглэх нь ойлгомжтой.

Мөн Цагдаагийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1-т **“Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээж авах, бүртгэх, олзлох, цуглуулах, олж**

авмагц таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авах, гэмт хэргийг илрүүлэх”, 9.2.2-т **“Гэмт хэрэг, зөрчил гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэрэг, зөрчлийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлохбаримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах”** гэж заасан ба энэ үүргийг хэрэгжүүлэхэд объектын болон субъектын судалгаа хийхгүйгээр гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл олж авах, цуглуулах, олж авмагц таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ, гэмт этгээдийг олж тогтоох боломжгүй. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг, зөрчлийг үйлдэж болзошгүй сэжигтэй этгээд хаана амьдардаг, хэн болох, хань харилцаа, үйлдлийн арга, онцлогийн талаар сэжиг таамаглалтай байхын тулд объектын судалгааг заавал хийх шаардлагатай.

Харин тэрхүү объектын болон субъектын судалгаа нь цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд ашиглаж болохуйц мэдээ, мэдээлэл агуулсан байх ёстой.

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9.1.3 дахь хэсэгт **“Цагдаагийн байгууллага нь далд аргаар үйлдэгдсэн эсхүл тодорхой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох түүнийг үйлдсэн гэмт этгээдийг олж тогтоох, түүнчлэн сураггүй алга болсон оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан болон нас барсанд тооцогдсон хүн, прокурор, шүүхээс даалгасан бусад хүнийг эрэн сурвалжлах,**



алдагдсан галт зэвсэг, сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодис, түүх соёлын дурсгалт болон бусад үнэт зүйлсийг эрж олох”² гэж заасан нь цагдаагийн байгууллагаас төрөл бүрийн объектынболон субъектын судалгаа явуулах эрх зүйн үндэс болсон гэж үзэж байна.

Түүнчлэн, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хэсгийн байцаагч, төлөөлөгчийн ажлын заавар, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, Хэсгийн байцаагч, төлөөлөгч, цагдаа нарыг орчны байдлаа судлан мэдэх, тухайн нутаг дэвсгэрт үнэлэлт өгөх, объектын судалгаа хийх талаар заавар журмыг баталсан байдаг. Тухайлбал, ЦЕГ-ын даргын 2009 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 613 дугаар тушаалаар баталсан ЦБҮАЖ-ийн код-702 цагдаагийн байгууллагын туслах тоо бүртгэлийн зааврыг дурдаж болно.

Дээрх зааварын 702.6.4-д “Объектын судалгааг Судалгаа-хяналтын мэдээллийн сан” гэж нэрлэж, уг субъектын 21 төрлийн, объектын 24 төрлийн бүртгэл, судалгааг хамруулжээ.

Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд боловсруулагдаж буй Хууль сахиулах ажиллагааны тухай хуулийн төсөлд объектын судалгаа явуулах эрх зүйн үндсийг зааж өгснийг дэмжиж байна. Хуулийн төслийн 2.14-д “*Эрх бүхий албан тушаалтан хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд тодорхой нутаг дэвсгэр, олон нийтийн газарт эрүүгийн ба хэв журмын нөхцөл байдлыг судлах, гэмт хэргийн талаарх мэдээлэл цуглуулах зорилгоор биечилсэн судалгааг*

халхавчтай болон халхавчгүй хийж болно”³ гэж заасан нь цагдаагийн байгууллагын объектын судалгааны нэг төрөл болох “Хариуцсан нутаг дэвсгэрийн гэмт хэрэг, зөрчлийн судалгаа”, “Эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэргийн судалгаа”, “Гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй хүмүүсийн судалгаа”, “Эрэн сурвалжлагдаж буй этгээдийн судалгаа” зэрэг судалгаа явуулах эрх зүйн үндсийг бэхжүүлэх заалт болжээ.

Цагдаагийн байгууллагаас хариуцсан нутаг дэвсгэрийнхээ объектын судалгааг бүрдүүлэхдээ оршин суугч иргэд хүн амыг судлахад гол анхаарлаа хандуулснаар иргэдтэй ажил хэрэгч сайн харилцааг тогтоож тэдний дэмжлэг тусалцааг авах нөхцлийг бүрдүүлнэ.

Цагдаагийн хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч нь субъектын судалгааг явуулахдаа гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээд хаана амьдарч байгаа, урьд өмнө нь гэмт хэрэг зөрчил үйлдэж байсан эсэх, ял эдлэж байсан эсэх, ял тэнссэн, хорихоос өөр төрлийн ял шийтгэл эдэлж байсан эсэх, хорихоос суллагдсан зан төлвийн хувьд тогтворгүй хүмүүсийг судлан мэдэж цаг тухайд нь бүртгэл судалгаандаа авч хүн амын талаар бүх талын мэдээлэлтэй болох нь гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж завдаж байгаа үйлдлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Цагдаагийн хэсгийн байцаагч, төлөөлөгч нь хариуцсан нутаг дэвсгэрт байгаа объектын байршил түүний хажуу талын объектын байршил хоорондын зай уг объекттой

холбогдох шугам, хоолой, хонгил байдаг эсэх, хэрэв байдаг бол уг хонгил хоолой нь хэдэн метр үргэлжилдэг, гэмт халдлага нэвтрэн орох боломжтой эмзэг цэг нь хаана ямар ямар байрлалтай хэдэн цонх хаалга, шал, хана, тааз, дээвэр байдаг эсэх шал, хана, тааз дээвэр, тагт, хоолой шугам нь ямар материалаар хийгдсэн, түүний өргөн урт, зузаан, нимгэн байдлыг тусгаснаар объектод халдсан гэмт хэргийг илрүүлэх болон цагдаагийн байгууллагын бусад зохион байгуулалтын ажилд ихээхэн тустай.

Түүнчлэн, уг объектруу хүрч очих, хэдэн гол болон туслах, нуугдмал зам байгааг судлан мэдэж, объектын судалгаандаа тусган уг замыг хаана ямар хүч хэрэгслээр бүслэн хаах ямар боломж байгааг судлах шаардлагатай. Ингэснээр гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажил явуулахдаа иргэдийн дундаас хэнийг түшиглэх хэний зүгээс хэрэг, зөрчил гаргаж болзошгүй түүнд хэрхэн хяналт тавих тухай асуудлыг нарийвчлан төлөвлөж боловсруулах ач хологдолтой.

Цагдаагийн албан хаагч объектын судалгааг тогтмол баяжуулах, ажил хэрэгчээр ашиглах явдал хангалтгүй байна. Цагдаагийн алба хаагчид түүний дотор хэсгийн байцаагч, төлөөлөгч нар нь объектын судалгаа түүнд хийсэн дүгнэлтийн үндсэн дээр гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэхэд чиглэгдсэн ажлыг зохион байгуулах бөгөөд эдгээр арга хэмжээг дэс дараатай, төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлж илүү үр дүнтэй ажиллахыг цаг үе шаардаж байна.

² Гүйцэтгэх ажлын тухай хууль

³ Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн төсөл 2015 он



Хариуцсан нутаг дэвсгэртээ үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэхэд цагдаагийн байгууллагын объектын судалгааг хэрхэн ашиглах вэ? гэдэг нь маш чухал асуудлын нэг юм.

Цагдаагийн байгууллагын анхаарлыг зүй ёсоор татаж болохобъект түүний дотор гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй этгээдүүд, тухайн нутаг дэвсгэрт байдаг гэмт хэргийн бүлэглэл, тэдгээр бүлэгт хэдэн хүн байдаг, тэдгээрийн үйл ажиллагааны чиглэл, гэмт үйлдлийн арга зэргийг судлан мэдэж ямар хүрээнд, ямар ажил, арга хэмжээ зохиохыг төлөвлөж үйл ажиллагааныхаа хүрээг тодорхойлохын зэрэгцээ тухайн хариуцсан нутаг дэвсгэрийн гэмт явдлын хэтийн төлөв байдлыг гаргах шаардлагатай.

Цагдаагийн байгууллагын объектын судалгааны нэг төрөл болох хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгаанд онцгой анхаарал хандуулж, тухайн нутаг дэвсгэрт

үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил түүний шалтгаан, нөхцөл үйлдэгдээд гэмт этгээд нь тогтоогдоогүй хэргийн ангилал, төрөл, тоо зэргийг нарийвчлан судалж, гэмт хэрэг, зөрчил хаана, хэзээ, ямар нөхцөлд ямар аргаар, хэн үйлдсэн байж болох зэргийг тодорхойлсны үр дүнд урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээнүүдийг угтуулан зохион байгуулах нөхцөл бүрдэнэ.


Хөрөнгө мөнгө ихээр төвлөрсөн албан байгууллага, аж ахуй нэгж, иргэд гэмт этгээдүүдийн анхаарлын төвд орж, гэмт халдлагад өртөх тохиолдол цөөнгүй байдаг. Иймд нутаг дэвсгэртээ байгаа онцлог объект гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээд тэдний хань харилцаа түр оршин суугч явуулын хүмүүсийн үйл ажиллагаа хөдөлгөөнд нь анхаарлаа төвлөрүүлж, объектын судалгаанд онцгой анхаарч ажиллах нь зүйтэй.

Үйлдэгдсэн гэмт хэргийг урьд өмнө нь гэмт хэрэгт холбогдож байсан, ял эдэлж байсан, зан байдлын хувьд тогтворгүй

этгээдүүд, бүлэг бөөгнөрөл, сэжиг бүхий байдлаар аж төрдөг сэжигтэй этгээдүүдтэй холбон авч үзэж үйлдлийн арга, цаг хугацаа, байнга хэрэглэгддэг үг хэллэг, биеийн онцлог, содон шинж тэмдэг, өмссөн хувцас зэрэг содон шинж тэмдгээр нь харьцуулан гэмт хэрэг илрүүлэхэд ашиглах шаардлагатай. Тухайлбал, гэмт хэрэг үйлдэгсдийн дийлэнх нь гэмт хэргийн замаар олж авсан эд зүйлсээ даруй нь зарж борлуулдаг учраас хямд үнээр эд зүйл авдаг иргэн, хуулийн этгээд, барьцаалан зээлдүүлэх газар, түүхий эд болон бусад эд зүйл авдаг ченжүүдийн бүртгэл судалгаанаас түүвэрчлэн авч хэргийг илрүүлэхэд ашиглаж болно.

Хариуцсан нутаг дэвсгэрийнхээ талаар нарийн судалж мэдэхгүйгээр гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа амжилтад хүрэхгүй гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.



ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ**УГОЛОВНАЯ ОТВЕТСТВЕННОСТЬ ЗА УКЛОНЕНИЕ
ОТ УПЛАТЫ НАЛОГОВ В ЗАКОНОДАТЕЛЬНОМ РЯДЕ
ЗАРУБЕЖНЫХ СТРАН***Лапишин Валерий Фёдорович**начальник кафедры уголовного права Академии
ФСИН России кандидат юридических наук, доцент*

Аннотация: в работе осуществлён сопоставительный анализ положений уголовного законодательства России и некоторых зарубежных государств в части регламентации ответственности за уклонение от уплаты налогов. Приведены высказанные в научной литературе мнения об учёте зарубежного опыта описания признаков налогового преступления при конструировании соответствующих норм российского уголовного закона, а также сформулирована авторская позиция в вопросе необходимости внесения изменений и дополнений в отечественное законодательство об уголовной ответственности за уклонение от уплаты налогов.

Ключевые слова: налоговое преступление, уголовная ответственность, зарубежное уголовное законодательство,

фелония, мисдиминор.

Действующий российский Уголовный кодекс (далее – УК) предусматривает относительно небольшое количество норм об уголовной ответственности за уклонение от уплаты налогов и иных обязательных платежей, перечисляемых в бюджеты различных уровней и во внебюджетные фонды. К таковым относятся уклонение от уплаты налогов и (или) сборов с физического лица (ст. 198), аналогичные деяния, совершённые от имени организации (ст. 199) и налогового агента (ст. 199¹), сокрытие денежных средств и иного имущества, за счёт которых должно производиться взыскание налогов и (или) сборов (ст. 199²), а также уклонение от уплаты таможенных платежей, взимаемых с организации или физического лица (ст. 194). Несомненным достоинством отечественного законодательства об ответственности за налоговые преступления (равно как и за любые другие уголовно-наказуемые деяния) является их систематизация в рамках единого нормативного акта – Уголовного закона. Общей особенностью правового содержания, практически,

всех налоговых преступлений, предусмотренных нормами УК, является их отнесение к материальным составам. Вне зависимости от степени завершенности действий злоумышленника и периода времени их совершения, преступление признаётся оконченным только с момента наступления общественно опасного последствия – непоступления в бюджет (внебюджетный фонд) соответствующей суммы налога, сбора или иного обязательного платежа. В свою очередь российское правосудие не приветствует практику привлечения к уголовной ответственности за неоконченные налоговые преступления¹, что нельзя признать недостатком общего государственной уголовной политики, особенно в свете положений Концепции модернизации уголовного законодательства в экономической сфере².

¹ См.: Уголовная ответственность за уклонение от уплаты налогов с организации по российскому Уголовному кодексу // URL: http://www.vneshtorg.ru/content/document_r_0C0E268D-BFB9-4C76-AC72-BF5B2630408D.html (дата обращения: 03.08.2014).

² Более подробно см.: Концепция модернизации уголовного законодательства в экономической сфере.



В законодательстве зарубежных стран с развитой рыночной экономикой и отработанными правовыми механизмами противодействия налоговой преступности подобное упорядочение уголовно-правовых норм отсутствует. К примеру, кодифицированное уголовное законодательство Германии предусматривает только одну норму о преступлении, которое достаточно условно можно отнести к разновидности налогового: «Нарушение обязанности ведения бухгалтерских книг (§283b УК ФРГ)»³. Иные нормы об ответственности за совершение налогового преступления содержатся в иных нормативных актах ФРГ, действующими независимо от УК Германии. Так, §370 Налогового устава ФРГ предусматривает уголовную ответственность за уклонение от уплаты налогов, если это деяние повлекло за собой умаление налогов или достижение налоговых выгод. В отличие от российского УК по уголовному законодательству Германии преступление образуют только активные действия, направленные на введение в заблуждение государственных фискальных органов относительно

М., 2010. 196 с.

³ Мнение об отнесении преступления к разновидности налоговых высказано А.С. Грибовым. Более подробно см.: Основные проблемы реформирования уголовно-правовых норм об экономических преступлениях и практики их применения на современном этапе развития России: Монография / Отв. ред. Л.Л. Кругликов. Ярославль, 2012. С. 281. Фактически же указанная норма включена в состав группы посягательств, совершаемых в сфере криминального банкротства. Диспозиции частей § 283b УК ФРГ указывают на стремление преступника скрыть своё истинное имущественное положение от кредиторов.

истинной суммы налогов, подлежащих перечислению в бюджет. Неуплата налогов, которой предшествовало правильное декларирование налогооблагаемой базы, полное исчисление сумм налогов, своевременное представление достоверной бухгалтерской документации и т.п., рассматривается только в качестве административного (налогового) правонарушения⁴. Что же касается перечисленных последствий, то они представляют собой:

– умаление налогов, выражающееся в полной неуплате, несвоевременной уплате всей суммы налоговых обязательств или её части;

– н е п р а в о м е р н о е получение налоговой выгоды, которая может представлять собой получение налоговых льгот, возмещений, отсрочку или рассрочку уплаты начисленных сумм налогов и т.п.

Иными словами, к последствиям активной обманной (преступной) неуплаты налоговых платежей немецким законодательством отнесено получение налогоплательщиком любой прямой или опосредованной выгоды за счёт налоговой экономии. Несомненным достоинством законодательства Германии о преступлениях в сфере налогообложения является то, что оно не разграничивает преступления в зависимости от вида налога, от уплаты которого уклоняется злоумышленник. Преступные неуплаты прямых или косвенных налогов, а равно таможенной пошлины и иных

⁴ Аналогичные действия относятся к разновидности общественно опасных деяний, предусмотренных ст.198-1991 УК.

платежей влекут за собой одни и те же правовые последствия. Как представляется, подобная законодательная регламентация в большей степени отвечает правилам законодательной техники о лаконичности и компактности нормативных предписаний⁵.

В США привлечение к уголовной ответственности лиц, совершающих уклонение от уплаты налогов и иных обязательных платежей, крайне затруднено по причине сложности, казуистичности формулирования правовых предписаний, а равно отсутствием иерархии нормативных актов по их юридической силе. На данную особенность американского законодательства обращали внимание многие российские исследователи⁶. В тоже время в соответствии с государственной уголовной политикой Соединённых Штатов налоговое преступление обладает значительной общественной опасностью, поскольку более половины доходной части федерального бюджета формируется за счёт налогов и иных обязательных платежей⁷.

Налоговые преступления, как и любые иные преступления, предусмотренные уголовным законодательством США,

⁵ См.: Царев А.Ю. О правилах законодательной техники, используемых при написании текста закона // Представительная власть – XXI век: законодательство, комментарии, проблемы. 2002. №5-6. С. 29-33.

⁶ См., например: Кузнецов А.П. Ответственность за налоговые деликты по законодательству США // Финансовое право. 2005. №6. С. 47; Никифоров Б.С., Решетников Ф.Н. Современное американское уголовное право. М., 1990; Шумилов В.М. Правовая система США. М., 2006; и др.

⁷ См.: Никифоров Б.С., Решетников Ф.Н. Указ. соч. С. 178.



подразделяются на тяжкие (felony) и менее тяжкие (misdemeanor)⁸. Определение тяжести совершённого деяния осуществляется аналогично приёму, используемому в законодательстве ФРГ: менее тяжким преступлением признаётся простая «безобманная» неуплата налогов и иных обязательных платежей. Данный вид уголовно-наказуемого деяния имеет место, если налогоплательщик надлежащим образом произвёл исчисление сумм платежей и отразил достоверные сведения в документах бухгалтерской отчётности. Аналогичным образом оценивается деяние работника, который, преследуя цель избежать в полном объёме или частично налогообложения своих доходов, сообщает работодателю (налоговому агенту) недостоверные сведения о праве на налоговые льготы, отсутствии объекта налогообложения и проч. Думается, что подобное снисхождение в вопросе определения незначительной общественной опасности обманных действий работника-налогоплательщика вызвано наличием обязанности работодателя осуществлять надлежащую проверку налоговых сведений, предоставляемых работником. Кроме этого, законодательство США не только не исключает, но и поощряет субсидиарную ответственность корпорации за преступные действия её работников⁹. Поэтому в

⁸ См.: Уголовное право США: понятие преступления и наказания // URL: <http://www.bibliotekar.ru/ugolovnoe-pravo-4/298.htm> (дата обращения: 20.08.2014).

⁹ См.: Додонов В. Ответственность юридических лиц в современном уголовном праве // Законность. 2006. №4.

подобных случаях существует возможность привлечения к ответственности и работодателя, который ненадлежащим образом исполняет обязанности налогового агента.

В свою очередь активные действия лица, направленные на уклонение от обязанности уплатить налоги в бюджетную систему, отнесены к категории фелоний. Американский законодатель не придаёт большого значения способу совершения активного уклонения от уплаты налогов. Таковыми могут являться: сокрытие средств от налогообложения, предоставление искажённой информации в документах бухгалтерской отчётности, совершение мошеннических действий и проч. По общему правилу способ совершения деяния не имеет принципиального юридического значения для квалификации содеянного. Что же касается размера санкций за совершённую налоговую фелонию, то в случае систематического совершения данного деяния лицу может быть назначено наказание вплоть до пожизненного лишения свободы¹⁰.

Специфическая строгость американского уголовно-правового противодействия налоговой преступности подтверждается и тем, что законодатель не дифференцирует ответственность за оконченное и неоконченное налоговое преступление. Так, в §7201 С. 39.

¹⁰ См.: Налоговый портал: «ПодатиНет»: В США за уклонение от уплаты налогов привлекают к суровой ответственности // URL: <http://www.podatinet.net/2012040424749/nalogovye-istorii/istoriya-i-teoriya-nalogov/v-ssha-za-uklonenie-ot-uplaty-nalogov-privlekeyut-k-surovoi-otvetstvennosti.html> (дата обращения: 21.08.2014).

раздела 26 Свода законов США предусматривается уголовная ответственность за стремление каким бы то ни было способом совершить уклонение от уплаты налогов. В данном случае попытка уклонения от налогов и иных обязательных платежей признаётся самостоятельным составом преступления, причём относящимся к категории фелоний¹¹. В этой связи можно констатировать факт весьма сурового реагирования государства и на попытки совершения, и на реальное совершение налогового преступления.

Таким образом, проведённый краткий анализ уголовного законодательства ФРГ и США в части ответственности за уклонение от уплаты налогов свидетельствует о наличии следующих отличительных особенностей, не присущих отечественному уголовному законодательству:

- нормы об уголовной ответственности предусматриваются как кодифицированными и уголовными законами, так и законами иных отраслей системы государственного права;
- активное и пассивное уклонение от уплаты налогов представляют различные по степени общественной опасности деяния. В отдельных случаях «безобманное» уклонение от уплаты налогов не выходит за пределы

¹¹ См.: Основные проблемы реформирования уголовно-правовых норм об экономических преступлениях и практики их применения на современном этапе развития России. С. 306-307.



- | | | |
|--|---|--|
| <p>административного деликта;</p> <p>– не признаётся основанием для дифференциации уголовной ответственности ни статус налогоплательщика, ни вид налога или иного обязательного платежа, сумма которого преступным путём не была перечислена в бюджет;</p> <p>– совершение налогового преступления во всех случаях характеризуется умышленной формой вины. Неуплата обязательных платежей по неосторожности предполагает наступление гражданско-правовой и административной ответственности;</p> <p>– американский вариант уголовно-правового противодействия налоговой преступности предусматривает</p> | <p>наступление уголовной ответственности как за оконченное преступление на подготовительных стадиях уклонения от уплаты налогов. В этой связи уголовный закон США предусматривает значительное количество составов преступлений, сконструированных по типу формальных и усечённых.</p> <p>Что же касается возможности применения изученного зарубежного опыта законодательной регламентации противодействия налоговой преступности в отечественном УК, то наиболее перспективным видится отказ от осуществлённого разграничения налоговых преступлений от правового статуса налогоплательщика: физическое лицо (ст. 198 УК) и организация (ст. 199 УК), – а также от вида обязательного платежа: налог, сбор (ст. 198, 199, 199.1 УК) и</p> | <p>таможенный платёж (ст. 194 УК).</p> <p>В свою очередь, формулирование составов налоговых преступлений по типу формальных и усечённых не является обоснованным ни с научной, ни с практической точек зрения. Общественная опасность налогового преступления связывается, в первую очередь, с непоступлением денежных средств в соответствующий бюджет или государственный внебюджетный фонд. Отсюда следует, что все действия, совершаемые в целях уклонения от уплаты налогов и (или) сборов, не могут признаваться самостоятельными преступлениями по причине недостаточной общественной опасности и нецелесообразности привлечения значительного количества граждан к уголовной ответственности в условиях отсутствия реального ущерба, причинённого государственной казне.</p> |
|--|---|--|



**ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ,
ПРАКТИКИЙН АСУУДАЛ****НОТЛОХ БАРИМТЫН ШИНЖ ЧАНАР: ХАМААРАЛТАЙ
БАЙДАЛ, БОЛОХУЙЦ БАЙДАЛ, БАТТАЙ БАЙДАЛ***Докторант Д.Мөрөн*

байдлын талаарх мэдээллийн агуулгыг тэмдэглэдэг.

Нотлох баримтын хамааралтай байдал гэдэг бол нотолгооны агуулга болон нотолбол зохих нөхцөл байдлын хоорондын холбоо юм. Дараах тохиолдолд нотлох баримтыг хамааралтай гэж үзнэ:

Нэгдүгээрт, түүний тусламжтайгаар нотолгооны зүйлд хамаарах аль нэг нөхцөл байдлыг тогтоож байгаа бол. Эрүүгийн хэрэгт гэмт хэрэг гарсан байдал, гэмт хэргийг хэн үйлдсэн, гэмт хэргийн сэдэлт, гэм буруугийн хэлбэр, яллагдагч, шүүгдэгчийн хувийн байдал, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл зэргийг нотолбол зохино/ЭБШХ-ийн 80 дугаар зүйл/. Тэгэхээр дурдсан нөхцөл байдлыг тогтооход шаарлагатай мэдээлэл тодорхой эрүүгийн хэрэгт хамааралтай байх нь ойлгомжтой. Жишээлбэл, хохирогч мэдүүлэгтээ 2 цагийн дараа гэртээ иргэж ирэхэд хаалгыг нь эвдэж, нийт 10 сая төгрөгийн үнэ бүхий алтан эдлэл, бэлэн мөнгө хулгайлсан тухай дурджээ. Уг мэдээллээр гэмт хэрэг үйлдсэн газар, цаг хугацаа, үйлдлийн арга, учирсан хохирлын төрөл, хэмжээг мөрдөн байцаагч тогтоосон байна /ЭБШХ-ийн 80.1.1, 80.1.5/.

Хоёрдугаарт, туслах чанарын /завсрын/ баримтыг тогтоож буй нотлох баримтыг хамааралтай гэж үзнэ.

Эдгээр нь нотолгооны зүйлд шууд хамаарахгүй боловч зарим төрлийн хэрэгт хууль зүйн учир холбогдолтой учраас судалж буй үйл явдалтай дам холбоотой байж болно. Тиймээс ийм баримтыг нотолбол зохих нөхцөл байдалтай уяж чадаж гэмээн болж өнгөрсөн үйл явлын зураглалыг сэргээн, яллагдагчийн гэм буруу болон бусад нөхцөл байдлыг тогтоох боломжтой болно. Жишээлбэл, хэргийн газрын үзлэгээр малгай олдсон бөгөөд түүнийг гэмт хэрэгтэн улайран тэмцэлдэх үедээ унагасан гэсэн таамаглал дэвшүүлжээ. Малгайн эзнийг тогтоох нь мэдээж хэрэг бусад хэрэгт нотлох шаардлагагүй баримт боловч тухайн тохиолдолд хэн нэгэн тодорхой хүн уг хэрэгт холбогдолтой эсэхийг тогтооход ач холбогдолтой.

Гуравдугаарт, эрүүгийн хэрэгт нэгэнт цугларсан мэдээллийг шалгахад хэрэгтэй нотлох баримтыг хамааралтай гэж үзнэ. Тухайлбал, 8 давхарын тагтан дээрээс 80-100 метрийн зайнаас 3 хүүхэд автомашинаас цүнхтэй зүйл хэрхэн хулгайлахыг харсан, нэгийн нь харвал таньж чадна хэмээн нэгэн гэрч мэдүүлжээ.

Мэдээллийг эрүүгийн хэргийн нотлох баримт болгон ашиглахад тэр нь эрх зүйн тодорхой шинж чанартай, өөрөөр хэлбэл, хамааралтай, болохуйц, баталгаатай байх шалгуурыг хангасан байвал зохино.

Эрүүгийн хэргийн аливаа нотлох баримт хамааралтай байдал, болохуйц байдал, баттай байдал гэсэн хууль зүйн цогц шинж чанартай байх шаардлагатай. Эдгээр нөхцлийн аль нэг хангагдаагүй бол нотлох баримт нотолгооны хэрэгсэл болж чадахгүй.

Эрүүгийн процессын онолд хамааралтай байдал, болохуйц байдлыг нэг бол нотлох баримтын шинж чанар, эс бөгөөс нотлох баримтын шинж тэмдэг хэмээн авч үздэг. Бидний ойлголтоор, “нотлох баримтын шинж чанар” нь түүний эрх зүйн гадаад учир холбогдлыг илүүтэй илэрхийлдэг бол “нотлох баримтын шинж тэмдэг” нотлох баримтын дотоод байдал, өөрөөр хэлбэл хуульд заасан эх сурвалжаас олж авсан, эрүүгийн хэрэгт нотолбол зохих нөхцөл



Ийм зайнаас тодорхой хүнийг гэрч таньж чадах эсэхэд мөрдөн байцаагч эргэлсэн бол тэрээр мөрдөн байцаалтын туршилт явуулах эрхтэй. Эрүүгийн хэргийн материалыг шалгахад чиглэсэн мөрдөн байцаах бусад ажиллагаанд нүүрэлдүүлэн байцаах, мэдүүлгийг газар дээр нь шалгах, шинжилгээ томилож, хийлгэх зэрэг хамаарна.

Дөрөвдүгээрт, өөр бусад нотлох баримт болон процессын эх сурвалжийг тогтооход хэрэгтэй нотлох баримтыг мөн хамааралтай гэж үзнэ. Жишээлбэл, зам тээврийн осол хэрхэн гарсаныг найзтайгаа хамт харсан хэмээн гэрч мэдүүлсэн гэж бодъё. Уг тохиолдолд хэрэгт шинэ эх сурвалж тогтоогдон, найзыг нь байцаах үед олж авсан мэдээлэл бие даасан нотлох баримт болно.

Тавдугаарт, аль нэг нөхцөл байдлыг тогтоож буй мэдээлэл буюу эерэг нотлох баримт хамааралтай байхаас гадна ийм нөхцөл байдлыг үгүйсгэсэн мэдээлэл буюу сөрөг нотлох баримтыг хамаарал бүхий хэмээн үзнэ.

Нотлох баримтын хамаарлыг тодорхойлоход энэхүү журмыг баримтална. Хэрэгт хамааралгүй мэдээллийг хэрхэх вэ? –гэсэн асуулт гарч ирэх нь дамжиггүй. Ерөнхий дүрмийн дагуу тэдгээрийг эрүүгийн хэрэгт үлдээнэ. Ингэснээр гэмт хэрэг гарсан нөхцөл байдлыг тал бүрээс нь, бүрэн дүүрэн, бодитой шалгасан, олон таамаглал дэвшүүлэн шалгасан боловч гагцхүү нэг нь л батлагдсан болохыг харагдуулна. Харин тухайн хэрэгт хамааралгүй нотлох баримт нь өөр бусад хүмүүсийн үйлдсэн гэмт хэргийг нотолж байгаа бол материалыг

тусгаарлан, эрүүгийн хэрэг үүсгэх эсэхийг ердийн журмаар шийдвэрлэх бөгөөд тусгаарласан материалын хуулбарыг эрүүгийн хэрэгт үлдээвэл зохино.

Болохуйц байдал гэж нотлох баримтыг эх сурвалж болон олж авч, бэхжүүлэх процессын журмын хувьд ашиглаж болох шинж чанарыг хэлнэ.

Нотлох баримтын хамааралтай байдал нь түүний нотолгооны зүйлийг бүрдүүлж буй баримттай холбогдох байдлыг харуулдаг бол нотлох баримтын болохуйц байдал нь түүний хууль ёсны эх сурвалж, мэдээллийг олж авч, бэхжүүлэх аргатай холбоотой. Хэд хэдэн шаардлага хангасан нөхцөлд нотлох баримтын болохуйц байдлыг хүлээн зөвшөөрдөг.

Нэгдүгээрт, ЭБШХ-ийн 79.2-т заасан эх сурвалжаас олж авсан бол нотлох баримтыг ашиглаж болно. Эдгээрт гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, эд мөрийн баримт, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны тэмдэглэл болон бусад баримт хамаарна. Уг жагсаалтыг бүрэн гүйцэд гэж үзэх боловч ЭБШХ-ийн 79.3-т гүйцэтгэх ажлын үр дүнг нотлох баримтын эх сурвалж байж болохоор хуульчилжээ.

Хууль тогтоогч аль нэгэн эх сурвалжид чухам ямар нотлох баримт байж болох тухай асуудлыг зохицуулаагүй. Зарчмын хувьд процессын эх сурвалжийн алинд ч янз бүрийн нотлох баримт агуулагдаж байж болно. Гэхдээ зарим нөхцөл байдлыг тодорхой эх сурвалжаар тогтоохыг хуулиар үүрэг болгосон байдаг. Тухайлбал, ЭБШХ-ийн 156 дугаар зүйлд хүн

нас барсан шалтгаан, гэмтлийн зэргийг тогтоох, сэтгэцийн байдлыг тодорхойлох зэрэгт шинжилгээ заавал хийлгэхээр хуульчилсан. Тэгэхээр дурдсан нөхцөл байдлын тухай мэдээллийг олж авах эх сурвалж нь зөвхөн шинжээчийн дүгнэлт байна.

Хоёрдугаарт, эрүүгийн хэргийн талаар мөрдөн байцаалт, шүүх ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтан нотлох баримт цуглуулах, шинжлэн судлах, үнэлэх, ашиглах ажиллагааг хэрэгжүүлнэ.

Тодорхой хэргийн нотлох баримтыг тухайн хэргийг хариуцаж буй албан тушаалтан /мөрдөн байцаагч, прокурор, шүүгч/ цуглуулдаг. Хэрэв мөрдөн байцаах ажиллагааг өөр газарт явуулах бол мөрдөн байцаагч ЭБШХ-ийн 398, 399 дүгээр зүйлд заасны дагуу байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай даалгавар өгнө. Ийм замаар цуглуулсан нотлох баримтыг болохуйц гэж тооцно.

Өмгөөлөгч бие даан нотлох баримт цуглуулах эрхтэй бөгөөд тухайн хэрэгт сонирхол бүхий бусад этгээд эрүүгийн хавтаст хэрэгт авахуулахаар баримт бичиг, эд зүйл цуглуулан, хүлээлгэн өгч болно.

Гуравдугаарт, процессын аргаар цуглуулсан нотлох баримтыг болохуйц гэж үзнэ. ЭБШХ-ийн 79.1-д зааснаар нотлох баримт цуглуулах арга нь мөрдөн байцаах болон процессын ажиллагаа байна. Уг хуулиар зохицуулаагүй аргаар олж авсан мэдээллийг болохуйц гэж үзэхгүй.

Дөрөвдүгээрт, нотлох баримт цуглуулах процессын журам баримталсан бол нотлох баримтыг болохуйц хэмээн



ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

тооцдог.

Нотлох баримт цуглуулах хамгийн их түгээмэл арга нь мөрдөн байцаах ажиллагаа бөгөөд ажиллагаа бүрийн журмыг ЭБШХ-иар тогтоосон байдаг бөгөөд түүнийг чанд баримтлах нь нотлох баримтын болохуйц байдлын үндсэн нөхцөлийн нэг мөн.

Нотлох баримт олж авах процессын бусад аргын хувьд эрх зүйн нарийн зохицуулалт байхгүй. Хуульд зааснаар эд зүйл, баримт бичиг болон бусад мэдээллийг гаргуулан авах, тайлбар авах, магадлагаа, тодорхойлолт болон бусад

баримт бичиг шаардаж авах, баримтын шалгалт хийлгэх замаар нотлох баримт олж авах боломжтой.

Тавдугаарт, нотлох баримт бүрийг процессын хувьд бүрдүүлсэн байвал зохино.


Нотлох баримтын баттай байдал гэдэг нь эрүүгийн хэрэгт нотолбол зохих нөхцөл байдалтай холбоо бүхий мэдээллийн үнэн, худал аль болохын шалгуур үзүүлэлт мөн.

Эрүүгийн процессын онолын хувьд нотлох баримт баттай, аль эсвэл баттай бус байдаг.

Баттай нотлох баримт гэдэгт агуулгын хувьд бодит ертөнцөд болж өнгөрсөн баримттай

нийцсэн мэдээлэл хамаарна.

Худал мэдээллийг яллах ажиллагааны үндэс болгож болохгүй бөгөөд хэргийн нөхцөл байдлыг тогтооход ашиглахгүй. Уг тохиолдолд худал мэдээллийг нотлох баримтад тооцно. Учир нь түүнийг хуульд заасан эх сурвалжаас, хуульд заасан аргаар эрх мэдэл бүхий албан тушаалтан зохих ёсоор бүрдүүлсэн байдаг. Харин мэдээллийн үнэн, худал болохыг тогтоох нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, өмгөөлөгч, шүүхийн зорилт болно.





ГЭМТ ЭТГЭЭДИЙГ ШИЛЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

Ц.Шийтэрчулуун

*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Мөрдөн
ажиллагааны онол, тактикийн тэнхимийн
багш, цагдаагийн хошууч*



Аливаа улс өөрийн эрүүгийн хэрэг шүүн шийдвэрлэх журмыг хил залгаа болон бусад улсын нутаг дэвсгэрт хэрэглэхийг феодалын нийгмийн үед олон улсын заншил, олон улсын гэрээгээр хориглож байв. Энэ үед суугаа улсын нутаг дэвсгэрт эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн дипломат төлөөлөгчид эрүүгийн хариуцлага оногдуулахгүй байх, тэдэнд дархан эрх ямба эдлүүлэх олон улсын заншлын хэм хэмжээ бүрэлдэн тогтжээ.

Өнөө үед гэмт этгээдийг шилжүүлэн өгөх ойлголтын агуулга ч өөрчлөгдсөн. Энэ нь улс төрийн үзэл бодлынхоо улмаас эрүүгийн хэрэгт мөрдөгдөж буй хүмүүсийг буцааж өгөхгүй байх агуулгатай орогнох эрхийг хуульчилсантай холбоотой бөгөөд төрийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдийг буцаан шилжүүлэхээ больжээ. Тухайлбал, Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай Монгол улс, БНСУ хоорондын гэрээний 3 дугаар зүйлийн 1-д “Хүсэлт хүлээн авагч Тал шилжүүлэн

өгөхийг хүссэн гэмт хэргийг улс төрийн гэмт хэрэг, эсхүл улс төрийн гэмт хэрэгт холбогдолтой гэмт хэрэг хэмээн тодорхойлсон бол шилжүүлэн өгөхгүй. Гэхдээ дараах гэмт хэргийг улс төрийн гэмт хэрэгт хамааруулахгүй. Үүнд:

- Төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүн, эсхүл тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн амь насанд халдсан, эсхүл халдахаар завдсан бол,
- Төрлөөр устгах болон бусдыг барьцаанд авах тухай олон улсын олон талт гэрээ, хэлэлцээрт хоёр Тал хоёулаа нэгдэн орсноор ийм гэмт хэргийг шүүх, эсхүл шилжүүлэн өгөх үүрэг хүлээсэн бол” гэж заасан.

Хөрөнгөтний ардчилсан хувьсгалыг дагалдан үндэсний эрүүгийн эрх зүй идэвхтэй хөгжиж, эрүүгийн эрх зүйн ерөнхий ангийн институтууд, гэмт хэргийн төрлүүд улс бүрт ижил байсан учраас эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх талаар харилцан тохиролцоход хялбар байсан. Далайн дээрэм, боолын худалдаа, хуурамч мөнгөн тэмдэгт үйлдэх, мансууруулах бодис худалдаалах, тээвэрлэх болон хэд хэдэн улсын ашиг сонирхол хөндсөн бусад гэмт

хэргүүд үйлдэгдэх болсны улмаас улс орнууд зайлшгүй хамтран ажиллах шаардлагатай болж нотлох баримт цуглуулах, гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх зэргээр эрх зүйн туслалцаа үзүүлэхийн тулд үндэсний эрүүгийн эрх зүй дэх гэмт хэргийг ангилах шалгууруудыг ойртуулан жигдрүүлэх шаардлага гарчээ.

Нөгөө талаас олон улсын эрүүгийн эрх зүй дэх гэмт хэргийн гурван ангилалд тохирох эрх зүйн зохицуулалтыг улс орон бүр өөрийн дотоодын хууль тогтоомждоо тусган оруулах замаар уг асуудлыг шийдвэрлэх боломжтой. Энэ талаар Их Британи, Итали, Герман болон эрх зүйт төрт бусад орны Үндсэн хуульд заасны дагуу хувь хүний эрүүгийн хариуцлагын тухай олон улсын гэрээний хэм хэмжээг гагцхүү үндэсний хууль тогтоомжид шилжүүлэн тусгаж, зохих журмаар хэвлэлд нийтлүүлсний дараа практикт хэрэглэдэг байна. ОХУ-д олон улсын гэрээг соёрхон баталж, албан ёсны хэвлэлд нийтэлсний дараа шүүх түүний хэм хэмжээг хэрэглэж болдог. Манай улсын хувьд Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3-т “Нэгдэн орсон олон улсын гэрээний хэм хэмжээ нь Монгол улсын нутаг дэвсгэр дээр дотоодын хууль тогтоомжийн



ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

адил үйлчилнэ” гэж заасан. Эндээс үзэхэд, шүүх түүний хэм хэмжээг шууд хэрэглэж болохоор байна.¹

2004 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр батлагдсан Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын дүрмийг шүүх шууд хэрэглэх боломж байгаа эсэхийг тодруулъя. Улсын Их Хурлаас баталсан Ромын дүрмийг соёрхон батлах тухай Монгол улсын хуульд **“Монгол улс 2000 оны 12 дугаар сарын 29-ний өдөр гарын үсэг зурсан Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын дүрмийг Засгийн Газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.”** гэж заасан байдаг ба Төрийн мэдээлэл эмхтгэлд энэхүү хууль нийтлэгдэж, Ромын дүрэм нийтлэгдээгүй Засгийн газарт үлдсэн.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар уг дүрэм нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хүчинтэй болсон боловч практикт хэрэглэх боломжгүй. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 3-т **“...албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй”**, мөн 1993 оны Олон улсын гэрээний тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1-д **“Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан олон улсын гэрээг нийтлэхдээ Монгол Улсын хууль нийтлэх журам баримтална”**, түүнчлэн, Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 26.6, 26.8-д **“Улсын Их Хурлын шийдвэрт өөрөөр заагаагүй бол уг шийдвэр албан ёсоор нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болно. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхдээ “Төрийн**

мэдээлэл” эмхтгэлд нийтэлсэн албан ёсны эхийг баримтлах бөгөөд ингээгүй дамжуулан нийтэлснийг албан бус гэж үзнэ” гэж заасан.

2005 оны 1 дүгээр сараас “Төрийн мэдээлэл” эмхтгэлд Монгол Улсын олон улсын гэрээнүүдийн монгол хэл дээрх хөрвүүлгийг албан ёсны болгох зорилгоор нөхөн хэвлэж эхэлсэн нь сайшаалтай байна.

Зарим нэг гэрээнүүдийн хувьд бусад хууль тогтоомжтой зөрчилдөх асуудал үүсч байна. Тухайлбал, Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын дүрэмд Монгол Улсын Эрүүгийн хууль, цаашилбал, Үндсэн хуультай харшлах зүйл, заалт тусгагдсан байдаг. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Эрүүгийн хуульд **“Монгол улсын иргэнийг гадаад улсад шилжүүлж өгөхгүй”**, Ромын дүрэмд **“...хүсэлт тавьсан бол өөрийн улсын иргэнийг шилжүүлэн өгөх үүрэгтэй”** гэсэн агуулгаар заажээ.

Дээрх зөрчилдөөнийг зарим хуульч эрдэмтэн, судлаачид тайлбарлахдаа:

- Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын дүрэм нь Олон улсын гэрээ биш, тиймээс хүчин чадлын хувьд бага учраас заавал дагаж мөрдөх шаардлагагүй,
- Олон Улсын Эрүүгийн шүүх нь улс биш байгууллага учраас өөрийн улсын иргэнийг шилжүүлэн өгсөн тохиолдолд Үндсэн хуультай зөрчилдөхгүй,
- Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын дүрмийг зөвхөн тухайн төрлийн харилцааг зохицуулсан

хэм хэмжээ байхгүй тохиолдолд нөхөлт маягаар хэрэглэх учир ямар нэг асуудал төдийлөн гарахгүй,

- Монгол Улсын Үндсэн хуулийн 10.4-т зааснаар **“Үндсэн хуульд харшилсан Олон Улсын гэрээ”** болох учир дагаж мөрдөхгүй зэрэг үндэслэл муутай тайлбар өгдөг.

Олон Улсын гэрээнд тайлбартайгаар нэгдэн орох, тайлбар хийх гэсэн ойлголт байдаг. Энэ талаар Олон улсын гэрээний тухай хуулийн 17.1-д **“Олон талт гэрээнд нэгдэн ороход тайлбар мэдэгдэл хийх шаардлагатай бол уг гэрээнд гарын үсэг зурах, түүнийг соёрхон батлан нэгдэн орох буюу батлах тухай Монгол улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрт энэ тухай заалт оруулна”** гэсэн байдаг бол ихэнх олон улсын гэрээ, дүрмүүдэд тайлбар хийж нэгдэн орох эсхүл тайлбар хийх хязгаарыг өөртөө тогтоож өгсөн байдаг. Тухайлбал, Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын дүрмийн 124 дүгээр зүйлд **“12 дугаар зүйлийн 1 дэх заалтаас үл хамааран аливаа улс энэхүү дүрмийн оролцогч тал болохдоо гэмт хэргийг өөрийнх нь иргэн буюу түүний нутаг дэвсгэр дээр үйлдсэн гэж үзэж байгаа 8 дугаар зүйлд² дурдсан гэмт хэргийн төрлийн хувьд энэхүү дүрэм тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 7 жилийн хугацаанд тэрээр шүүхээс хэрэг шүүн шийдвэрлэхийг хүлээн зөвшөөрөхгүй тухайгаа зарлаж болно.”**

Дээрх зөрчилдөөнийг шийдвэрлэж, Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын

¹ Д.Мөнхтуяа. Олон улсын эрүүгийн эрх зүйн зарим асуудал. УБ., 2000. 16 дахь тал

² Цэргийн гэмт хэрэг



дүрмийг соёрхон баталж, улмаар практикт хэрэглэснээр манай улсад дараах ач холбогдолтой. Үүнд:

- Дүрэмд зааснаар гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектын нас 18, Монгол Улсын Эрүүгийн хуульд зааснаар 16 нас тул субъектын насыг нэмэгдүүлэх,
- Дүрэмд зааснаар ялын хамгийн хүнд хэлбэр нь бүх насаархорих, Монгол Улсад цаазаар авах ял байдаг тул энэхүү ялаас татгалзах,
- Монгол Улсын Үндсэн хуульд заасан “Хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзнэ” хэмээн зарлан тунхагласан нь биелэлээ олох,
- Дэлхийн орнуудаас “Монгол Улс энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг хүндэтгэн дээдэлдэг” гэсэн эерэг үнэлэлт авах,
- Цөмийн зэвсэг бүхий 2 их гүрний хооронд оршдог хөгжиж буй улсын ашиг сонирхол хамгаалагдах эрх зүйн орчин бүрдэх,
- Олон улсын байгууллагууд, Европын холбооны гишүүн улсуудын дэмжлэг туслалцаа, авах зэрэг болно.

Монгол Улсын Эрүүгийн хууль, Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээнүүдэд харьяалалгүй хүнийг хүсэлт гаргасан тохиолдолд хүсэлт хүлээн авагч тал шилжүүлэн өгөх тухай зохицуулалт байдаг.

Монгол Улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суугаа аль ч улсын харьяат биш хүмүүсийн эрх ашгийг хангах асуудалд онцгой анхаарах ёстой. Үүний тулд хэдийгээр Монгол улс нэгдэн орж, Монгол Улсын олон улсын гэрээ болгоогүй ч НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталж, 1975 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон “Аль ч улсын харьяат биш байхыг цөөлөх тухай конвенц”-ийн заалтыг харгалзан үзэх нь НҮБ-ын гишүүн орны хувьд ихээхэн учир холбогдолтой.

Харьяалалгүй хүнд Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг эдлүүлэхдээ Монгол Улсын Олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлалт тогтоож болохыг Монгол Улсын Үндсэн хуулийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заажээ.

Олон Улсын Эрүүгийн эрх зүйд гэмт этгээдийг шилжүүлэхгүй байгаа улсад нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх тогтолцоо байдаг. Тухайлбал, шүүхийн түгээмэл харьяалал:

- Нутаг дэвсгэрт нь гэмт хэрэг үйлдсэн тэр улсын шүүхээр гэмт этгээдийг шүүх,
- Тодорхой гэмт хэргийн шүүн таслах эрх мэдэл бүхий эрүүгийн шүүх байгуулж, гэмт этгээдийг шүүх хэлбэрээр хэрэгждэг.

2 дахь хэлбэр нь олон улсыг хамарсан дайн, зэвсэгт мөргөлдөөний дараа цэргийн гэмт хэрэгтнүүдийг шүүх зорилготой бөгөөд сөрөг тал нь ял шийтгэлийг халдаан хэрэглэх,

эсхүл хуулийг буцаан хэрэглэх зэрэг үзэгдэл дагалддаг.

Эхний хэлбэр нь илүү үр дүнг бий болгодог “Төрлөөр устгах (геноцид) гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм хэрэг үйлдэгчдийг шийтгэн цээрлүүлэх тухай”³ 1948 оны конвенцид тусган оруулжээ.

Эндээс үзэхэд, Монгол Улсад байнга оршин суудаг харьяалалгүй хүн, Монгол Улсын иргэн байсан боловч гэмт хэрэг үйлдэх үедээ харьяалалаа алдсан байсан этгээдүүдийг гадаад улсад шилжүүлэн өгөх нь тийм ч зохимжтой зүйл биш бөгөөд энэрэнгүй ёсны зарчмыг үндэслэн одоогийн зохицуулалтыг өөрчлөх нь зүйтэй болов уу.

Улс хооронд гэмт этгээдийг шилжүүлэн өгсний дараа уг этгээдтэй холбогдсон нэгэн зохицуулалт бий. Монгол улсын хоёр талт гэрээнүүдэд үүнийг шилжүүлэн өгсөн этгээдийг мөрдөх хязгаар, шилжүүлэн өгсөн этгээдийг хэрэгт холбогдуулах хязгаар, шилжүүлэн өгсөн этгээдийг байцаан шийтгэх хязгаар зэргээр нэрлэн тусгадаг. Утга нь “Шаардлага хүлээн авсан хэлэлцэн тохирогч этгээдийн зөвшөөрөлгүйгээр шилжүүлж өгсөн этгээдийг шилжүүлэн өгөхдөө холбоогүй бөгөөд шилжүүлж өгөхөөс өмнө үйлдсэн хэргийн учир эрүүгийн хариуцлагад татах, шийтгэх буюу 3 дахь улсад дамжуулан шилжүүлж болохгүй”⁴ тухай юм.

Аливаа эрх зүйн хэм хэмжээнд тодорхой байх, тогтвортой байх гэсэн хоёр үндсэн шалгуур байдаг бөгөөд тогтвортой байх нь тодорхой

³ Монгол Улс 1969 онд соёрхон баталсан.

⁴ БНМАУ, БНУАУ-ын гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ. 1968. 65 дугаар зүйл.



ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

байхаасаа шууд хамааралтайгаар оршдог. Тодорхой байх гэдэг нь:

- Ямар нэг урьдач шалтгаантай байх,
- Үүнээсээ үүдсэн зорилготой байх,
- Тухайн харилцаагаа бүрэн тусгасан байх,
- Хэрэгжих боломжтой байх,
- Зөрчсөн тохиолдолд хэрэглэх санкцтай байх,
- Тэр нь хэрэгжих механизмтай байх зэрэг хамаарч болно.

Дээрх зохицуулалтын хувьд авч үзвэл:

- Урьдач шалтгаан нь хүлээлгэн өгсөн улсыг нь мэдээгүй байхад түүнд ямар нэгэн ял оногдуулах бололцоо олгогдох магадлал,
- Зорилго нь үүнээс болж шилжүүлэн өгсөн этгээд эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо эдэлж чадахгүйд хүрэхээс урьдчилан сэргийлэх, хамгаалах,
- Хамрах хүрээ өөрөөр хэлбэл, зохицуулах харилцаа нь хангалттай тусгагдаж өгсөн гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл, өөр хэрэгт хариуцлагад татах, 3 дахь улсад шилжүүлэн өгөхийг тодорхой тохиолдолд хориглосон.
- Цаг хугацаа хөрөнгө мөнгөний асуудлыг шийдэж чадвал хэрэгжих боломжтой гэж үзэж болно.
- Гэмт этгээдийг хүлээн авсан улс хүлээлгэн өгсөн талд мэдэгдэлгүй уг этгээдийг өөр гэмт хэрэгт сэжиглэн эрүүгийн

байцаан шийтгэх ажиллагаа явуулан тэр нь нотлогдвол эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн тохиолдолд 2 улсын хооронд үл ойлголцох байдал бий болж нэг нь нөгөөгөө Олон Улсын Эрүүгийн Шүүхэд өгөх үү, эсвэл хүлээлгэн өгсөн талд мэдэгдсэн тохиолдолд татгалзлаа гэж бодъё. Энэ татгалзал нь тухайн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болох уу.

Эндээс үзэхэд, “шилжүүлэн өгсөн этгээдийг мөрдөх хязгаар” нь шалтгаан, нөхцөл, зорилго нь үндэслэл муутай, тухайлбал, өөрийн улсын иргэнээ шилжүүлэн авч эрүүгийн хэрэгт сэжиглэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж байгаа бол тухайн улсын дотоодын хэрэг болно гэсэн үг, хэрэгжих боломж тааруу, зөрчигдвөл хамгаалагдах механизм байхгүй, Олон улсын эрх зүйн зарим нэг зарчимд харш, харин ч хүний эрх, эрх чөлөөг зөрчих магадлалыг өндөрсгөх зохицуулалт болжээ. Тухайлбал,

- Олон улсын эрх зүйн улсын бүрэн эрхийн зарчим, дотоод хэрэгт үл оролцох зарчим, гэмт этгээд үйлдсэн буруутай үйлдэлдээ эрүүгийн хариуцлага гарцаагүй хүлээх зарчим зэргийг зөрчинө гэж үзэх үндэстэй.
- Шилжүүлэн өгөхөөс өмнө үйлдсэн хэргийн учир эрүүгийн хариуцлагад татах тухай хүлээлгэн өгсөн улсад мэдэгдэж

хариу авах тэр хугацааны туршид цагдан хоригдох магадлал маш өндөр, нөгөөтэйгүүр дотоодын хууль тогтоомжид заасан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах хугацаа алдах болно.

Монгол Улсын эрх зүйн туслалцаа үзүүлэх болон эрх зүйн харилцааны тухай гэрээнүүдэд тусгагдсан гэмт этгээдийг шилжүүлэн өгөхөөс татгалзах үндэслэлүүд нь тодорхой зарчимд тулгуурлаагүй, нийтлэг биш юм шиг санагддаг.

Хэдийгээр улс орон болгоны баримталдаг, даган мөрддөг эрх зүйн хэм хэмжээнүүд, үзэл баримтлал өөр өөр байдаг ч гэмт хэргийн хувьд ижил шаардлага зүй ёсоор тавигдах ёстой.

Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын дүрэмд цэргийн гэмт хэргийг тусган оруулж, онцлон авч үзэн уг гэмт хэргийг үйлдсэн этгээдийг шилжүүлэн авч ял шийтгэл оногдуулах тухай зохицуулсан байдаг. Уг дүрмийн 8 дугаар зүйлийн 1-д “Шүүх нь цэргийн гэмт хэргийн хувьд тухайлбал, тэдгээрийн төлөвлөгөө буюу бодлогын хүрээнд эсхүл тийм гэмт хэргийг өргөн хэмжээгээр үндсэн тохиолдолд шүүн шийдвэрлэх эрх хэмжээтэй байна. Олон улсын эрх зүйгээр тогтсон олон улсын зэвсэгт мөргөлдөөнд хэрэглэх хууль болон зан заншлыг өөрөөр ноцтой зөрчсөн, ялангуяа дараах үйлдлийн аль нэг нь цэргийн гэмт хэрэг болох тухай дурджээ.

- Дайны ажиллагаанд шууд оролцдоггүй энгийн хүн ам буюу энгийн тодорхой хүмүүст санаатайгаар халдан довтлох,



- Иргэний байгууламж өөрөөр хэлбэл, цэргийн зориулалтгүй байгууламжид санаатайгаар халдан довтлох,
- Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх буюу НҮБ-ын дүрмийн дагуу энхийг сахиулахад оролцож байгаа ажилтан, байгууламж, материал, нэгж буюу тээврийн хэрэгсэлд тэдгээрийг зэвсэгт мөргөлдөөний эрх зүйн дагуу энгийн хүмүүс буюу иргэний байгууламжийн эдэлж байгаа хамгаалалтын эрхтэй байхад нь санаатайгаар шууд цохилт өгөх
- Тухайн халдан довтлох явдал нь энгийн хүмүүс амь насаа тохиолдлоор алдах буюу гэмтэлд өртөх, эсхүл иргэний байгууламжид хохирол учруулах, цэргийн тодорхой болон шууд тооцон хүлээж байгаа ердийн давуу байдалтай жиших аргагүй өргөн, урт хугацааны болон ноцтой хохирлыг хүрээлэн байгаа орчинд учруулахыг мэдсээр байж санаатайгаар халдан довтлох,
- Хамгаалалтгүй болон цэргийн зориулалтгүй хот, тосгон, орон сууц буюу барилга байгууламжид халдан довтлох, эсхүл ямар ч хэрэгслээр хамаагүй тэдгээрийг бөмбөгдөх,
- Зэвсгээ хураалгаж, цаашид хамгаалалтын хэрэгсэлгүй болон үг дуугүйбууж өгсөн цэргүүдийг алах буюу шархдуулах,
- Цэргийн командлалаас дайсны талтай хэлэлцээ хийх бүрэн эрх бүхий элчийн туг болон үндэсний далбаа, дайсагнагч талын буюу НҮБ-ын цэргийн ялгах тэмдэг болон дүрэмт хувцас, түүнчлэн Женевийн конвенциудаар тогтоосон ялгах тэмдгийг буруугаар ашигласнаар хүмүүс амь насаа алдах буюу тэдгээрийн биед ноцтой гэмгэл учруулахад хүргэх,
- Эзэлсэн улс өөрийн энгийн хүн амыг шууд буюу тойруу замаар өөрийн эзэлсэн нутаг дэвсгэрт шилжүүлэх, эсхүл эзлэгдсэн нутаг дэвсгэрийн хүн амыг бүхэлд нь буюу зарим хэсгийг энэ нутаг дэвсгэрийн хилийн дотор буюу хилийн чанадад албадан гаргах буюу шилжүүлэх зэрэг болно.



КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ, АРГА ЗҮЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ**ГЭМТ ХЭРГИЙГ ИЛРҮҮЛЭХЭД КРИМИНАЛИСТИКИЙН
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА***Б.Жаргалсайхан**Хууль сахиулахын их сургуулийн докторант*

Гэмт хэргийг илрүүлэх, мөрдөх ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй явуулах, түүнд криминалистикийг ашиглах шаардлагатай хэдий ч манай практикт цэгцтэй ашигладаггүй, урсгалаар явуулдаг дутагдал бий. Энэхүү нийтлэлээр гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх ажиллагаанд криминалистикийг ашиглах хэрэгцээ, шаардлагын талаар авч үзнэ.

Гэмт хэргийн түүхийг судлан үзэхүйд аль ч улсад, хүний нийгэм хөгжихийн хирээр үйлдвэрлэл-үйлчилгээг хэрэглэгчид ойртуулахын тулд төвлөрүүлэх шаардлага гардгийг даган хотжих болж, бүх хүн бие биеэ таньдаг, ах захаасаа эмээдэг хөдөөнөөс цугласан хүмүүс бие биеэ үл таних болж, хот газарт төвлөрсний дараагийн үеэс гэмт явдлын гаралт нэмэгдэж, түүнтэй тэмцэх шаардлага бий болсон.

Гэмт хэргийг илрүүлэхдээ хохирсон буюу тэр орчимд явж байсан зэрэг хүний харсан, үзсэнд түшиглэн их

төлөв шийдвэрлэдэг байжээ. Нийгмийн ухамсар харьцангуй цэвэр байсан тэр цагт хүн хийсэн гэмт үйлдээ өөрөө гэмшин, хэргээ голдуу хүлээдэг байсан бол яваандаа тэр нь үгүй болж үйлдсэн хэргээ хүлээхгүй, худал мэдүүлэх, тэр ч байтугай бусдыг гүтгэх болсон зэрэг нь гэмт хэргийг илрүүлэхэд шинжлэх ухаанч аргыг эрэлхийлэх хэрэгцээг бий болгосон.

Гэмт хэргийг илрүүлэх урлаг гэж нийтээр нэрлэж байсан криминалистикийг гэмт хэргийг мөрдөхөд хэрэглэхийн чухлыг дэлхийн олон улс нэлээд эртнээс мэдэж байсан боловч чухам юуг, хэрхэн ашиглах эвээ олохгүй байсан тул гэмт хэрэгтэй тэмцэхдээ шинжлэх ухааны мэдлэгийг огт ашиглахгүй, зөвхөн гэрч, хохирогчийн мэдүүлгээр хэргийг шүүж байсан үе түүхэнд бий.

Гэмт этгээдийг тогтоохоор эртний Хятадад гэмт хэрэг үйлдсэн гэж сэрдэж байгаа хүнд хуурай тутрага зажлуулаад зажилсанхивдсийг нулимуулах¹, Энэтхэгт гэмт хэрэгт сэжиглэж буй хүнд гэмт хэргийн дэлгэрэнгүйтэй холбоотой, холбоогүй үг хэлэх тоолонд нөгөө хүн анх санаанд орж ирсэн үгээ хэлж, үүнтэй нэгэн

зэргээр харанга зөөлөн цохих”², Орос ба дундад зууны Европод гал, усаар тамлах, нүцгэн гараар улайссан төмөр атгуулах буюу буцламгай ус руу гараа дүрж дотор нь буй бөгжийг гаргуулах зэрэг аргыг хэрэглэж гэмт этгээд гэж тогтоосон хүнийг хашраахаар нүдэнд ил газарт тамгалах, хурууг тайрах зэргээр зэрэмдэглэх мэтийн аргаар бусдад гэмт хэрэгтэн болохыг таниулан сэрэмжлүүлдэг байв.

Дэлхийн анхны эрүүгийн цагдаагийн байгууллага- “Сюртэ”-г 1810 онд Парист байгуулсны дараа бүхэл бүтэн 20 жил гэмт хэргийг хамгийн “сайн мэддэг”, өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдэж байсан хүмүүсийг цагдаад авч ажиллуулж байсан гашуун түүх бас буй. Харин 1884 оноос хүн судлалын хэмжил зүйг Францын цагдаад А.Бертильон эхлэн хэрэглэснээр шинжлэх ухаанч криминалистик системтэй үүсэх эхлэл болж, улмаар 1900-гаад оноос гарын мөрийг, 1920-иод оноос биологи, хими, физикийн аргаар бичил мөрийг, 1960-аад оноос атом, нейтроныг, 1970-аад оноос үнэр судлалыг криминалистикийн техник зүйд хэрхэн бүтээлчээр ашиглаж ирснийг бид мэдэх

² Симонов. П.В. Высшая нервная деятельность человека (мотивационно-эмоциональные аспекты). М. Наука, 1975. С. 128

¹ Холодный Ю. Голос молчащего/Служба безопасности/ 1993, №1. С. 25.



билээ.

XIX зууны дунд үе хүртэл уг ухааныг гэмт хэрэг илрүүлэх урлаг гэж байснаа, Австрийн шүүгч мөрдөгч Х.Гроссын нэрлэснээр төв Европ хавийн улсад “Криминалистик” гэж нэршжээ. Англи хэлтэн орнууд энэ ухааныг “Шүүх шинжилгээний ухаан” буюу “Forensic science”, Япон, Бельги мэтийн зарим оронд “Цагдаагийн ухаан” буюу “Police science” гэж бас нэрлэнэ. Оросууд Германаас авсан “Криминалистика” нэрээр явахын зэрэгцээ, XX зууны сүүлээс “Forensic”-ийг “криминалистик”, эсвэл “судебный” буюу “шүүх” гэдэг нэрээр бас орчуулан нэрлэж ирсэн байнам. Криминалистик гэдэг үг үүссэн Латины “criminalis”, шүүх шинжилгээ гэдэг үг үүссэн “forensic” хэмээх үг аль аль нь “гэмт хэрэгт холбоотой” гэсэн үг гэдэг. Манайх мөн л криминалистик нэрээр явахын зэрэгцээ мөнөөх “судебный” гэдэг үгийн “ялгах, шийдэх” гэдэг утгыг эс ухан буруу орчуулснаас “шүүхийн шинжилгээ” мэтийн буруу нэрс орж ирж хэвшсэн байна.

Бүхий л шинжлэх ухааны адил, энэ ухаан зүй тогтлыг судлах бөгөөд түүнд гэмт хэрэгтэй холбоотой бүх зүйл хамаарна. Үүнд, гэмт хэрэг үйлдэгч хувь хүн, түүний дадал, үйлдэх арга, гэмт хэргээс үлдэх төрөл бүрийн мөр, тэдгээрийн үүсэх явц, зүй тогтол, түүний онцлог, аливаа мөрийг илрүүлэх, байгаа хэвээр бэхжүүлэх, унших буюу мөрийн агуулж буй мэдээлэл танин мэдэхүйн бүтцийг гарган авах болон тэдгээртэй ажиллах зүй тогтлыг судлаж, түүндээ үндэслэн гэмт хэргийг илрүүлэх арга, ажиллагааны тактик,

арга зүйн зөвлөмжийг гаргаж боловсруулах асуудал бүхэлдээ багтдаг.

Иймд энэ ухааныг судлах асуудлын хүрээгээр төрөлжүүлэн:

1. Криминалистикийн ерөнхий онол,

2. Криминалистикийн техник зүй,

3. Криминалистикийн тактик зүй,

4. Криминалистикийн арга зүй гэж дөрвөн үндсэн салбар болгон хуваана.

Эхний салбар түүхдээ үндэслэн судлах зүйлээ эрэмблэх, шинжлэх ухааныхаа тодорхойлолтыг оноох, онол, арга зүйгээ цэгцлэх, судлах асуудлаа систем болгон төрөлжүүлэх, криминалистикийн хэмээх хэлийг гаргах, боловсронгуйлах, орчин цагийн мэдлэгийн системд энэ ухааны эзлэх байр, бусад ухаантай хэрхэн уялдаж буй, хөгжлийн төлөв, хандлага зэргийг тодорхойлж өгдөг.

Хоёрдахь салбар мөртэй ажиллах зүй тогтлыг мөр үүсэх, түүнийг илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, тусгаарлан авах, ашиглах буюу шинжлэх гэсэн дарааллаар дагнан судлана. Гэмт хэргийн мөр хэмээх ойлголт одоогийн нүдээр харж болох элдэв ором, хүрээлэн буй орчинд орсон өөрчлөлт, гэмт этгээдийн үлдээсэн зүйл зэргээс эхлээд зөвхөн микроскопоор л харж болох эс, хумхийн тоос хүртэл, энгийн жинлэх аргаас өгсүүлээд атомын жингийн солонголгийг хэмжсэнээр л тодорхойлж болох бичил, нано мөр хүртэл багтана.

Гуравдахь салбар гэмт хэргийг илрүүлэхээр хэрэгжүүлж буй үзлэг хийх, нэгжих, байцаах, турших, мэдүүлгийг газар дээр нь шалгах зэрэг ажиллагааг

төрөлжүүлэн хэргийн газарт, орон байранд, машинд хийх үзлэг гэх буюу, хохирогчийг байцаах, сэжигтнийг байцаах ажиллагаа гэж ангилаад тэр бүгдийг хэрхэн өгөөжтэй, шуурхай хийх тактикийн зөвлөмжийг гаргаж боловсруулдаг.

Дөрөвдэх салбар тодорхой төрлийн гэмт хэргийг шуурхай, дүүрэн илрүүлэхийн тулд ямар ажиллагааг, хэрхэн хэрэгжүүлбэл зохих арга зүйн зөвлөмжийг боловсруулж өгнө. Жишээлбэл манайд хамгийн их гардаг хулгайлах хэргийг илрүүлэх арга зүй гэхэд эхлээд энэ төрлийн хэрэг гарч буй газар нутаг, цаг, үйлдэж буй этгээд, үйлдлийн арга, хулгайн халдлагад их төлөв өртөх объект, тэдгээрийг зарж борлуулах газар, арга зэргийг судлаад хэргийг илрүүлэхийн тулд хэрэг гарсан газарт үзлэг хийж мөр илрүүлэх, илрүүлсэн мөрөөр сэжигтэн этгээд, гэмт үйлдлийн тухай төрөл бүрийн таамаг дэвшүүлэх, түүнийгээ шалгах, мөнөөх мөрөөр тогтоож болох асуултын тоймыг боловсруулах, шинжилгээ томилох, хийлгэх, хохирогчийг байцааж хохирлын хэмжээ болон гэмт хэргийг ирүүлэхэд ач холбогдол бүхий бусад баримтыг тогтоох, гэмт үйлдлийг харсан байж болзошгүй хүмүүсийг тогтоох, байцаах, сэжигтнийг тогтоох, байцаах, түүний хувцас, бие, орон байрт үзлэг, нэгжлэг хийх, гэрчээр таниулах, нүүрэлдүүлэн байцаах, гарын, хөлийн, хувцасны, эвдлэгч багажны мөр, бичил мөр, үнэрийн мөр зэрэг мөрөөр шинжилгээ хийлгэж сэжигтнийх мөн эсэхийг тогтоолгох, сэжигтний мэдүүлгийг газар дээр нь шалгаж нуусан, зарсан зүйлийг



КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ, АРГА ЗҮЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

олж тогтоох, хураан авах, мөрдөн байцаалтын туршилт хийж гэмт үйлдлийг хэрхэн хийсэн нөхцөл, үйлдлийн арга, цаг хугацааг нарийвчлан шалгах зэрэг ажиллагааг хийлгэх талаар арга зүйн зөвлөмжийг гаргаж өгдөг.

Ийнхүү цогц нэгэн ухааныг мөрдөж гэмт хэргийг илрүүлдэг учир “гэмт хэргийг илрүүлэх урлаг” хэмээн нэршсэн байжээ.

Манай улсад гэмт хэрэгтэй тэмцэж буй өнөөдрийн практикаас харахад криминалистикийг цогцоор нь ашиглахгүй байна.

Криминалистикийн онол, арга зүйг зөвхөн ХСИС-ийн хичээлийн хөтөлбөрөөр судлаад орхих тул онол огт хөгжөөгүй гэхэд хэтрүүлэг болохгүй. 2007 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 36 дугаар тогтоолоор батлаж, 2008 оны хичээлийн жилээс мөрдөж эхэлсэн эрх зүйч мэргэжилтнийг бэлтгэх “MNS 5323-39: 2007” стандартаар криминалистик хичээлийг сонгон судлах хичээлд оруулсан тул олонхи сургууль үздэггүй, нэгэнт үздэггүй тул гэмт хэргийг илрүүлэхэд хамгийн чухал ухааныг огт мэддэггүйэрх зүйчид төрж байна.

Криминалистикийн техник зүйг хэрэгжүүлж буй ганц субъект нь ШШҮХ, түүний харъяа нэгжүүд бөгөөд криминалистикийн тактик зүй ба арга зүйг практикт хэрэгжүүлж буй мөрдөх албатай ажлын уялдаа сул тул өгөөж муу байдгийг хүн бүр мэднэ. Тус хүрээлэн сүүлийн үед бичил мөрийн шинжилгээ хийхэд түлхүү анхаарч 2014 онд бичил мөрийн, нэхмэлийн утасны бичил сэмрэгдсийн, шавьж судлалын, ургамал судлалын

зэрэг шинжилгээг цөөн боловч хийж эхэлсэн нь багагүй дэвшил боловч төсөв хөрөнгө дутагдалтайгаас далайцтай хөгжүүлэх боломж хомс байна.

Криминалистикийн тактик зүй болон арга зүйг хэрэгжүүлж буй субъектууд уг нь бүх ажлаа төлөвлөн, хэрэгт хийх ажиллагааг системтэй, дэс дараатай хийх шаардлагатай боловч практикт тэгдэггүй, урсгалаар, зөвхөн мөрдөн шалгах ажиллагааны явцад тогтоож буй ганц 2 баримтыг хөөцөлдөж, хийвэл зохих ажиллагааг орхигдуулдаг дутагдал түгээмэл оршиж байгаа нь өнөөдөр хэнд ч нууц биш. Жишээлбэл, хэн нэг хүнийг байцаах ажиллагааг гэхэд гэрчийг, сэжигтнийг, насанд хүрээгүй гэрчийг, тохиолдлоор харсан хүнийг, рецедивист гэмт хэрэгтнийг мэтчилэн субъектээр төрөлжүүлж, хэн, хаана, хэзээ, ямар техник хэрэгсэл ашиглаж, ямар мэргэжилтнийг оролцуулж, ямар асуултыг тодруулах, асуусан асуултад эерэг ба сөрөг хариулсан тохиолдолд цаашид асуух асуулт, хийх ажиллагаа зэргээ нарийвчлан төлөвлөж, албаны даргаар батлуулж ажиллавал хэргийг илрүүлэхэд өгөөж өндөр байх нь тодорхой. Илтгэлийг бэлдэх явцад судалгаа хийж гэмт хэргийг мөрдөх ажиллагаа явуулдаг 20 субъекттай уулзаж ярилцахад ийм төлөвлөгөө хийдэг хүн нэг ч байгаагүй нь гэмт хэргийг мөрдөх ажиллагаа урсгалаар явж байгаагийн тод жишээ мөн гэж бид үзэж байна.

Орчин үеийн криминалистикийн төлвийг анзаарч үзэхэд уламжлалт аргын зэрэгцээгээр сэтгэл судлалын аргад түлхүү хандах болсон байна. “Олон бичүүр” буюу

“Полиграф” тестийн аргыг гэмт хэргийг илрүүлэхэд 1960-аад оноос ашиглаж эхлэх болсон нь сэтгэл зүйд үндэслэсэн аргын эхлэл байлаа. Энэ арга хүний биед сэтгэл хөдлөлтэй холбоотойгоор гарах өөрчлөлтийг мэдрэгч багажид суурьлана. Хүний биед байрлуулсан авуурын тусламжтайгаар амьсгал, зүрхний цохилт, хөлс ялгаруулах, арьсны цахилгаан эсэргүүцэл, цусны даралт зэргийн өөрчлөлтийг бүртгэж авахад энэ арга үндэслэнэ.

Сэжигтэн, гэрч, хохирогчийн мэдүүлгийг шалгах, хохирсон мэтээр мэдүүлэх болон бусад худал мэдүүлэгчийг илчлэх, сэжигтний хүрээг хумих, хилсээр сэжиглэж буй хүнийг цагаатгах, таамаг шалгах, нэмэлт мэдээлэл цуглуулах гэх зэрэг зорилгоор өнөөдөр криминалистик полиграфыг өргөн ашиглаж байна.

Сэтгэл зүйд суурьласан өөр нэг арга бол барууны орнууд “profile” (хажуу дүр), Оросууд “психический портрет” (сэтгэл зүйн хөрөг) хэмээн нэрлэсэн сэтгэл зүйн хөрөг бүтээх арга юм. Гэмт хэрэг үйлдсэн орчинд хийсэн шинжилгээний явцад тухайн газарт гэмт хэрэгтний хийсэн үйлдлийн тоймоор дүгнэн үйлдэгчийн сэтгэл зүйн онцлог, сэтгэл хөөрлийн төлөв, хэлбэр, тэр ч байтугай гадна төрхийн онцлогийг тодорхойлоход энэ аргыг ашиглана. 1968 онд АНУ-д гарч байсан, “солиот тэслэгч” нэрээр криминалистикийн түүхэнд орсон бөмбөг дэлбэлэгч алуурчийг сэтгэл зүйч доктор Жеймс Бруссель өөрт ирүүлсэн материалд анализ хийгээд хийсэн үйлдлийнх нь тоймоор сэтгэл зүйн хөрөг бүтээх аргаар тодорхойлж, эрж буй хүн: «40—



50 настай, Дорнод Европоос гаралтай, одоо Коннектикут хотноо нэг бол эгчтэйгээ, эсвэл авга эгчтэйгээ суудаг. Хүүхэд байхдаа эцэгтэйгээ таарамж маш муу, харин эхийгээ ихэд хайрлаж, ойлголцдог байсан, сэтгэцийн эмгэг судлалын онош — солио өвчтэй. Нарийн ширийнийг соргог мэдэрдэг. Баривчлах үед бүрэн товчилсон, хоёр эгнээ товчтой костюм өмссөн байх болно»³ гэсэн дүгнэлт гаргаж өгчээ. Брусселийг ийм хөрөг гаргасны дараа Нью-Йоркт Слав гаралтай, 50 настай, эхнэргүй, Коннектикутад нөхөргүй хоёр эгчтэйгээ суудаг Жорж Метесский гэгчийг уг хэрэгт баривчилсан байна. Баригдах үедээ хоёр эгнээ товчтой костюм өмсөж бүрэн товчилсон байжээ”.

Ховсдох аргыг хэрэг бүртгэх, мөрдөх ажиллагаанд оновчтой ашигласан жишээ бас бий. Испанид хоёулхнаа суудаг гэр бүлийн эхнэр алуулсан хэрэгт нөхрийг нь сэжиглэсэнд тэрээр хэрэг гарах үед эзгүй байсан, мэдэхгүй гэж мэдүүлсэн ба ховсдогч Алехандро нохойг ховсдон “Хохирогчийг нөхөр нь буудаж алсан, буудах үед нохой түүн рүү дайрч баруун гарын тохой орчмоос зуусан, үүний дараа тэрээр нохойгоо буудах гэж хөөсөн, гүйцэхгүй болохоороо сүүлд буугаа худагт хаясан” зэрэг мэдээллийг гаргаж авсныг шалгахад үнэн байжээ. Түүнчлэн, АНУ-д 2 охиныг барьцаалсан хэрэгт жирийн үедээ олигтой юм санахгүй байсан охин ховсодсоны

дараа гэмт этгээдийг тухайлан тогтоохоор хэмжээний нарийн мэдээллийг (авто засварын газар, мөнгөний картын өнгө гэх мэт) гаргаж өгсөн ба тухайн насны хүүхдийн үгийн санд байхааргүй тийм этгээд хэллэгийг тогтоож авсан байсан зэрэг жишээ энэ аргын ирээдүйтэйг илтгэнэ.

Сүүлийн үед өргөнөөр ашиглах болсон орчин нөхцөлд хийх криминалистикийн шинжилгээ буюу баруунд “situation examination” гэж нэршсэн арга мөн л сэтгэл зүйд тулгуурласан аргын нэг. Хүрээлэн буй орчны байгаа төлөв, түүнд орсон өөрчлөлт, элдэв мөр зэргээр тоймлон уг гэмт хэрэг гарсан шалтгаан нөхцөл, үйлдсэн этгээдийн үйлдэл, сэтгэцийн төлөв, тухайн орчин, нөхцөлд хүн тус бүр биеэ жолоодох чадвар, хийх үйлдлийн тойм зэргийн тухай мэдээллийг гаргаж авах боломжийг олгодог энэ аргыг дэлхийн криминалистикт цаашид ч өргөн ашиглах хандлагатай байна.

Сэтгэл зүйд тулгуурласан аргын хүрээнд телепацийн арга буюу бодлыг зайд дамжуулах аргыг судлан, ярилцаж буй хүнийхээ бодлыг унших, экстрасанс буюу үзмэрчийн туслалцааг ашиглан хэргийн болж өнгөрсөн үйл явдлын дэлгэрэнгүйг тогтоох, улмаар криминалистикт ашиглах талаар АНУ, ОХУ зэрэг улс нэлээд ажиллаж байна.

1980-аад оноос үнэр судлалын мэдлэгийг ашиглах болж гэмт хэргийг үнэрээр нутлах болж эхлэв. 1986 онд Москвад гарсан,

“Волга” машины жолоочийг алсан хэрэгт үнэр судлалын шинжилгээг ашиглан гэмт этгээдийг нутласан нь дэлхийд анхных байв. Машин дотор, жолоочийн арын суудал дээр бензиний хоосон савны тагийг нээн хаясан байсан ба 5 суудлаас үнэрийн мөрийг бэхжүүлэн авч харьцуулаад чухамхүү хоосон сав байсан суудал дээр сэжигтний үнэр байсныг тогтоосон нь энэ арга хичнээн ирээдүйтэйг гэрчилнэм.

Манай практикт сэтгэл зүйд суурилсан дээрх аргуудыг огт ашигладаггүй билээ.

Эдгээрээс дүгнэхэд, манай улсад криминалистикийг гэмт хэрэгтэй тэмцэхэд өргөн ашиглах нэн хэрэгцээтэй байгаа нь харагдаж байна.

Дүгнэлт

Манай улсын гэмт хэргийг мөрдөх практикт криминалистикийн хэрэгцээ байгаа боловч түүнийг цэгцтэй ашиглахгүй байна.

Санал

Гэмт хэргийг шинжлэх ухааны үндэстэй илрүүлэхэд криминалистикийг өгөөжтэй ашиглахын тулд

- Хуулийнбүхбайгууллагын практик ажилтнуудад сургалт явуулж к р и м и н а л и с т и к и й н мэдлэгийг нэмэгдүүлэх,
- Хэрэг бүртгэх, мөрдөх ажиллагаанд к р и м и н а л и с т и к и й г цэгцтэй ашиглах зэрэг болно.

³ Обрацов. В. А. Основы криминалистики. М.: Юристъ, 1996. 160 с.





ТЕХНОЛОГИЧЕСКИЕ ПРИЕМЫ ОБУЧЕНИЯ СТУДЕНТОВ
ЮРИСТОВ МЕТОДИКЕ РАСКРЫТИЯ ПРЕСТУПЛЕНИЯ В
УЧЕБНЫХ ЗАВЕДЕНИЯХ МОНГОЛИИ

САДЫКОВ НИКОЛАЙ БУДАЕВИЧ

*доцент кафедры уголовного процесса, заведующий криминалистической лаборатории
юридического факультета Бурятского государственного университета*

Среди преступлений против жизни и здоровья, убийство считается наиболее опасным по своему вреду, последствиям, как для общества так и для отдельного человека. Их раскрытие требует высокого криминалистического профессионализма следователей и помогающих ему оперативно розыскных работников.

В этой связи, важную роль, в подготовке будущих следователей играет дидактический подход преподавателя к методике расследования убийств.

В России методика расследования убийств, предусматривает знание следователем криминалистической характеристики убийств и умение использовать эти знания в их расследовании. Важнейшим элементом криминалистической характеристики убийств является сведения о способах их совершения. Кроме того, условия при котором совершено убийство называется очевидным и не очевидным. Такое же понятие имеется и в учебнике Криминалистика Монголии.

Но что отрадно отметить, в криминалистике Монголии очень подробно и четко прописаны действия преступника в период подготовки к преступлению в

момент и после, а также действия следователя по избличению преступника. В России в учебнике криминалистике об этом сказано сухо, но восполняется в результате монографических работ ученых, а также в различных брошюрах и журналах, где практические работники делятся своим опытом работы по раскрытию и расследованию различных преступлений.

Например, в журнале Следственного комитета России «Предварительное следствие», выпуск 1(7) 2010г. В разделе Раскрытие и расследование преступлений, связанных с безвестным исчезновением граждан в статье В.В. Волкова руководителя отдела криминалистики СУ СКР по Курганской области «Убийство или безвестное исчезновение граждан» идет перечисление оперативно-розыскных мероприятий, такие как собирается характеристика на пропавшего, составляется словесный портрет, описывается одежда, в котором он был в день исчезновения, предметы которые он имел с собой, запрашиваются морги, больницы, психиатрические учреждения и т.п.

Данными, указывающими на

признаки преступления, могут быть следы крови в жилище пропавшего, наличие по месту жительства вещей и документов, без которых человек не может обходиться в случае длительного отсутствия и т.д.

Выдвигаются версии, одним из которых под подозрение попадают близкие родственники¹.

В учебнике «Криминалистика» под редакцией Н.П. Яблокова в разделе следственные ситуации указано: «Материалы проверки указывают на вероятность убийства исчезнувшего... Типовые первоначальные версии направлены на проверку следующего: убийства, самоубийства, смерти и захоронения как неизвестного лица ... После подтверждения версии об убийстве (обнаружен труп, его части либо следы сожжения трупа и другие) на основе изучения личности и образа жизни убитого и его окружения выдвигаются и проверяются версии о мотиве времени и месте убийства, а также личности убийцы».²

Р.С.Белкин, Т.В. Авреьянов, Ю.Г. Коруханов,

¹ Волков В.В. «Убийство или безвестное исчезновение» Сборник СК при прокуратуре РФ «Предварительное следствие», выпуск 1 (7), 2010, С.102-103

² Яблоков В.П. «Курс лекции по криминалистике», М, С.310



Е.Р. Россинская в разделе расследование убийств... в связи с исчезновением потерпевшего указывают на необходимость проверки самого факта исчезновения, с привлечением оперативно-розыскных мероприятий, детального допроса заявителя, у которого выясняется, когда последний раз видели исчезнувшего, как был одет, какие документы, предметы и ценности были при себе; какие документы и ценности остались дома, на работе; как он вел себя в последнее время, не намеревался ли уехать, наличие у него особых примет, кто мог быть заинтересован в его смерти. Осматривается место жительства исчезнувшего.³

Аналогичные рекомендации по раскрытию убийств, в связи с исчезновением потерпевшего, дали А.Ф. Волынский, В.П.Лавров, Е.П. Ищенко, А.А. Топорков и др.

Все эти рекомендации несомненно имеют практическое значение и неоднократно применялись на практике, но хочется отметить, что в учебнике «Криминалистика» Монголии в разделе «Руководство по расследованию убийств» при описании методики расследования убийств в случае исчезновения человека указаны более подробные рекомендации такие как, «... необходимо ХОРОШО допросить подающего заявления... Спрашивать необходимо о последнем месте пребывания человека...во что был одет... был ли кому либо должен, находился ли в ссоре с кем-то...при обнаружении трупа необходимо помнить, что одежда на трупе может быть

приобретенной...

В случае получения данных о том, что пропавший убит, возбуждают уголовное дело. Предварительно продумывают план, основанный на следующих условиях: выбирало ли время при совершении преступления виновное лицо, искало ли орудие для осуществления своих действий, устраняло ли препятствия...и т.д. Чаще всего для подавления сопротивления потерпевшего, для причинения ему вреда используют в качестве орудия предметы бытового назначения: нож, топор, шило, ножницы и т.д. Но если убийство носит случайный характер, то используют предметы, находящиеся под рукой на месте совершения преступления: палки, камни, стекло, трубы и т.д.

При совершении умышленных убийств, непременно остаются следы, условия применения насилия. Это могут быть следующие следы:

- на месте совершения преступления следы борьбы выражаются в беспорядке (посуда, столы, стулья лежат упавшими, предметы разбросаны в беспорядке);
- на месте преступления бывают следы биологического происхождения: кровь, слюна, рвотные массы, волосы и т.д.);
- микроследы (обрывки одежды, нитки);
- на одежде потерпевшего следы повреждений (разорванная, разрезанная, распоровшаяся);

- вследствие оказания сопротивления потерпевшим, на теле преступника остаются следы ногтей, зубов, одежда разорвана, оторвана;
- брошенные, потерянные на месте преступления виновным лицом вещи.

На метод, выбранного преступником для сокрытия своего преступления, влияют отношения между преступником и потерпевшим, место, где произошло преступление.

Однако, если преступник не был знаком с потерпевшим, их знакомство носит случайный характер, тогда место совершения преступления не касается лично преступника, стараясь как можно быстрее сбежать с данного места, чтобы было время возможность скрыться.

Если убийство произошло в доме, чтобы не привлекать внимание, тело скрывают, либо в ванной комнате, либо в туалете, под кроватью, в шкафу для вещей и сверху забрасывают кучей предметов.

Однако, если убийство произошло в открытом, заброшенном, тело прикрывают ветками, травой, придавливают мусором, либо бросают в строящееся или развалившееся здание, в подвал, водопровод.

Наряду с сокрытием последствий причиненного вреда преступник принимает меры по устранению следов, оставшихся на его теле, ликвидации одежды, орудия. Это могут быть следующие меры: стирает, отдает на чистку, выбрасывает, сжигает одежду, если появились шрамы, ссадины замазывает

³ Белкин Р.С. учебник «Криминалистика», М,2010, С677



КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ, АРГА ЗҮЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

кремом, пудрой, полученные раны перебинтовывает.

В целях устранения тела потерпевшего, сжигает его, для сокрытия расчленяет...

Также, преступник для устранения подозрения против него, активно ведет поиски потерпевшего, распространяет слухи о его дальней поездке, отправляет посылки, телеграммы из разных мест от

его имени и т.д....»⁴

Таким образом, можно, что монгольские преподаватели, обучая студентов криминалистике и методике расследования отдельных видов преступления, дают больше практически значимые знания студентам.

⁴ Ж.Амарсанаа «Криминалистика П», Улаанбаатар хот, 2002, С.344-349



ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУУЛЬ ТОГТООМЖООР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ЭРХ ЗҮЙН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ

Б.Баянмөнх

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн дэд
профессор, докторант, цагдаагийн хошууч



Монгол Улсын цагдаагийн байгууллагын үндсэн үүрэг бол гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах мөн.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох нэг чухал асуудал бол түүний эрх зүйн үндсийг боловсронгуй болгох явдал бөгөөд зөвхөн өнөөдрийг харж одоо байгаа зүйлүүдэд тулгуурлан өөрчлөлтийг хийх, практик ажиллагаанд ашиглан хэрэглэхэд учир дутагдалтай.¹ Иймд цагдаагийн байгууллагын гүйцэтгэж ирсэн үе үеийн үүргүүдийг харьцуулан авч үзснээр өнөөгийн цагдаагийн байгууллагын шинэчлэлтийг эрчимжүүлэхэд ач холбогдолтой.

Монгол Улс ардчилсан эрх зүйт улс болон хөгжих явц нь хууль сахиулах байгууллагууд, түүний дотроос цагдаагийн байгууллагын тогтолцоо, үйл ажиллагааны өөрчлөлт шинэчлэлтээс ихээхэн хамааралтай бөгөөд хууль

хяналт, цагдаагийн байгууллагын явуулж буй үйл ажиллагааны үр дүн нь төрөөс хүний эрх, эрх чөлөөг хэрхэн хангаж, хүлээн зөвшөөрч байгаа, нийгэм иргэдийнхээ аюулгүй байдлыг хангах тал дээр хэр анхаарч, байдлыг хэрхэн шийдвэрлэсэн болон төрийн механикмыг боловсронгуй болгосон байдал, төрийн тогтвортой бодлогоос ихээхэн хамаарна.

1990 онд Монгол Улсад ардчилсан хувьсгал өрнөж, нийгмийн тогтолцоонд өөрчлөлт орсноор төрийн үйл ажиллагааны механизм мөн дагаад өөрчлөгдсөн бөгөөд ардчилал, шинэчлэлийн нөлөөгөөр Монгол оронд түүхэн үнэнийг сэргээх, түүхэн үйл явдлыг чөлөөтэй судалж, олон ургалч үзэл санаагаар тунгаан дүгнэх таатай нөхцөл боломжийг бий болгосон билээ.

Энэхүү нийгмийн тогтолцоонд өөрчлөлт орсноор төрийн байгууллагуудад нэлээдгүй өөрчлөлтийг хийсэн билээ. Тухайлбал, Нийгмийг аюулаас хамгаалах яамны харьяанаас гаргаж, Засгийн газрын дэргэд Цагдан сэргийлэх ерөнхий газрыг байгуулсан нь цагдаагийн байгууллагыг тагнан турших байгууллагын системээс гаргаж бие даалгасан чухал

алхам болсон.²

Зохион байгуулалтын оновчтой энэ өөрчлөлт нь шинэчлэгдсэн нөхцөл байдалтай уялдан бие бүрэлдхүүнээ өргөжүүлэн бэхжүүлэх, материаллаг баазыг нэмэгдүүлэх, шинжлэх ухаан, техникийн ололт, хамгаалалтын техник хэрэгслийг нэвтрүүлэхэд зохих нөлөө үзүүлсэн билээ.

Тэгвэл өнөөг хүртэл цагдаагийн байгууллага ямар үүрэг гүйцэтгэж ирсэн, түүний эрх зүйн өөрчлөлт, шинэчлэлтийг нь тусгайлан авч үзэх нь цаашдын хөгжлийн чиг хандлагад тодорхой хувь нэмэр болно гэж үзэж байна.

Нийслэл хүрээний цагдан сэргийлэх хорооны дүрэм, хэмжээ:

Засгийн газрын 1923 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 18 дугаар хурлаар Ардын цагдан сэргийлэхийн анхны дүрэм болох “Нийслэл хүрээний цагдан сэргийлэх хорооны дүрэм, хэмжээ”, мөн “Цагдан цээрлүүлсний зөрчигсөдийг яллах хууль”³-ийн хамт батлан мөрдүүлжээ.

² “Монгол улсын цагдаагийн байгууллагын түүхэн замнал, шинэтгэл” 2006 он УБ хот 34 дэх тал

³ А. Думбурай. БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын зарим эрхийн актууд. УБ. 1988. 15-20 дахь тал

¹ Д.Таванжин. Монголын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний хөгжилт. УБ. 2000. 7 дахь тал



Энэ дүрэм нь МАХН-ын Төв хороогоор зөвшөөрүүлэн Засгийн газрын 1923 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 18 дугаар хурлаар хэлэлцэн баталсан. Уг дүрэмд Цагдан сэргийлэх байгууллагын гүйцэтгэх үүргийг тодорхойлохдоо “Гэмт хэрэгтэй тэмцэх, хууль дүрмийн биелэлтэнд хяналт тавих, хэв журмыг сахиулах, үйлдсэн эрх зүйн зөрчилд хавсран хууль ёсоор арга хэмжээ авч байх, олон улсын элчин консулыг хамгаалах, ариун цэврийг сахиулах, эргүүл манааны үүрэг гүйцэтгэх, гал түймрийг сэргийлж сөнөөх явдлууд болохыг заахын хамт Засгийн газар, олон яамдаас зааж тушаасан нэмэгдэл үүргийг биелүүлж байхыг заасан байна.”⁴

Хүрээний цагдан цээрлүүлэх хорооны тухай хууль:

Генерал Сюй-шу-Чжан Монголын бүх эрх мэдлийг гартаа авч дагаж мөрдөж байсан аливаа хууль дүрмийг хүчингүй болсныг зарлаж, өөрийн хүсэл зорилгод нийцсэн хууль дүрмүүдийг боловсруулан дагаж журамлуулах арга хэмжээ авч эхэлсний нэг нь “Хүрээний цагдан цээрлүүлэх хорооны тухай хууль” гээчийг боловсруулан гаргасан явдал юм.⁵

Энэ хууль нь 11 зүйлтэй бөгөөд хүрээн дор цагдан цээрлүүлэх хороо байгуулж, ерөнхий сайдын яамнаа захирагдаж, хүрээний бүх зээлийн цагдан цээрлүүлэх, амьтныг хамгаалах, галыг сөнөөх үүргийг гүйцэтгэхээр зохицуулсан.

⁴ Д.Таванжин. Монголын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний хөгжилт. УБ. 2000. 25 дахь тал

⁵ Д.Таванжин. Монголын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний хөгжилт. УБ. 2000. 20 дахь тал

БНМАУ-ын сэргийлэх газрын дүрэм:

1924 оны 9 дүгээр сард Догсом тэргүүтэй комисс байгууллагдаж, анхны дүрэм дээр 6 зүйл шинээр нэмэгдүүлэн, Засгийн газрын 1924 оны 2 дугаар сарын 21-ны 43 дугаар хурлаар баталсан байна. Ингэж Улсын анхдугаар хурлын заалт хэрэгжиж, Дотоод яамны харъяанд Цагдан сэргийлэх газар байгуулагдснаар Цагдан сэргийлэх газрын дүрмийг шинэчлэн боловсруулж, 9 бүлэг, 73 зүйлтэй дүрмийг Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1926 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 1-р хурлаар хэлэлцэн хүчин төгөлдөр болжээ.

Энэ үеийн Цагдан сэргийлэх газрын чиг үүрэг нь “Нийслэл хүрээ, Гандан хийдийн доторх гол дуган сүм, ордуудыг сэргийлэн манаж, тэнд муу самуун хэрэг өдүүлэхгүй, муу хүмүүсийг шургуулахгүй байх, Богд эзэн, улсын эх дагина, гэгээнтэн залрах, ном бурхан залах, цэрэг жагсах өдрүүдэд олон хүнийг дэмий үймэлдэн шахцалдуулахгүй болгон их ёслолыг хүндэтгэн гүйцэтгэх, цагдан сэргийлэх нь аливаа олныг цаг үргэлжид тайван суулгах, Богдын тушаалыг дагаж явуулах, зохих дээд тушаалын эхэс, гадаад улсын элчин сайд, ихээхэн албаны хүн нарыг хичээнгүй ёсоор харгалзан эрхэмлэж өнгөрүүлэх журмыг сахиж, аливаа хүнд найртай зөөлөн эелдэг зан ёсоор хандаж тушаалын хэгийг сайтар бүтээмжлэн гүйцэтгэвээс зохино”⁶ хэмээн тодорхойлсон байна.

Цагдан сэргийлэх газрын

⁶ А.Думбурай. Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжил/1-р дэвтэр/. УБ. 2000. 57 дахь тал

Цагдан дагаж явах дүрэм:

Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаа цагдан сэргийлэх хэлтсийн дүрмийг 1927 оны сүүлчээр боловсруулан хотын захиргааны 12 дугаар сарын 20-ны 4 дүгээр хурлаар хэлэлцэн баталж, улмаар Засгийн газрын 1928 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 1 дүгээр хурлаар хэлэлцэн баталжээ.

Дүрмийн 3 дугаар зүйлд “Хотын доторхи олон ардын амгалан байдлыг сахин хамгаалах нь элдэв зүй бус явдлыг ариутгахын учир ямагт санаа тавьж, нарийн чандаар цагдан сэргийлж...хууль цааз зарлал хийгээд дүрэм зааврыг зөрчигчид эрүүгийн хэрэгт холбогдох хэрэгтэн этгээдийн зэрэг зальхай, самуун хүмүүсийг байцаан бариулж, хууль дүрмийн ёсоор цээрлүүлэн шийтгэх буюу зохих газраа шилжүүлэн шийтгүүлбээс зохино” гэж үүргийг нь тодорхойлжээ.⁷

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Цагдан сэргийлэх тухай дүрэм:

Засгийн газрын 1934 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 3 дугаар хурлаар “БНМАУ-ын цагдан сэргийлэхийн дүрэм”-ийг хэлэлцэн баталж, улмаар Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 7-р хурлаар хэлэлцэн баталсан байна.⁸

Энэ дүрмээр цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үүргийг 19 байхаар тусгасан бөгөөд уг үүрэгт “олон нийтийн амь бие, улсын болон олон нийтийн хөрөнгийг хамгаалах, малын хулгайгаас сэргийлэх, төв ба

⁷ Д.Таванжин. Монголын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний хөгжилт. УБ. 2000. 49 дэх тал

⁸ Д.Таванжин. Монголын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний хөгжилт. УБ. 2000. 60 дахь тал



орон нутгийн засаг захиргааны газруудаас гаргасан тогтоол ба тушаалуудыг сахин гүйцэтгэх, зөрчигчдийг хариуцлагад татаж шийтгэх, албан тушаалтны хууль ёсны шаардлагыг үл гүйцэтгэх, эсэргүүцэх аваас тусламж үзүүлэх, хотын доторхи гудамж ба айлууд, яармаг ба наадмын газарт хэв журам сахиулах, хашаа, гудамж, чөлөөнүүдийн ариун цэврийг сахиулах, орон байшин, барилгуудын гүйцэтгэх аюулыг дүрмийн ёсоор гүйцэтгүүлэх, гэнэтийн аюулууд болох шуурга, усны үер, гал түймрээс хамгаалах, туслах этгээдгүй арга ядарсан хүмүүст анхны тусламж үзүүлэх, онц халдвартай тарваган тахал ба халуун өвчин гарсан үед зохих байгууллагад мэдэгдэх, тэмцэх арга хэмжээ авах, малын халдварт өвчин гарсан үед эмнэлгийн болон захиргааны байгууллагад мэдэгдэж, арга хэмжээ авах, гэнэт алга болсон насанд хүрээгүй хүүхдийг эрэх, олдсон эд хөрөнгө ба мал, баримт бичгийг хүлээн авч, эзэн гартал хамгаалах, эрүүгийн хэрэгт холбогдох гэмт явдлуудыг урьдаас сэргийлэх, зогсоох, эрүүгийн гэмт хэргүүдийг илрүүлэх, байцаах, шүүхэд шилжүүлэх, гэмт хэргээс зайлан оргох, шүүх таслан газрын тогтоолыг үл гүйцэтгэх этгээдийг эрэн олох, цэргийн албан хаагчид ба нас тэнцсэн этгээд нар хөсөг хэрэглэлийн зүйлийг бүртгэх явдал дор тусламжийг үзүүлэх” зэрэг үүргүүдийг тусгасан байна.

Дотоод Явдлын Яамны харьяа Улсын Цагдан сэргийлэх газрын дүрэм:

1942 оны 4 дүгээр сард БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 14-р хурлаар Дотоод

явдлын яамны харьяа Улсын цагдан сэргийлэх газрын дүрэм хэлэлцэн батлав. Энэ дүрэм нь 3 бүлэг, бүлэг тус бүрт 4-14 зүйлтэй байв.

Шинэ дүрмийн заалтаар 1940 онд Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар баталсан паспортжуулах ажлыг Цагдан сэргийлэх байгууллагад хариуцуулахаар болсон байна.

1943 оноос тус улсын харьяат нараас гадаад улсад виз, паспортын асуудлыг Цагдан сэргийлэх байгууллагаас шийдвэрлэж эхэлсэн байна.

Уг дүрмийн 3 дугаар зүйлд “Улсын цагдан сэргийлэх газар нь төв ба орон нутгийн засаг захиргааны газраас олон нийтийн хэв журам ба амгалан тайвны байдлыг сахиулах тухай гаргасан хууль, тушаал, тогтоолуудыг хэрхэн биелүүлэн буйг хянан шалгах болно. Түүнчлэн тус улсын эрүүгийн болон байцаан шийтгэх хуулийг баримтлан дагаж, аливаа нэгэн гэмт хэргийг өдүүлэгч нэр лугаа тэмцэх бөгөөд улсын хийгээд олон нийтийн болон ардын хувийн эд хөрөнгийг ба ард түмний амгалан тайвны байдлыг хамгаална”⁹ хэмээн Цагдан сэргийлэх байгууллагын гүйцэтгэх үүргийг тодорхойлсон байна.

БНМАУ-ын Дотоод явдлын яамны Улсын цагдан сэргийлэхийн дүрэм:

Энэхүү дүрмийг 1955 оны 3 дугаар сарын 29-нд баталсан бөгөөд 3 хэсэг, 18 зүйлээс бүрдэж байв.

Урдах дүрмэнд Цагдан сэргийлэх байгууллагын үүргийг гуравхан зүйлд багтаан

⁹ Д.Таванжин. Монголын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний хөгжилт. УБ. 2000. 70-71 дэх тал

ерөнхий тодорхойлолт өгч байсан бол, энэ дүрмээр Цагдан сэргийлэх байгууллагаас төрийн захиргааны байгууллагын хувьд гүйцэтгэх үүргүүдийг эрүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх, паспортын системийг хэрэгжүүлэх, иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх, авто техникийн шалгалт ба хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавих зэргээр тус бүрд нь тодорхойлсон явдал ихээхэн чухал ач холбогдолтой болсон юм.¹⁰

Цагдан сэргийлэх байгууллагын гүйцэтгэх үүргийн талаар уг дүрмийн 2 дугаар хэсэг /Улсын цагдан сэргийлэхийн эрх, үүрэг/, 3 дугаар зүйлд тусгаж өгсөн бөгөөд тодорхой хэмжээгээр бүлэглэн төрөлжүүлсэн нийтдээ 26 үүргийг гүйцэтгэж байсан байна. Тухайлбал,

а. Захиргааны арга хэмжээ авах талаар /13 үүрэг/

б. Эрүүгийн гэмт хэрэг өдүүлэх явдалтай тэмцэх талаар /3 үүрэг/

с. Паспортын системийг биелүүлэх талаар /3 үүрэг/

д. Иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх талаар /3 үүрэг/

е. Автомашин, техникийн ашиглалт болон хөсөг тээвэр ба явган хүмүүсийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай дүрмийг хэрхэн биелүүлж байгааг хянах талаар /4 үүрэг/

Дүрмийн 5 дугаар зүйлд “Энэ дүрмийн 3-р зүйлд зааснаас өөр үүргийг Улсын цагдан сэргийлэхэд гагцхүү БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн тогтоолоор даалгаж болно.”¹¹

¹⁰ Д.Таванжин. Монголын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний хөгжилт. УБ. 2000. 75 дахь тал

¹¹ Д.Таванжин. Монголын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний хөгжилт. УБ. 2000. 79 дэх тал



БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм:

1960 онд Монгол Улсын Үндсэн хууль шинэчлэгдэн батлагдсанаас үүдэн Цагдан сэргийлэх байгууллагын шинэ шинэ зорилт дэвшин гарсанаас 1963 оны 10-р сарын 25-ны өдөр БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 499 дүгээр тогтоолоор “БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм” шинэчлэгдэн батлагджээ.

Энэхүү дүрмээр 1955 оны дүрэмд заасан дээр галын аюулаас хамгаалах болон бусад үүргүүдийг нэмж тодорхойлсон байна.

Энэ дүрэм нь 2 бүлэгтэй, 351 зүйлтэй, хавсралт олон журамтай, ихээхэн хэм хэмжээний нийлбэр цогц байжээ.

Цагдан сэргийлэх байгууллагын гүйцэтгэх үүргийн талаар уг дүрмийн 2 дахь хэсэгт Цагдан сэргийлэх байгууллагын үүргийг тусгаж өгсөн бөгөөд 7 чиглэлээр бүлэглэн төрөлжүүлж, нийтдээ 43 үүргийг гүйцэтгэж байсан байна. Тухайлбал,

а. Гэмт хэрэгтэй тэмцэх талаар /8 үүрэг/

б. Олон нийтийн хэв журам сахиулах талаар /11 үүрэг/

в. Хөдөлгөөний аюулгүй байдал хангах талаар /10 үүрэг/

д. Галын аюулаас хамгаалах талаар /3 үүрэг/

е. Паспортын дүрмийг биелүүлэх талаар /5 үүрэг/

г. Иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх талаар /2 үүрэг/

г. Бусад үүргийг биелүүлэх талаар /4 үүрэг/¹²

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 96 дугаар зарлиг. “БНМАУ-ын Цагдан

¹² Д.Таванжин. Монголын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний хөгжилт. УБ. 2000. 86-90 дэх тал

сэргийлэх байгууллагын үндсэн үүрэг, эрхийн тухай”

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1985 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн хуралдаанаар Цагдан сэргийлэх байгууллагын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор уг 96-р зарлиг гарсан байна.

Зарлигийн 1-д Цагдан сэргийлэх байгууллагын нэн чухал зорилт нь гэмт хэрэг, нийгэмд харш бусад үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, түүнчлэн гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад бүх талын тус дэмжлэг үзүүлэх явдал мөн” хэмээн тодорхойлж өгчээ.

Тус зарлигт Цагдан сэргийлэх байгууллагын үндсэн үүргийг 18 байхаар тусгасан байх бөгөөд зарлигийн 7-д “Олон нийтийн газарт хэв журам сахиулах, иргэн, байгууллагын хууль ёсны ашиг сонирхолыг нийгэмд харш үйлдлээс хамгаалах, гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж илрүүлэх зорилгоор шуурхай эрэн сурвалжлах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, прокурор, мөрдөн байцаагчийн ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх, нийгмийн хэв журам хамгаалах асуудлаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийн биелэлтэнд хяналт тавих, депутат, албан тушаалтанд эрх хэмжээний дотор дэмжлэг үзүүлэх, гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгахад хуульд заасан арга хэмжээ авах, хүүхдийн гэмт хэрэгтэй тэмцэхэд

улс, хоршоолол, олон нийтийн байгууллагатай хамтрах, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх, химийн хорт бодисын эргэлтэнд хяналт тавих, паспортын системийг хэрэгжүүлэх, эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, тоо бүртгэл хөтлөх, галын аюулаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэнсэн суллагдсан этгээдэд захиргааны хяналт тавих, олон нийтийн газарт биеэ хамгаалж чадахгүй байгаа хүмүүст тусламж үзүүлэх, байгалийн гамшиг, бусад онцлог нөхцөлд улс, олон нийт, иргэдийн амины эд хөрөнгийг хамгаалах, гудамж, талбайн ариун цэврийг сахиулах, хорио цээрийн дэглэм сахиулах” зэрэг олон үүргийг гүйцэтгэж байжээ.

БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм:

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 96-р зарлигийг үндэслэн Сайд нарын зөвлөлийн 1985 оны 4-р сарын 26-ны өдрийн 95 дугаар тогтоолоор “БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм”¹³-ийг батлан гаргасан байна.

Уг дүрмээр Цагдан сэргийлэх байгууллагын үүргийг 24 болгон өмнөх зохицуулалтаас улам нэмэгдүүлсэн байна.

Цагдан сэргийлэх, Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын ажилтны үүргээ биелүүлэх баталгааны тухай БНМАУ-ын хууль:

Улсын Бага Хурлын 1990 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн анхны хуралдаанаар “Цагдан сэргийлэх, Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын ажилтны үүргээ биелүүлэх

¹³ Д.Таванжин. Монголын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний хөгжилт. УБ. 2000. 100-103 дахь тал



баталгааны тухай БНМАУ-ын хууль”¹⁴-ийг батлан гаргасан байна.

Цагдаагийн байгууллагын тухай хууль:

1993 онд УИХ-аас баталсан Цагдаагийн байгууллагын тухай хууль¹⁵-д “Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн” гэж тодорхойлсноор энэ байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоож өгсөн.

Цагдаагийн байгууллагын үүргийг нийтлэг шинжээр нь бүлэглэн ангилсныг чиг үүрэг гэж нэрлэж байгаа юм. Эдгээр чиг үүрэгт юу юу багтахыг задалж тоочсоныг үүрэг гэнэ.¹⁶ Уг хуулиар цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үүргийг дараах байдлаар тодорхойлжээ. Тухайлбал,

- Гэмт хэрэгтэй тэмцэх /6 үүрэг/
- Нийгмийн хэв журам хамгаалах /2 үүрэг/
- Хүмүүсийг эрэн сурвалжлах
- Гүйцэтгэх ажил
- Шинжилгээ хийж, дүгнэлт гаргах¹⁷
- Цагдан хорих, баривчлах, албадан саатуулах шийдвэрийг биелүүлэх
- Ял эдлүүлэх тогтоолыг биелүүлэх¹⁸
- Эрүүлжүүлэх¹⁹

¹⁴ Д.Таванжин. Монголын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний хөгжилт. УБ. 2000. 122 дахь тал

¹⁵ Төрийн мэдээлэл. УБ. 1993. №1

¹⁶ Б.Пүрэв. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн тайлбар. УБ. 1997. 13 дахь тал

¹⁷ Энэ зүйлийг 2009 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар хүчингүй болсон тооцсон

¹⁸ Энэ үүрэг шинээр байгуулагдсан Тахарын албанд шилжсэн.

¹⁹ Шинэчлэлийн бодлогын хүрээнд эрүүлжүүлэх үйл ажиллагааг

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах
- Гал түймэртэй тэмцэх²⁰
- Цагдаагийн байгууллагаас гүйцэтгэх захиргааны үүрэг /10 үүрэг/²¹

Монгол Улсын цагдаагийн байгууллага дээрх 2-оос гадна захиргааны нилээд үүрэг гүйцэтгэдэг байсан нь “Захиргааны үйл ажиллагаа” юм.

Харин УИХ-ын чуулганаар цагдаагийн байгууллагаас явуулах захиргааны зарим үйл ажиллагаа нь чиг үүргийн хэмжээнд хүрэхгүй, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхэд туслах чанартай гэж үзсэн байна.²²

Цагдаагийн албаны тухай хууль

Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 2013 оны 7 сарын 5-ны өдрийн УИХ-ын чуулганаар Цагдаагийн албаны тухай хуулийг шинэчлэн баталсан бөгөөд уг хууль нь 9 бүлэг, 42 зүйлтэй.

Уг хуулиар цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үүргийг 3 үндсэн үүргээр тодорхойлсон юм. Өмнөх хуулиар хүлээсэн үүрэг дээр шинээр олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг шинээр нэмэгдсэн. Энэ нь Дотоодын цэргийн гүйцэтгэж ирсэн чиг үүргийг цагдаагийн байгууллагад шилжүүлсэнтэй холбоотой юм.

Өнөөдөр цагдаагийн байгууллага дараах 3 үндсэн үүргийг гүйцэтгэж байна. Үүнд: Эмнэлэгийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

²⁰ Энэ зүйлийг 1999 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар хүчингүй болсон тооцсон

²¹ Захиргааны үүргээс 6 үүргийг хүчингүй болгосон.

²² Б.Пүрэв. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн тайлбар. УБ. 1997. 13 дахь тал

1. Гэмт хэрэгтэй тэмцэх /5 үүрэг/

2. Нийтийн хэв журам хамгаалах /2 үүрэг/

3. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах /7 үүрэг/

Дээрх 3 үүргээс гадна захиргааны хяналтын үүрэг гүйцэтгэдэг бөгөөд үүнд 7 үүргийг зааж өгсөн боловч бусад хууль тогтоомжоор хүлээлгэсэн үүргийг бусад үүрэгт хамааруулан үзсэн байна.

Дүгнэлт

Цагдаагийн байгууллагын 1916 оноос хойшхи бүхий л гүйцэтгэж ирсэн үүргүүдийг авч үзэхэд, ихэвчлэн тухайн үеийн нийгмийн тогтолцоо, төр, засгийн бодлого, шийдвэр, цаг үеийн шинж чанартай улс төрийн нөхцөл байдлаас ихээхэн хамаарч байжээ.

Тухайн үед өнөөгийн цагдаагийн байгууллагын гүйцэтгэж байгаа үүргээс харьцангуй олон үүргийг цагдан сэргийлэх байгууллагад хариуцуулж байжээ. Тухайлбал, мэргэжлийн хяналтын байгууллагын гүйцэтгэж байгаа үүргийг цагдаагийн байгууллагад харьяалуулж байжээ.

1920-аад оны үеийн Цагдан сэргийлэх байгууллагын үүрэг нь гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журам сахиулахаас гадна эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан бүхий л шийдвэрийг биелүүлдэг байсан нь тухайн үеийн нийгмийн харилцааны зохицуулалт нь бүрэн хэмжээгээр үйл ажиллагааг зохицуулж чадахгүй байсантай салшгүй холбоотой.

1938 оны үед улс, олон нийтийн өмчид халдагсадтай тэмцэх үүрэг бүхий “эдийн засгийн” тасгийг шинээр



ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

байгуулсан явдал Монгол Улсад цагдан сэргийлэх байгууллагыг нийгмийн үйлдвэрлэлийн шинэ харилцааг хамгаалах үүргийг хэрэгжүүлэхэд түлхэц болсон.

1960-аад оны үеийн Цагдан сэргийлэх байгууллагын гол зорилт нь нийгмийн хэв журам сахиулж, гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх явдал хэвээр байсан боловч хамгийн гол нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх шинэ зорилт дэвшин гарсан байна.

1980-аад оны үеийн Цагдан сэргийлэх байгууллага гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхдээ ганцаараа биш төр засаг, олон нийтийн бүх байгууллага, ялангуяа хууль хамгаалах байгууллагууд, иргэд, хөдөлмөрийн хамт олонтой нягт хамтран ажиллаж, энэ ажлыг бүх нийтийн үйлс болгоход чиглүүлсэн байна.

1990-ээд оны үед Монгол Улсад нийгмийн тогтолцоо өөрчлөгдөж, улс орны бүхий л харилцааг зохицуулж байсан тухайн үеийн эрх зүйн

зохицуулалтууд бүхэлдээ зохицуулж чадахгүй болсон бөгөөд 1993 онд Цагдаагийн байгууллагын тухай хууль батлагдснаар цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг анх удаа хуулиар баталгаажуулсан явдал юм.

Өнөөдөр цагдаагийн байгууллагын гүйцэтгэж байгаа үүргийг 2013 онд батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулиар зохицуулж байгаа бөгөөд 3 үндсэн, нэг дэмжлэг үзүүлсэн чиглэлийн үүргүүдээр зохицуулж байна.

Энэ хуулиар цагдаагийн байгууллагад хүлээлгэж байсан зарим чиг үүргийг бусад төрийн байгууллага руу шилжүүлж, заримыг нь үүргээс хассан хэдий ч бүрэн төгс шийдэж чадаагүй.

Хамгийн гол нь цагдаагийн байгууллагад Цагдаагийн албаны тухай хуулиар хүлээлгэсэн үүрэгт хамааралгүй бусад хууль тогтоомжоор хүлээлгэсэн үүргүүдийг судалж,

зарим шаардлагагүй үүргүүдийг харъяалалынх нь дагуу бусад төрийн болон төрийн бус байгууллагууд руу шилжүүлж, зарим үүргийг хасч цэгцлэх шаардлага байна.

Иймд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Ц а г д а а г и й н байгууллагад гүйцэтгэж байгаа үүргийг дахин нарийвчлан судлах,

2. Бусад хууль тогтоомжоор үүрэг болгосон заалтуудыг судалж, зарим шаардлагатай үүргүүдийг Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тусгах,

3. Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах гэсэн 2 үүрэгт байгаа зарим үүргийг дахин нарийвчлан тодруулах, тухайлбал гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүргийг төрөл мэргэжлийн албадын чиг үүрэгт нарийвчлан оруулж өгөх зэрэг болно.





ЖАГСААЛ ЦУГЛААНЫ ҮЕД НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙГ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТААР ХАНГАЖ БУЙ ИХ БРИТАНИ УЛСЫН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУРШЛАГА

Ш.Чулуун

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн
ахлах багш, цагдаагийн хошууч



Нийтийг хамарсан арга хэмжээ гэдэг нь хүмүүсийн улс төр, бие бялдар, оюуны хэрэгцээг хангах зорилготой тэдгээрийн эрх ашигт нийцсэн олон түмний оролцоотойгоор явагдаж байгаа хүний эрх, эрх чөлөө хэрэгжих, өөр хоорондоо харилцах хэлбэр бие хүн, хамт олон, нийгэм бүхэлдээ үзэл бодол, үйл хөдлөл чиглэлээ нэгтгэх арга хэрэгсэл болсон зохион байгуулалттай үйлдлийн нийлбэр юм.¹

Нийтийг хамарсан арга хэмжээ явагдаж байгаа газарт амгалан тайван байдал бүрдүүлэх зорилгоор удирдлагын тусгай штаб байгуулах, хэм хэмжээний акт гаргах, хамгаалалтын хүч нэмэгдүүлэх замаар иж бүрэн шинжтэй арга хэмжээ авч, тодорхой дэг журам тогтоон хэрэгжүүлэхэд чиглэгдсэн төр, олон нийтийн байгууллагын гүйцэтгэх захирамжлах, удирдан зохион байгуулах бүтээлч ажиллагаа мөн² гэж тус тус үндэсний эрх зүйн эх сурвалжид заасан байна.

Аливаа нэг хүн буюу асуудлын талаар өөрийн санаа

бодлоо илэрхийлэх олон нийтийн илрэл нь жагсаал, цуглаан хэмээн тодорхойлсон байдаг. Өргөн цар хүрээтэй асуудал, шалтгаанаар нэгдмэл зорилготой хүмүүс олноор цугладаг. Жагсаал, цуглаан тайван байдлаар өнгөрч байгаа ч гэсэн олон тооны хүмүүсийн хөдөлгөөн, үйл ажиллагааг зохицуулах нь цагдаагийн байгууллагад өвөрмөц асуудлыг үүсгэдэг билээ.

Эсэргүүцэлгэдэг нь явуулж буй бодлого буюу үйл ажиллагааны шалтгаанд чиглэсэн зохион байгуулалттай олон нийтийн жагсаал юм. Эдгээр эсэргүүцэл нь ихэнхдээ нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал, иргэний эрх, эрх чөлөөнд аюул, эрсдэл бий болгодог ба энэ нь хууль сахиулагч байгууллагад ямагт асуудал бий болгодог.

Олон нийтийг хамарсан жагсаал, цуглаан бий болсон үед цагдаагийн байгууллагаас нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг хэрхэн зөв оновчтой удирдан зохион байгуулан хэрэгжүүлдэг Их Британи улсын цагдаагийн байгууллагын арга барил, туршлагын талаар танилцуулъя.

Нийтийг хамарсан арга хэмжээ болон жагсаал, цуглааны үед цагдаагийн байгууллага нь

дотоодын үйл ажиллагаагаа дараах чиглэлийн дагуу зохион байгуулан хэрэгжилтийг хангаж ажиллавал үр дүнтэй арга хэмжээ болдог байна. Үүнд:³

1. Төлөвлөлт ба бэлтгэл ажил,
2. Сургалт,
3. Судалгаа, шинжилгээ ба мэдээллийн менежмент,
4. Гүйцэтгэх үүрэг ба хариуцлага /удирдлага ба хяналт/,
5. Эмх замбараагүй байдал ба хүч хэрэглэлт зэрэг болно.

1. Төлөвлөлт ба бэлтгэл ажил⁴

Нийтийг хамарсан жагсаал, цуглаан болон бусад арга хэмжээг үр дүнтэй, амжилттай зохицуулах гол түлхүүр бол төлөвлөлт ба бэлтгэл ажил юм. Хэдэн сарын дараа болох жагсаал болон гэнэт явцын дунд үүсэх байдлыг төлөвлөх хоёрын хооронд том ялгаа бий. Төрөл бүрийн хэлбэр, цар хүрээ бүхий жагсаалыг зохицуулах өөрсдийн чадварт цагдаагийн байгууллага тогтмол үнэлгээ дүгнэлт өгч, болзошгүй байдлын төлөвлөгөө хийж, албан хаагчдаа сургасан байх хэрэгтэй.

Нарийн төлөвлөлтийн ажиллагаа нь мэдээлэл дээр тулгуурласан үнэн зөв шийдвэр гаргалтын үндэс болдог. Жагсаал

³ Жагсаал цуглааныг зохицуулах цагдаагийн байгууллагын менежмент сургалт 2012 он

⁴ Жагсаал цуглааныг зохицуулах цагдаагийн байгууллагын менежмент сургалт 2012 он

¹ Д.Таванжин. Монгол Улсын Цагдаагийн эрх зүй. УБ., 2006. 36 дахь тал

² Д.Таванжин. Монгол Улсын Цагдаагийн эрх зүй. УБ., 2006. 81 дэх тал



ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

цуглааныг зохицуулахад бэрхшээлтэй тулгарсан цагдаагийн байгууллага илүү сайн төлөвлөлт хийсэн бол зарим том асуудал гарахаас зайлсхийж болох байсан гэдгийг хүлээн зөвшөөрдөг билээ.

Нарийвчлан хийсэн төлөвлөлт нь үүсч болох төрөл бүрийн асуудалд (байдал) байгууллагын дотоод нөөц бололцоог бэлтгэхэд тус нэмэр болно. Үүнийг цагдаагийн алба хаагчид олон нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангахад онцгой чухал, үндсэн гол асуудал хэмээн үздэг. Гэхдээ аливаа үйл явдлын үед өмнө нь урьдчилан төсөөлөөгүй тодорхой хэмжээний зүйлс дагалдаж байдаг. Иймээс үр бүтээлтэй төлөвлөлтийн ажиллагаанд байдал огцом өөрчлөгдөх нөхцөлд уян хатан байх төлөвлөгөө хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрч харгалзан үздэг.

Төлөвлөлтийн явцад үүсч болох нөхцөл байдал, магадлалтай асуудлуудыг тусган "Хэрвээ ингэвэл яах вэ?" гэсэн хамгийн муугаар төсөөлсөн хувилбар нөхцлийг авч үзэх ёстой юм.

Эсэргүүцэл илэрхийлэгч бүлгүүд үйл ажиллагаагаа хооронд нь илүү уялдаа холбоотой явуулах болсон тул үүнийг мөн тооцоолох шаардлагатай.

Нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал цуглаан ч гэсэн илүү хүч хэрэглэсэн өнгө аястай болж байгаа тул цагдаагийн байгууллага үүнд өөрсдийгөө бэлтгэсэн байвал зохино.

Арга хэмжээний өмнөх төлөвлөлт:

1. Арга хэмжээ болохоос өмнө зохион байгуулагч нартай

албан ёсны уулзалт хийх,

2. Эсэргүүцэл гаргаж болзошгүй бүлгүүдийг тодорхойлох,

3. Дэмжлэг туслалцаа үзүүлж чадах аюулгүй байдлыг хангах бусад байгууллагуудыг тодорхойлох,

4. Үйл ажиллагааны үед баримтлах хэм хэмжээ, тоног төхөөрөмж, хувцсыг нарийвчлан зааж өгөх,

5. Хэвлэл мэдээллийнхнийг зохицуулах, мэдээллийн стратеги бодлого тодорхойлох,

6. Уг арга хэмжээний үед баримтлах үйл ажиллагааны хэм хэмжээний тусгай зааврыг боловсруулах,

7. Нэгжүүдийн дарга нар болон тэргүүн шугамын офицерууд зэрэг бүх шатны удирдлагуудад зориулсан сургалт зохион байгуулах,

8. Туслалцаа дэмжлэг үзүүлж болох бүх оролцогч талуудтай албан ёсны уулзалт хийх. Үүнд:

- Орон нутгийн удирдагчид
- Бизнес /хувийн хэвшлийнхэн/
- Нийтийн тээврийнхэн
- Нийтийн ахуйн үйлчилгээнийхэн
- Эрүүл мэндийн байгууллагууд
- Арга хэмжээ зохиох газруудын менежер /Зочид буудал, хурлын байр г.м/

9. Удирдлага хяналтаа тодорхойлох. Үүнд:

- Үйл ажиллагааны болон тактикийн удирдлага тодорхойлох
- Хүн барьцаалахад авах хариу арга хэмжээний дүрэм журмаа дахин хянан үзэх /үйл ажиллагааны журам, хэрэглэх хүч, ямар түвшинд зөвшөөрөл хэрэгтэй болох, хүч

хэрэглэх түвшин г.м/

- Урьдчилан тодорхойлсон журмаасаа хазайх эрхийг хэнд олгох, ямар нөхцөлд зэрэг асуудлыг харгалзах
- Хууль бус цуглааны талаархи үндэсний хууль тогтоомжоо дахин сөхөж үзэх

10. Х э в л э л мэдээллийнхэнтэй харилцах төлөвлөгөө. Үүнд:

- Мэдээлэл түгээх ажиллагааны журмаа тогтох /ердийн, мэдээлэл бэлтгэж өгөх, судалгаа/
- Хэвлэл мэдээллийнхэнд эрх олгох, давуу эрх олгох үйл ажиллагааны журам тогтоох
- Хэвлэл мэдээллийнхэнтэй уулзалт зохион байгуулж хэвлэл мэдээллийн ерөнхий бодлогоо тодорхойлон хэрхэн зохион байгуулахаа ярилцах

11. Жагсаал цуглаан зохион байгуулах зөвшөөрөл олгох журмаа хянан үзэх мониторинг хийх

12. Гэмт хэрэг мөрдөх журмыг нарийвчлах

- Арга хэмжээтэй холбогдон гарах гэмт хэргийн дагуу цагдаагийн байгууллагаас ямар хариу арга хэмжээ авахаа тодорхойлох

13. Мэдээлэл цуглуулах асуудлаа хэлэлцэх. Үүнд:

- Мэдээлэл цуглуулах арга зам буюу зорилтод баг бүрдүүлэх
- Мэдээлэл цуглуулах ерөнхий цар хүрээ, удирдамж, зааварчилгаа боловсруулах. Жишээ нь:
- Мэдээлэл цуглуулах, боловсруулах асуудлыг хариуцах
- Мэдээлэл цуглуулах



хүлээн зөвшөөрөгдсөн арга барил ба тактик

- Эх сурвалжийг бий болгох
- Үнэн зөвд үнэлгээ өгөх
- Олон нийтийн дундах уур амьсгал, орчны нөхцөл
- Мэдээлэл түгээх хуваалцах
- Мэдээлэл хир үнэн болох

14. Нөөц бололцооны үнэлгээ. Үүнд:

- Гэнэтийн үед буюу нөхцөл байдал хүндрэхэд ашиглахаар бэлэн байлгах хангалттай нөөцийн төлөвлөгөө /бэлэн байдалд оруулсан анги нэгтгэлүүд, тусгай бүлэг, нэгжүүд гэх мэт/
- Арга хэмжээ болохоос өмнө цагдаагийн алба хаагчдад зохих нарийвчилсан сургалт явуулсан байх
- Урьдчилан эхлүүлсэн ажиллагааны алба хаагчдад захиргааны зохих дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах /харилцаа холбоо, тээвэрлэлт, бүртгэлд оруулах, лавлагаа авах, баривчлан саатуулах гэх мэт/
- Ар талын албанаас хариуцсан хангалтын асуудлыг боловсронгуй болгоход хувь нэмрээ оруулах төрийн бусад байгууллагуудыг тодорхойлон баталгаажуулах. Үүнд:
- Гал түймэртэй тэмцэх газар
- Түргэн тусламж
- Төрийн бусад байгууллага
- Эрүүл ахуйн байгууллага
- Прокурор
- Шүүх
- Засан хүмүүжүүлэх газар /Шүүхийн шийдвэр

гүйцэтгэх газар/

15. Ц а г д а а г и й н байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

- Албан хаагчдын хангамжийг бэлэн байлгах (хүнс, ус, сольж өмсөх жагсаал хувцас, галт зэвсэг, сум, бусад зэвсэглэл, олноор баривчлан саатуулах хэрэгсэл, нөөц авто хөсөг, шатахуун, нотлох баримтыг хянан харгалзах
- Бусад тоног төхөөрөмж хэрэгслийг бэлтгэх /хаалт, саад, хашаа/
- Хүнд техник, тээврийн хэрэгсэл зайлуулах төхөөрөмж

16. Дараах зүйлсийг багтаасан үнэлгээ дүгнэлт өгөх хариуцлагатай тогтолцоог бий болгох. Үүнд:

- Арга хэмжээний өмнөх ба дараах менежментыг зүй зохистой хийх ажлыг сайжруулах зорилгоор шийдвэр, мэдээллийг оруулах сүлжээ
- Байгууллагаас арга хэмжээнүүдийн видео журнал хийх зааварчилгаа, удирдамж

2. Сургалт⁵

Гэнэтийн үйл явдал болоод байдал сөргөөр эргэх зэрэг бүхий л төрлийн болзошгүй нөхцөл байдлыг тооцон хамгийн дээд зэргээр нарийн боловсруулсан төлөвлөгөөг цагдаагийн байгууллагаас анх төлөвлөсөн ёсоор нь нарийн чанд биелүүлэн мөрдөж ажиллах юм бол түүний жинхэн үр дүн нь гарна.

Дээд удирдлагаасаа авахуулаад анхан шатны нэгж дээрх алба хаагч хүртэл нийтлэг

⁵ Жагсаал цуглааныг зохицуулах цагдаагийн байгууллагын менежмент сургалт 2012 он

стандартын хэм хэмжээний сургалтад хамрагдсан байвал зохино. Бүх шатны нийт алба хаагчдын жагсаал цуглааны менежментын талаарх сургалт дараах зүйлсийг агуулсан байх ёстой. Үүнд:

- Үндэсний хууль тогтоомж болон байгууллагын бодлогын тухай
- Олон улсын хүний эрхийн тухай хууль тогтоомж
- Дайчилгаа, хүч хэрэглэх талаарх бодлого ба олноор баривчлан саатуулах үйл ажиллагааны талаарх нэгдмэл ойлголт,
- Өөрийгөө хянах, багаар ажиллах, удирдамжийг дагах шаардлагын тухай нарийн зааварчилгаа,
- Өндөр сахилга бат, зан байдал, өөрийгөө хянах, дүрэм журмыг чанд сахихыг эрхэмлэх,
- Дүрэм журмыг зөрчсөн тохиолдолд сахилгын шийтгэл хүлээлгэнэ гэдгийг тодорхой мэдэгдэх
- Байдлыг хурцадуулахгүй байх арга техникийн талаарх зааварчилгаа

Багаар ажиллах хандлага нь тактикийн ур чадварыг дээшлүүлэн, хувь хүн болон багийн өмнө хүлээх хариуцлагыг бий болгон, хүч хэрэглэх талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд тус нэмэр болж, үр дүн багатай хувь хүний ганцаарчилсан үйл ажиллагаа гэхээсээ багаар ажиллах нь давуу талтай гэдгийг ойлгуулдаг байна.

Баг бүрдүүлэх дасгал сургуулилтаа хийж, аврах болоод баривчлан саатуулах тактикийн арга техникийг практик дээр туршин, дадлага хийж ойлгосон байвал зохино.



Нэгж бүрдүүлэх, хөдөлгөөний явцад хариу арга хэмжээ авах техникийг амьдрал дээр хэрэглэж тийм нөхцөлд ажиллаж үзсэн байх, олон нийтийн хөдөлгөөний үед ажиллах дадлага сургуулилт хийж, хамгаалагчийг гаргаж ирэх аргыг мэддэг байх хэрэгтэй.

Багийн удирдагч болон дарга нар дараах сургалтад хамрагдсан байвал зохино. Үүнд:

- Нөхцөл байдлыг хяналтандаа авах
- Зөв зүйтэй сонголтыг хийхийн тулд нөхцөл байдал, гүйцэтгэх ажлын шугамаар олсон мэдээлэлд үнэлгээ дүгнэлт өгөх
- Тухайн нөхцөл байдал, цуглуулсан мэдээлэл, ерөнхий стратеги, бодлого дээр тулгуурлан шийдвэр гаргах

3. Мэдээлэл цуглуулалт ба мэдээллийн менежмент⁶

Болох арга хэмжээний стратегийн төлөв байдал, хэрэгцээтэй мэдээллийг олж авах найдвартай эх сурвалжийг тодорхойлон, мэдээллээр хангах үүрэг өгөх, хэрэгцээтэй ач холбогдолтой мэдээлэл цуглуулахад мэдээлэл харилцан солилцож, ингэснээр мэдээллийг харьцуулан улам нарийвчлан, эх сурвалжийг баталгаажуулах тогтмол уулзалтуудыг зохион байгуулах хэрэгтэй юм.

Энэ нь хов живийг баталгаатай тооцооноос ялган салган, гэмт хэргийн чанартай завдалт санаархлыг эсэргүүцлээ илэрхийлэх хууль ёсны үйл ажиллагаанаас ялгахад шинжээчдэд тус нэмэр болно.

Мэдээлэл авах олон нийтийн шууд бус эх сурвалжаас гадна

шууд эх сурвалжуудын сувгаар мэдээлэл тогтмол цуглуулах боломжууд байна. Үүнд:

- Интернетээс хайгуул хийх
- Нийтийн шуудан харилцаа ба хэвлэлүүд
- Цугларагсдын дунд гүйцэтгэх ажилтнуудаа оруулан ажиллуулах
- Байгууллагын дотор гүйцэтгэх ажил явуулах

Болсон үйл явдлын талаарх түүхэн баримтуудыг хадгалан үлдээхийн тулд гол арга хэмжээ, шийдвэрүүд болон авсан арга хэмжээг баримтжуулан авах хэрэгтэй. Үүнд:

- Арга хэмжээний хүрээ, цаг дарааллын баримт
- Мэдээллийн урсгалыг хянах механизм / мэдээллийн эх сурвалж, хүлээн авсан, удирдлагад дамжуулсан цаг хугацааг тэмдэглэх/
- Удирдлагын шийдвэрийн баримтжуулалт / тэмдэглэл, шийдвэрийн хронологи, хэзээ, хэн, ямар шийдвэр өгсөн болох
- Бие бүрэлдэхүүний идэвхтэй ажиллагааны зураглал, дайчлах тушаал өгсөн хугацаа болон бусад ажиглалтуудын тэмдэглэл Үүнд:
- Цугларагсдын зан байдал
- Амь насанд хүрэхээс наагуурх хэрэгсэл ба бусад зэвсэг

Нийтийг хамарсан жагсаал цуглааны үед цагдаагийн байгууллагаас хүч хэрэглэсэн тухай мэдээллийг бүртгэх стандартын хэм хэмжээг мөрдлөг болгох шаардлагатай юм. Жишээлбэл: Их Британий цагдаагийн байгууллагаас нэгэн хэрэгтэй, үр ашигтай практикийг нэвтрүүлсэн байна.

Тухайн нөхцөл байдалд боломжтой бол арга хэмжээний явц, багийн үйл ажиллагаатай холбогдуулан өгсөн тушаал шийдвэрийг цаг дарааллаар нь тэмдэглэх нэг хүнийг газар дээр ажиллаж байгаа багаас томилон ажиллуулдаг байна. /Аудио бичлэгийн хэрэгсэл ашиглах/

Дүрс бичлэгийн баталгаажуулалтыг дараах зүйлсийг баримтжуулахад бэлэн байлгах хэрэгтэй юм. Үүнд:

- Олон нийтийг зогсоох
- Өмчийн хохирол
- Гэмтэл, бэртэлт
- Баривчилгаа
- Биет /бодит баталгаа, нотолгоо/

4. Үүрэг роль, хариуцлага (Удирдлага ба хяналт)⁷

Олон нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал цуглааныг зохицуулахад тодорхой үүрэг бүхий аль болох бага шат дамжлагатай удирдлага байх нь чухал гэдгийг цагдаагийн туршлагатай ажилтнууд хүлээн зөвшөөрдөг байна.

Энэ нь дараах давуу талуудтай байдаг. Үүнд:

- Хариуцлагаа илүү сайн ухамсарладаг
- Шийдвэр гаргалт нь тодорхой байдаг
- Үйл ажиллагааны өрнөлд нийцэхүйц хариу арга хэмжээг цаг алдалгүй авдаг.

Стратеги бодлого, үйл ажиллагаа, практик гэсэн гурван үе шаттай удирдлагын нэгдмэл тогтолцоо нь газар дээрээ үр дүнтэй болох нь батлагдсан.

- Стратеги бодлогын удирдагч нь арга хэмжээний менежментын бодлогын гол зорилтуудыг

⁶ Жагсаал цуглааныг зохицуулах цагдаагийн байгууллагын менежмент сургалт 2012 он

⁷ Жагсаал цуглааныг зохицуулах цагдаагийн байгууллагын менежмент сургалт 2012 он



тодорхойлдог. Тэрээр стратеги, тактик болон практик түвшинд гарч ирэх нарийн асуудлуудыг гүнзгий ойлгодог байх ёстой.

Тэр уялдуулан зохицуулсан арга хэмжээнүүдийг боловсруулан төлөвлөж, томилсон менежерээрээ дамжуулан биелүүлэх чадвартай байвал зохино. Стратегийн удирдагч нь удирдлагын стратегийн түвшинд ажиллах ба олон нийтийн зан байдал, үйлдэлд нөлөөлхүйцээр алба хаагчдаа хянан, удирдан чиглүүлдэг удирдагч болон баг, бүлгүүдийн дарга нартай ажилладаг байна.

Тэрээр зохион байгуулагдсан сургалт, байгаа арга тактикууд, хэрэгсэл, бусад нөөц бололцоо болон нэгж дээр ажиллаж байгаа алба хаагчдын чадавхи ба дутагдалтай асуудлуудыг сайн мэддэг байх ёстой.

- Бодит үйл ажиллагааны удирдагч нь байгаа бодлогыг хэрэгжүүлэх буюу цагдаагийн хариу арга хэмжээг хэрхэн зохицуулахыг зааварчилсан шинэ бодлого боловсруулах үүрэгтэй. Нөхцөл байдалд үнэлгээ өгч, авсан шинэ мэдээллийг харгалзан, байгаа нөөц бололцоогоо үнэлэн цэгнэж, хэрэгцээ, зорилгодоо илүүтэй хүрэх зам хоёрын тэнцвэрийг олох үүрэгтэй.
- Эдгээр чиглэл, зааврыг мөн стратегийн зорилт болон үйл ажиллагааны бодлогын асуудал дээр адилхан хөндөн авч үзнэ. Тактикийн удирдагчийг дуудан тодорхой

үйл ажиллагаа буюу дайчилгааны асуудлаар ерөнхийдөө богино хугацаанд шийдвэр гаргахыг үүрэг болгодог.

Олон нийтийг хамарсан жагсаал, цуглааны үед тусгай бүлгийнхэн онцгой үүрэг гүйцэтгэдэг. Гэхдээ цагдаагийн байгууллага эдгээр нэгжийг хэрхэн ашиглах асуудалд болгоомжтой хандах хэрэгтэй юм. Үүнд:

- Дугуйтай эргүүл (машин тэргийг бодвол) шуурхай хариу арга хэмжээ авч тэдний имиж дүр төрх эсэргүүцэгчид, жагсагчдад эмзэглэл, айдас төрүүлдэггүй
- Химийн бодистой тэмцэх багууд
- Дэмжлэг үзүүлэх багууд (тэдгээрийг ажиллагаанд оруулахдаа ихэд болгоомжтой байх хэрэгтэй. Жагсагчид нь цагдаагийн дэмжигч багт хохирол учруулахыг оролдож мэднэ.
- Тусгай зэвсэгт багууд
- Баривчилгааны багууд.

Том арга хэмжээний үед харилцаатай байх, радио холбоогоор хангах нь хүндрэлтэй байдаг. Дараах зүйлсийг ямагт анхааралдаа байлгавал зохистой юм. Үүнд:

- Стратеги, тактик болон үйл ажиллагааны удирдагч нарыг харилцаа холбооны тусгай сувагтай байлгах шаардлагатай
- Нэг буюу түүнээс дээш сувгийг нэгж, газар дээр нь ажиллаж байгаа алба хаагчдад
- Цагдаагийн ердийн үйл ажиллагаанд тусгай суваг
- Тодорхой, богино код,

тушаал ашиглах

- Шуурхай албаныханд /гал, эмнэлэг гэх мэт/ харилцаа, холбооны нэгдсэн суваг

5. Эмх замбараагүй байдал ба хүч хэрэглэл⁸

Цугларсан хүмүүс тоо хэмжээ, бүрэлдэхүүн болон зан байдал, үйлдлийнхээ хувьд хурдан өөрчлөгдөж болно. Болзошгүй байдлын төлөвлөгөө буюу журам заавраа нөхцөл байдлыг шийдвэрлэж чадахуйцаар хийнэ. Эдгээр бодлого болон үйл ажиллагаа нь тод томруун байх ёстой.

Эгнээ бий болгох, тулааны хэсгүүд, өнцгөөр урагшаа явах, хагас хөдөлгөөн, хяналтан дор нэвтрэн гарах, түрж гаргах зэрэг цагдаагийн нэгж хэсгүүдийг олноор цугларсан хүмүүсийн эсрэг зөв зохион байгуулан оруулвал энэ нь эмх замбараагүй байдлыг хяналтандаа авахад хамгийн их хэрэглэгддэг практик ажиллагаа юм.

Цагдаагийнхныг аливаа нэгэн хэлбэрээр нь оруулах шийдвэр гарвал алба хаагчдын аюулгүй байдлыг хангах зохих арга хэмжээ авах зүй зохистой дэмжлэг байх ёстой.

Жишээ нь: Тухайн хэсэг эсрэг талаасаа дайралтанд өртөхөөс хамгаалагдсан байх ёстой. Энэхүү ажлын хүрээнд дохионы гар бөмбөг, резинен болон хуванцар сум, нулимс асгаруулагч зэргийг хэрэглэхээс гадна гал унтраах баг, усан буу зэргийг аюулгүй байдлын хүрээнд бэлэн байлгана.

Нэгж бүлгүүдийг ашиглах нь цаашид үр бүтээлтэй сонголт болж чадахгүй болсон тохиолдолд нөгөөтэйгүүр эмх замбараагүй болсон

⁸ Жагсаал цуглааныг зохицуулах цагдаагийн байгууллагын менежмент сургалт 2012 он



ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

хүмүүс цагдаагийн хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс татгалзвал хүмүүсийг олноор баривчлан хүч хэрэглэх шаардлагатай болдог.

Олноор баривчилгаа хийхэд цагдаагийн байгууллагаас авч буй хариу арга хэмжээ нь нөхцөл байдалд дүйцсэн, зөв арга хэмжээ юу гэдэг асуудал тулгарна. Бүхий л авч болох арга хэмжээг аваад амжилтанд хүрээгүй буюу онцгой нөхцөлд амжилтгүй болохоор байвал олноор баривчилгаа явуулахыг зөвшөөрдөг байна.

Сургалтаар баривчилгаа хийх хоёр нөхцлийг онцолсон байна. Үүнд:

- Цагдаа орчноо хяналтандаа байлгаж баривчилгаа буюу хүчээр тараах ажиллагааг төлөвлөх цаг хугацаатай бөгөөд хяналтан доор явуулах боломжтой үеийн баривчилгааны тактик /суугаа эсэргүүцлийн үед/
- Цагдаа орчноо хянаж чадахгүй байгаа үеийн баривчилгааны тактик

Шахалт үзүүлэх арга техник, зөв зүйтэй гавлалт болон баривчилгааны арга хэрэглэн эсэргүүцэгчдийг хүнлэг ёсоор сугалан авахдаа эсэргүүцэгчид болон цагдаагийн алба хаагчдаас гэмтэл, бэртэл авах эрсдлийг аль болох гаргахгүй байх тал дээр анхаарна. Гэхдээ заримдаа байгаа хүч хэрэгслээ баривчилгаанд зориулахгүй байх нь зөв зүйтэй арга хэмжээ болдог.

Хүч хэрэглэлт нь бодлогоор зохицуулагддаг. Хүч хэрэглэлтийг олныг хамарсан жагсаал, нийтийн арга хэмжээнд тохируулан нарийвчилж боловсронгуй болгох ёсгүй юм.

Хэв журмын нөхцөл байдал хүндрэхэд хариу болгон хүч хэрэглэлтийг нэмэгдүүлэх онол нь аюул заналхийлэлд дүйцэхүйц, тохирохуйц байхад чиглэгдсэн байна.

Арга хэмжээ болохоос өмнө заавар чиглэл, үүрэг өгөх, бүх алба хаагчдад оролцооны журам болон удирдлагын шатлалыг нарийн ойлгуулсан байна. Явагдах ажиллагаа болгоны өмнө болзошгүй хувилбаруудыг хэлэлцэн туршиж, гадна болох хүч хэрэглэлтийн түвшиний талаар нэгдмэл ойлголтыг өгсөн байна.

Стандартын техник хэрэгслийг ашиглахдаа зөв ашиглалт, хэрэглэлт, алба хаагчийн ур чадвар талаас нь шалган үзэх хэрэгтэй. Сургалтаар хүч хэрэглэх бодлогыг сэргээн үзэж, алба хаагчийн мэдлэг, ур чадварыг бодитоор үзэх хэрэгтэй.

Алба хаагчийн ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэхэд бороохой, бамбайтай ажиллах тогтмол сургалтыг явуулах хэрэгтэй. Эмх замбараагүй байдал үүсч, хүчирхийлэл нэмэгдэхэд амь насанд хүрэхээс наагуурх /аминд халгүй зэвсэг/ техник, тусгай хэрэгслийг хэрэглэдэг.

Ийм хэрэгсэл ашиглахаасаа өмнө цагдаагийн алба хаагч нь дараах зүйлийг анхаарна. Үүнд:

- Уг хэрэгсэл нь тэргүүн эгнээнд байгаа алба хаагчдад учрах аюулыг бага зэрэг зайлуулж, зорилгоо биелүүлэх боломжийг дахин олгож буюу хадгалан үлдэх бололцоог олгож байгаа эсэх
- Дээрх зүйлийн дэргэд энэ нь боломжтой, тэнцвэртэй,

нийцэхүйц арга хэмжээ мөн эсэх.

Амь насанд хүрэхээс наагуурх хэрэгсэл /аминд халгүй зэвсэг/ ашиглаж байгаа буюу ашиглах гэж байгаа бол дараах үндсэн зааварчилгаа удирдамжийг заавал санаж явах шаардлагатай. Үүнд:

- Түүний хэрэглээ нь тэргүүн эгнээнд байгаа алба хаагчдад учирч байгаа аюул заналхийлэл болон тэдний гүйцэтгэхийг оролдож байгаа үүрэгтэй харьцуулвал дүйцэхүйц байх ёстой
- Хүссэн үр нөлөөнд хүрэх хүртэл уг сонголтыг ашиглана.
- Хэрэглээнд байнга үнэлгээ өгч ашиглалтыг үргэлжлүүлэх эсэхийг баталгаажуулна
- А ш и г л а х ы г з ө в ш ө ө р с ө н т э й холбогдуулан удирдагч үр нөлөө, тухайн сонголтын хязгаарлалтуудын талаар нарийн мэдлэгтэй байх ёстой
- Амь насанд аюул учирч болохуйц эрсдэлтэй газар үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:
- Хэрхэн ашиглах талаарх иж бүрэн сургалтанд хамрагдаж тогтмол явагдах давтан сургалтад оролцсон байх
- Тухайн сонголтын хүчин чадлын талаар бүрэн ойлголттой байх
- Тухайн сонголтын хязгаарлалтын талаар бүрэн ойлголттой байх
- Нөхцөл байдал ингэхийг шаардаж байгаа бол



ашиглах, эс ашиглах
талаарх эцсийн шийдвэр
гаргах эрхтэй байх

Биет хаалтыг эмх замбараагүй байдлыг зохицуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор олонтой ашигладаг боловч энэ нь бие бүрэлдэхүүнийг орлодоггүй. Саад, хаалтыг ашиглах нэн тэргүүний зорилго нь:

- Эмх замбараагүй байдалд шилжсэн иргэдийн хөдөлгөөнийг хянах
- Хориотой буюу эмзэг газруудад байгаа гудамж, байшин, барилга руу нэвтрэхээс урьдчилансэргийлэх
- Эсэргүүцэгч иргэдийг тодорхой урсгал чиглэл

рүү хөтлөн оруулах

Эсэргүүцэгчид, босогчид хаалтыг авч хаяхыг оролдож болзошгүй тул хаалт саад нь хүндрүүлсэн, хамгаалалттай байх шаардлагатай.

Дүгнэлт:

Монгол Улсын цагдаагийн байгууллага нь олон нийтийг хамарсан жагсаал цуглаан, эмх замбараагүй байдлын үеийн хэв журам, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ дэлхийн хөгжилтэй болон хөгжингүй орнуудын арга барил, тэргүүн туршлагаас судлан түүнд үнэлгээ дүгнэлт өгч, улмаар өөрийн орны онцлог, эрүүгийн болон


хэв журмын нөхцөл байдалд тохирсон шинэлэг дэвшилтэт үйл ажиллагааг албанд мөрдлөг болгож ажиллах шаардлагатай байна.

Ингэснээр нэг талаас олон улсын жишиг стандартанд нийцсэн цагдаагийн албаны үйл ажиллагааг баримтлах, нөгөө талаас НҮБ-ын эрх зүйн баримт бичиг болон үндэсний хууль тогтоомжид тусгагдсан хүний эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцлийг бий болгох чухал алхам болох юм.



ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ
АЖЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТҮҮХЭН ХӨГЖИЛТ

Д.Бямбахуу

*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн
тэнхимийн багш, докторант, цагдаагийн хошууч*

Эрэн сурвалжлах гэдэг үгийн үндэс болох эрэх гэдэг үгийг Монгол хэлний товч тайлбар тольд “мэдье, олъё гэж хайх сурвалжлах, эрэх сурах, эрж хайх, эрж сурвалжлах гэсэн хоршоо үг”¹ гэснээс үзэхэд аливаа зүйлийг мэдэх эсхүл олох зорилгоор тодорхой этгээдээс хийх үйлдэл буюу үйл ажиллагаа байна.

Цагдаагийн байгууллагын хөгжлийн явцад гэмт хэрэгтэй тэмцэх ажил нь шинэ арга хэлбэр буй болгож ирсний үр дүнд цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ажиллагаа үүсч, улмаар өсөн хөгжиж улам боловсронгуй болж ирсэн.

1911 оны Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн ялж, Богд хаан нэгдсэн захиргаа, дүрэмгүй тархай бутархай байсан цагдаагийн албыг шинэчлэн байгуулж, дүрэм хэмжээг тогтоох зарлиг буулгаж, улмаар олноо өргөгдсний зуравдугаар оны 12 сард “Нийслэл хүрээний тойрон газруудыг цагдан сэргийлэх дүрэм”-ийг баталсан. Энэ

¹ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.1966

дүрмийн 16 дугаар зүйлд “Аливаа цагдан сэргийлэгчид нийслэл хүрээний булаах хулгайлах ба хүний аминий зэрэг хүнд хөнгөн хэрэг өдүүлэхгүйг хичнээн шамдан машид чандлан сэргийлбээс зохино. Хэрэв энэ мэт хэрэг илэрхий гарч ирвээс уг ялт ардыг оргон зайлж холдон одох хэрхэхийн урьд эрхгүй хүчлэн гавишгайлан дайчлан бариулж батлан харяат албаны газраа хүргүүлж уламжлан учрыг гаргаж дээд яамнаа мэдүүлэн хүргэж гүйцэтгэн шийтгүүлсүгэй. Хааяа битүү хулгайн учир нэргүй ба оргон зайлагчдыг санаа сүвэгчлэн эд зан мөрөөр сурвалжлан эрх үгүй хичнээн хүчлэн олж гүйцэтгэн шийтгүүлбээс зохино”² хэмээн эрэн сурвалжлах ажлын эрх зүйн үндсийг тусгаж өгсөн.

1919 онд Хятадын генерал Сюй-Шу-Чжан монголын эрх мэдлийг гартаа авсны дараагаар “Хүрээний цагдан сэргийлэх хорооны зохиосон хууль” гэгчийг боловсруулсан. Уг хуулийн 4.2-т цээрлүүлэх засгийн салбар дор цээрлүүлэн үзэх, сурвалжлан барих, нигүүлсгэх сайн явдал (урьдчилан сэргийлэх) галыг сөнөөх, хамаг засгийн (эрхийг) явуулах эл хэргийг

² Д.Таванжин. Монголын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт түүний хөгжилт. УБ., 2000. 14 дэх тал

шийтгэмой³, мөн хуулийн 5 дугаар зүйлд “Салбар хороон дор жинхэнэ цагдагч нэг хүнийг зохиож (томилж) тус хорооны зарлалыг эрхэлж зүүн зээлийг цээрлүүлэн үзэх сурвалжлан барих, амьтныг хамгаалах, галыг сөнөөх, нигүүсгэх сайн явдлыг эл хэргийг захиран шийтгэмой”⁴ гэж тус тус заажээ.

1921 оны 7 дугаар сарын 19-нд Засгийн газрын 6 дугаар хуралдаанаар цагдаагийн байгууллагыг Цэргийн яамны дэргэд “Сэргийлэх цэрэг” нэртэйгээр байгуулж, улмаар дүрмийг боловсруулах ажлын хэсэг байгуулж, 1923 оны 6 дугаар 26-ны өдрийн Засгийн газрын 18 дугаар хуралдаанаар “Нийслэл хүрээний цагдан сэргийлэх хорооны дүрэм, хэмжээ”-г баталсан.

“Нийслэл хүрээний цагдан сэргийлэх хорооны дүрэм, хэмжээ”-ний 26 дугаар зүйлд “Цахилгаан утас ба цахилгаан гэрлийн багана мод ба утас зүйлийг цаггүй цагдан байцааж, хааяа эвдэх хулгайлах нь буй авбаас эрхгүй даруй түргэнээ сурвалжлан байцаан барьж, шүүх явдлын яамнаа

³ Д.Таванжин. Монголын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт түүний хөгжилт. УБ., 2000. 22 дах тал. Хүрээний цагдан сэргийлэх хорооны зохиосон хууль.

⁴ Энэ хуулийг Цагдаагийн ерөнхий газрын музейгээс судлаач Д.Таванжин уйгаржин бичгээс хөрвүүлсэн.



мэдүүлж хургүүлж нягтлан шийтгүүлбээс зохимой”, 27 дугаар зүйлд “Аливаа хулгай худал ба булаан уулаглах жич хүний аминий зэрэг тохиолдвоос харьяа ялт хүнийг даруй түргэнээ санаа сүвэгчлэн байцаан барьж, шүүх явдлын яамнаа мэдүүлэн хургүүлж, шүүх шийтгүүлвээс зохимой”.

1924 онд Улсын анхдугаар хуралдаанаар Цагдан сэргийлэхийг Цэргийн яамны харьяанаас гаргаж, Дотоод яамны харьяанд Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрыг байгуулсан. 1926 оны 1 дүгээр сарын 15-нд баталсан БНМАУ-ын Цагдан сэргийлэх газрын дүрмийн 61 дүгээр зүйлд “Аливаа хулгай худал ба булаан уулаглах жич хүний аминий зэрэг тохиолдвоос харьяа ялт хүнийг даруй түргэнээ санаа сүвэгчлэн байцаан барьж, шүүх явдлын яамнаа мэдүүлэн хургүүлж, шүүх шийтгүүлвээс зохимой”.

1926 оны 5 дугаар сарын 12-ны хуралдаанаар цагдан сэргийлэхийг орон нутагт байгуулахыг түдгэлзүүлж, УЦСЕГ-г татан буулгаж, Улаанбаатар хотын захиргааны харьяанд Цагдан сэргийлэх хэлтэс байгуулж, “Цагдаа бүхий хэсгийг оргодол ба ноцтой гэмт хэргийг эрж баривчлах, шоронд хоригдосдыг харгалзаж байх” үүрэгтэйгээр Шүүх яаманд шилжүүлсэн бөгөөд 1929 онд Цагдан сэргийлэх газрын дагж явах дүрмийг баталсан.

Уг дүрмийн 35 дугаар зүйлд “Аливаа алдагдал мал буюу жич янагш чанагш явах хүмүүс бие дор авч явсан ба тээн явсан юм зүйлийг гээгдүүлэх нь тохиолдвоос даруй уул эзэн хүн дор таниулан тушаан өгмөөс зохимой. Хэрэв эзэн хүнд дав

дув эс олдвоос зохих газраа мэдүүлж данслуулан уг зүйлийг сайнаар хадгалуулж, нэгэн тээгүүр учрыг тодорхойлон нийтэд зарлаваас зохимой”, 45 дугаар зүйлд “Аливаа хулгай худал ба булаан уулаглах жич хүний аминий зэрэг тохиолдвоос харьяа ялт хүнийг даруй түргэнээ санаа сүвэгчлэн байцаан барьж, шүүх явдлын яамнаа мэдүүлэн хургүүлж, шүүх шийтгүүлвээс зохимой” гэж тус тус заасан.

Цагдаагийн байгууллагын шуурхай эрэн сурвалжлах ажиллагаа нь улсыг аюулаас хамгаалах байгууллагын арга туршлагаар анх үүсч хөгжсөн түүхтэй. 1921-1932 онд цагдаагийн байгууллага нь Бүх цэргийн зөвлөл, Дотоод яам, Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны харьяа Цагдан сэргийлэх хороо, хэлтэс, газар байжээ. Энэ үед гүйцэтгэх ажил гэж байсангүй. Харин 1932 онд Дотоодыг хамгаалах газрын харьяанд шилжүүлэн авснаар Цагдан сэргийлэх байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг Дотоодыг хамгаалах газрын эсэргүүцэн тагнах үйл ажиллагааны туршлагаар “нууц далд аргаар явуулах” болжээ.⁶

Шуурхай эрэн сурвалжлах үйл ажиллагааг нууц аргаар тусгай хүч хэрэгслээр зохиох анхны аппарат 1934 онд “Эрүүгийн эрэн сурвалжлах тасаг” гэж байгуулагдсан бөгөөд 1936 оны 9 дүгээр сард Гүйцэтгэх хэлтэс болон өргөжсөн байна.

Цагдаагийн байгууллагын шуурхай эрэн сурвалжлах ажиллагааг эрүүгийн хэргийг эрэн сурвалжлах өмч ашиглан

⁵ А.Думбарай. БНМАУ-ын ЦСБ-ын зарим эрхийн актууд УБ. 1988 он.

⁶ А.Думбарай, С.Рэнцэнхорлоо. БНМАУ-ын ЦСБ-ын түүх. УБ. 1984 он.

шамшигдуулагчидтай тэмцэх, насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх албадын гүйцэтгэх ажилтнууд эрхэлдэг байсан.

1950-иад оноос цагдан сэргийлэх байгууллагын бэхжүүлэх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлсний дүнд Цагдан сэргийлэх байгууллагыг Улсын цагдан сэргийлэх ерөнхий газар болон өргөтгөсөн.

БНМАУ-ын Дотоод явдлын яамны харьяа Улсын цагдан сэргийлэхийн дүрмийг 1955 оны 3 дугаар сарын 29-ний өдөр баталсан. Дүрмийн 3 дугаар зүйлд улсын цагдан сэргийлэхийн үүргийн тусгасан ба уг зүйлийн Ж-д “16 хуртэл насны багачууд ба бусад хүмүүс алга болж тэднийг гэмт хэрэг буюу цаг бусын аюулд хэлмэгдсэн гэж үзэх үндэс байвал уг хүмүүсийг эрэн сурвалжлана”, дүрмийн 6 дугаар зүйлийн Ж-д “Гэмт хэрэгт сэрдэгдсэн буюу хорих газраас оргон зугтсан хүмүүсийг мөрдөн хөөх ба эрэн сурвалжлах гэмт хэрэг өдүүлэх ба мөн олон нийтийн байдалд аюул учруулах явдлыг таслан зогсоох эрүүгийн хэргийг мөрдөн байцаахад эрүүгийн байцаан шийтгэх хуульд заагдсан ажиллагааг гүйцэтгэх, буу зэвсэг дэлбэрэх материал ба бодисыг хадгалах журмыг хэрхэн сахиж байгааг шалгах, паспортын журмыг хэрхэн сахиж байгааг шалгах зэрэг цагдан сэргийлэх байгууллагуудын эхлэх ажил хамаарагдах бусад асуудлын талаар хүмүүсийн орон сууц, албан үйлдвэрийн газар, байгууллагуудаар нэвтрэн орно”⁸.

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1963 оны 10 дугаар

⁷ А.Думбарай. БНМАУ-ын ЦСБ-ын зарим эрхийн актууд УБ. 1988 он.

⁸ А.Думбарай. БНМАУ-ын ЦСБ-ын зарим эрхийн актууд УБ. 1988 он.



сарын 25-ны өдрийн 499 дүгээр тогтоолоор БНМАУ-ын цагдан сэргийлэх байгууллагын дүрмийг шинэчилэн баталсан. Энэ дүрмээр Цагдан сэргийлэх байгууллагын хэрэг бүртгэх болон шуурхай эрэн сурвалжлах ажилтай холбогдсон эдлэх эрх, үүргийг тодорхойлсон байна.

Энэхүү дүрмийн ерөнхий анги буюу 2 бүлэгт цагдан сэргийлэх байгууллагын үүргийг тусгажээ. Уг бүлгийн 4 дүгээр зүйлд “Хойно заасан хүмүүс ба эд хөрөнгийг эрэн сурвалжлана.”

А. Мөрдөн байцаалт ба шүүхийн байгууллаг тэрчлэн эрүүгийн ба захиргааны шийтгэлийг эдэлж буй газраас оргон нуугдагчид

Б. Хүүхэддээ хууль ёсоор тэтгэвэр төлөх явдлаас зайлсхийн нуугдсан хүмүүс

В. Улс, олон нийтийн байгууллага, ард иргэдийн хулгайлагдсан эд хөрөнгө

15-р зүйлд гэнт алга болсон хүмүүс нь гэмт хэрэг буюу аюул осолд хэлмэгдсэн гэж үзэх үндэстэй байдал тапнийг эрэн сурвалжилна.

27-р зүйд Хулгайд алдагдсан ба оргон зугтсан гэмт этгээдэд ашиглагдсан авто машин, мотоцикл болон тээврийн бусад механикжсан хэрэглүүрийг эрэн сурвалжлана.

Монгол Улсад социалист нийгмийн сүүлийн жилүүдэд цагдан сэргийлэх байгууллагын зохион байгуулалт үйл ажиллагааг үндсээр нь өөрчлөн сайжруулж боловсронгуй болгох шаардлага хурцаар тавигдах болсон. “БНМАУ-ын цагдан сэргийлэх байгууллагын үндсэн үүрэг, эрхийн тухай” 96 зарлигийг АИХТ-ээс гаргаж, улмаар 1985 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн Сайд

нарын зөвлөлийн 95 тогтоолоор “БНМАУ-ын цагдан сэргийлэх байгууллагын дүрэм”-ийг баталсан. Дүрэмд “Гэмт хэрэг түүнийг үйлдсэн этгээдийг олж илрүүлэх, урьдчилан сэргийлэх таслан зогсоох зорилгоор зайлшгүй шаардлагатай шуурхай эрэн сурвалжлах үйл ажиллагааг явуулах”, “Эрэн сурвалжлах, мөрдөн байцаах ажиллагаа явуулах тухай прокурор мөрдөн байцаагчаас БНМАУ-ын ЭБШ хуулийн дагуу өгсөн заалт, даалгаварыг биелүүлэх мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахад тэдэнд тус дэмжүүлэг үзүүлэх”, “Мөрдөн байцаалт шүүхээс оргосон яллагдагч, шүүгдэгч, шүүхийн таслан сэргийлэх тогтоол биелүүлэхээс зайлсхийсэн ялтан сураггүй алга болсон, хүүхдийн тэтгэвэр төлхөөс болон улс хоршоолол олон нийтийн байгууллагууд төлөх их хэмжээний өр төлбөрөөс зайлсхийсэн хүмүүс, түүнчлэн улс хоршоолол олон нийтийн байгууллага, иргэдийн хулгайлагдсан хөрөнгө алдагдсан буюу гээгдсэн байлдааны болон бусад галт зэвсэгийг эрэн сурвалжлах” гэж үүрэг болгосон⁹.

Эндээс үзэхэд, БНМАУ-ын Үндсэн хууль, БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, БНАМУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн холбогдох зарлиг, НАХЯ-ны болон Улсын цагдан сэргийлэх байгууллын дүрмийн заалтад эрэн сурвалжлах ажил явуулах эрх зүйн үндсийг тусгаж, шуурхай эрэн сурвалжлах ажиллагаа явуулах нарийвчилсан зохицуулалтыг Цагдан сэргийлэх байгууллагын эрэн сурвалжлах

ажлын тухай заавар, нэгдсэн тоо бүртгэлийн заавар, цагдан сэргийлэх байгууллагын эрэн сурвалжлах ажлын заавар, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах тухай заавар, гэмт хэрэг илрүүлэх ажлыг зохион байгуулах үндсийн тухай дүрэм, эрүүгийн хэрэг үүсгэх, мөрдөн байцаалт явуулах хамтын ажиллагааны тухай зааварт тодорхойлсон байна.

1987 оны Цагдаагийн байгууллагын шуурхай эрэн сурвалжлах ажлын зааварт “Цагдаагийн байгууллага шуурхай эрэн сурвалжлах үйл ажиллагаандаа БНМАУ-ын хуулиуд, цагдаагийн байгууллагын үндсэн үүрэг, эрхийн тухай БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлиг, цагдан сэргийлэх байгууллагын дүрэм болон энэхүү заавар, НАХЯ-ны сайд, УЦСЕГ-ын даргын тушаал, албан даалгаварыг удирдлага болгоно” гэжээ.¹⁰

Монгол Улсад 1992 онд ардчилсан Үндсэн хуулиа баталж, улмаар 1993 онд УИХ-аас Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийг баталсан. Уг хуулийн 12-р зүйлд “Цагдаагийн байгууллага сураггүй алга болсон хүн, оргон нуугдсан сээжигтэн яллагдагч, шүүгдэгч, ялтан болон шүүхээс даалгасан бусад хүнийг эрэн сурвалжлана”¹¹ гэж эрэн сурвалжлах ажлын эрх зүйн үндсийг заажээ.

2013 онд УИХ-аас баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн 9.2.2-т “гэмт хэрэг, зөрчил гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэрэг,

⁹ Д.Таванжин. Монголын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт түүний хөгжилт. УБ., 2000 он.

¹⁰ А.Думбарай, С.Рэнцэнхорлоо. БНМАУ-ын ЦСБ-ын түүх. УБ. 1984 он.

¹¹ Цагдаагийн байгууллагын тухай хууль. УБ. 1993 он.



зөрчлийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах”, 12 зүйлд “цагдаагийн байгууллагын захиргааны үүрэгт 12.1.6.эрх бүхий байгууллага, албан тушаалтны даалгаснаар сураггүй алга болсон хүн, гээгдэл эд хөрөнгийг эрэн сурвалжлах” гэж тус тус заасан.

Энэ бүхнээс үзэхэд, цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ажиллагааны эрх зүйн хэм хэмжээ нь цагдаагийн байгууллагын хөгжилтэй салшгүй холбоотой байжээ. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг БНМАУ-ын АИХТ-ээс гаргасан зарлиг, Сайд нарын зөвлөлөөс баталсан цагдан сэргийлэх байгууллагын дүрэм зэрэг эрх зүйн актуудаар тогтоож,

эдгээр эрх зүйн актад үндэслэн эрэн сурвалжлах ажиллагааг зохицуулсан хэм хэмжээг НАХЯ, УЦСЕГ өөрсдийн эрх хэмжээний хүрээнд тогтоож байжээ.



МОНГОЛ УЛСАД ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГА, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРУУДЫН ХАМГААЛАЛТАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

А.Гансүх

ХСИС-ийн магистрант, цагдаагийн хошууч



Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан олон эрх зүйн акт, мөрийн хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байсан боловч түүхэнд хамгийн чухал үүрэг гүйцэтгэсэн нь тухайн үеийн төр, түүний төлөөллийн байгууллагуудаар батлагдан гарсан дүрмүүд байна.

Тэдгээр дүрмүүдийн нэг болох “Цагдан сэргийлэх эрх хэмжээний дүрэм”¹ нь 1923 онд батлагдаж, цагдан сэргийлэхийн гүйцэтгэх үүрэг, зорилтыг хуульчлан баталсан тодорхойлсон.

Уг дүрэмд “Олон Улсын Элчин Консулыг хамгаалах нь цагдан сэргийлэхийн үүрэг” гэж зааснаар Орос улсын Тувагийн консулыг хамгаалалтанд авч, 1924 оны 6 дугаар сарын 2-нд анхны Монгол Улсын банк байгуулагдсанаар цагдаагийн харуул хамгаалалтын буюу тус хэлтсийн цаг тооллын алтан хуудас эхэлжээ.²

¹ Д.Таванжин. Монголын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний хөгжилт. УБ. 2000. 28 дахь тал

² Л.Очирхуяг. Цагдаагийн ажилтны гарын авлага. УБ. 2005. 4 дэх тал

Нийтийн хэв журам хамгаалах газрын Дипломат байгууллага, банкны хамгаалалтын хэлтсийн Дипломат байгууллага хамгаалах тасаг нь Монгол Улсын Үндсэн хууль, 1961 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр баталсан Венийн конвенци, Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 135, 2007 оны 223 дугаар тогтоолын дагуу Монгол улсад суугаа элчин сайдын яамны халдашгүй онц бүрэн эрх, Дипломат төлөөлөгчдийн үүрэгт ажлаа явуулах таатай нөхцлийг бүрдүүлж аюулгүй байдлыг хангах үүргийг гүйцэтгэж ирсэн.³

Өнөөдөр ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах газрын харьяа Дипломат байгууллага, банкны хамгаалалтын хэлтэс нь Банкны тухай хууль⁴, Монгол улсын Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 17 дугаар зүйл, Монгол Банкны Ерөнхийлөгч, Цагдаагийн Ерөнхий газрын хамтарсан 1993 оны 3/281, 246 дугаар тушаалаар баталсан “Монгол банкны хамгаалалтын журам”, Засгийн газрын 2004 оны 135 дугаар тогтоолын хавсралтын 3 дахь хэсгийн 1 дэх зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 100 дугаар тогтоол “Цагдаагийн хамгаалалтанд байх объектын жагсаалт батлах

³ Дипломат байгууллага, банкны хамгаалалтын хэлтэс. УБ. 2013. 8 дахь тал

⁴ Төрийн мэдээлэл. 2010. №7

тухай”-д заасны дагуу Монгол банк болон бусад арилжааны банкны аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.⁵

Монгол Улсын Засгийн газраас гаргасан шийдвэрийг удирдлага болгон Монгол Улсын Сангийн яам, Хууль зүйн яам, ЦЕГ-ын бодлого чиглэлийг хэрэгжүүлэх үүднээс Монгол банк болон бусад арилжааны банкуудын хамгаалалтыг Дипломат байгууллага банкны хамгаалалтын хэлтсийн банкны гэрээт тасаг нь хариуцан ажиллаж байгаа бөгөөд банкны хамгаалалтын тасаг нь Монгол банк болон бусад арилжааны банкны харуулын 9 постонд 24 цагаар, өдрийн 5-н постонд 8 цагаар үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд ЦЕГ-ын даргын 2011 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 490 дугаар тушаалаар НХЖХГ-ын Дипломат байгууллага банкны хамгаалалтын хэлтэс болгон өөрчлөгдөн ажиллаж байна. Одоогийн байдлаар хамгаалалтын тасагт 9 буюу 11.6% нь дээд, 1 буюу 1.2% нь тусгай дунд, 67 буюу 87% нь бүрэн дунд боловсролтой албан хаагчид ажиллаж байна. Түүнчлэн, хүйсийн хувьд авч үзвэл, 4 буюу 5.1% нь эмэгтэй, 73 буюу 94.8% нь эрэгтэй, 19-48 насны албан хаагчид байна.⁶

⁵ Дипломат байгууллага, банкны хамгаалалтын хэлтэс. УБ. 2013. 8 дахь тал

⁶ Дипломат байгууллага, банкны хамгаалалтын хэлтсийн 2014 оны



Бид Дипломат байгууллага, банкны хамгаалалтын албан хаагчдаас хамгаалалтын үйл ажиллагаа явуулж буй нөхцөл байдлын талаар судалгаа авахад тулгамдаж байгаа дараах хэд хэдэн нөхцөл байдал хамгийн хүнд асуудал болоод байна гэж тэд үзсэн байна. Тухайлбал,

- Харуул хамгаалалт хийж байгаа албан хаагчийн байрлаж буй байр нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй байгаа;

/харуулын байрны талбайн хэмжээ хүрэлцэхгүй, төвлөрсөн ус дулаангүй, хооллох, гар угаах, бие засах газаргүй, хүйтэн гэх мэт/

- Хоол хүнсний хангалт хүртээмжгүй;

/1300 төгрөг нь хоногийн хоол хүсэнд хүрэлцдэггүй/

Түүнчлэн, 2011 онд Нийтийн хэв журам хамгаалах газрын Дипломат байгууллага, банкны хамгаалалтын хэлтсийн Монгол Улсад суугаа гадаад улсын элчин сайдын яам, НҮБ-ын суурин төлөөлөгчийн газрын хамгаалалтанд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нарын 23 ажлын байранд Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраар ажлын байрны эрүүл ахуйн дүгнэлт, Хөдөлмөрийн нөхцөл мэргэжлийн өвчин судлалын төвөөр хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэсэн байна.

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөрийн улсын байцаагчийн 2011 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 05-145/1711 дугаар дүгнэлтэнд цагдаагийн харуулын байрны харьцангуй чийглэгийн хэмжээ 0.6-0.8 хувиар зөвшөөрөгдсөн хэмжээнээс бага, ажлын харуулын байрны талбайн хэмжээ хүрэлцэхгүй, төвлөрсөн ус дулаангүй, хооллох, гар угаах,

танилцуулгаас хэсэгчилэн авав.

бие засах газаргүй нөхцөлд ээлжийн үүрэг гүйцэтгэж байгаа нь Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага MNS:4990:2000 стандартын шаардлага хангаагүй, ажлын байр нь алба хаагчдын өвчлөлттэй холбоотой⁷ гэж дүгнэлт гаргасан. Өөрөөр хэлбэл, “Хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн өвчин судлалын үндэсний төв”-ийн хөдөлмөрийн нөхцөлийн дүгнэлтээр тус байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл болон ажилтан ажиллуулаагүйгээс ажиллагсдын хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, ажлын зохистой орчныг бүрдүүлэх, хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар тусгах санал боловсруулах, шаардагдах зардлыг тухайн жилийн төсөв төлөвлөгөөнд тусгуулах ажил хангалтгүй байгаа нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”⁸-ийн 28.2.1 дэх заалт, “Зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив батлах тухай” Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2008 оны 126 дугаар тушаал, заавар хэрэгжихгүй байгаа тухай дүгнэлтэндээ тусгасан байгаа нь хамгаалалтын үйл ажиллагаанд тулгамдаж байгаа асуудлын нэг болоод байна.

Өнөөдөр дипломат байгууллагуудыг хамгаалж байгаа харуул хамгаалалтын байрууд нь жижиг давчуу

⁷ Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Л.Долгорсүрэнгийн хийсэн 2011 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 05-145/1711 дугаар дүгнэлтээс хэсэгчилэн авав.

⁸ Төрийн мэдээлэл. 2008. №28

(2x1.5м) хэмжээтэй байгаа нь “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Дэлгэц бүхий тоног төхөөрөмжтэй ажиллах эрүүл ахуй, эргономиклийн ерөнхий шаардлага” MNS 5027:2001 стандартад “Нэг хүнд оногдох талбайн хэмжээ 6м², эзэлхүүн 20м³-аас багагүй байна” гэсэн тус стандартын шаардлагад нийцэхгүй байна. Харуул хамгаалалтын байр нь хана, цонхоороо дулаан алдалт ихтэй, өвлийн улиралд хүйтэн, зуны улиралд халуун байдаг нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 18.1.1 дахь заалт хэрэгжихгүй байна гэсэн үг юм.

Түүнээс гадна Америкийн элчин сайдын харуул хамгаалалтын 2 дугаар байраас бусад ажлын байрууд нь угаалтуур, бие засах газар, ариун цэврийн өрөөгөөр хангагдаагүй байгаа нь Монгол Улсын Үндсэн хууль⁹ийн 16.2-ийн “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах боломжоор хангагдах”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль”¹⁰-ийн 18.1.1-ийн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд ажиллах” гэсэн заалтууд тус тус хэрэгжихгүй байгаагаас гадна эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангагдахгүй байна.

Харуул хамгаалалтын байруудын халаалтыг цахилгаанаар ажилладаг хуурай тенээр шийдсэн боловч Франц, БНСУ-ын ЭСЯ-ны харуул хамгаалалтын байрны тень эвдэрч ажлын байр хүйтэн (гадаа 23⁰С) байгаа нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 18.1.1 дахь

⁹ Төрийн мэдээлэл. 1992. №1

¹⁰ Төрийн мэдээлэл. 2008. №28



заалт болон цахилгааны аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөж байна.

Харуул хамгаалалтын цагдаа нарт ажлын хариуцлага, үүргийн дагуу хариуцсан байраа орхиж явахыг хориглодог учраас цагтаа хооллох, бие засахад хүндрэлтэй байдаг зэргээс өдрийн хоол идэлгүй олон цагаар ажилладаг нь “Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль”¹¹-ийн 75.3-д заасан “Ажил, үүргийн онцлогоос шалтгаалан завсарлах боломжгүй ажилтай ажилтныг ажил олгогч хооллох бололцоогоор хангана” гэсэн заалт зөрчигдөж байгаа төдийгүй, ажиллагсадад хоол боловсруулах эрхтэн системийн өөрчлөлт, өвчлөл үүсэх магадлалтай нь Хөдөлмөрийн чадвар түр алдах өвчлөлийн судалгаагаар хоол боловсруулах тогтолцооны өвчин эхний байранд орсон байгаагаас харагдаж байна.

ЦЕГ-ын даргын тушаалаар шөнийн цагт ээлжинд гарч байгаа ажиллагсадад хоолны мөнгө 1300 төгрөгийг олгож байгаа нь хүнсний бүтээгдэхүүн өдрөөс өдөрт өссөж байгаа энэ үед халуун хоол, эрүүл хүнсэнд хүрэлцэхгүй байгаа нь Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай хууль”¹²-ийн 18.1.1-ийн

“Үндсэн цалингийн хэмжээг тогтоох, нэмэгдүүлэх, түүний хэлбэр, олгох хугацаа, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшил, нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, олговрын хэмжээ, хөдөлмөрийн норм, нормативыг тогтоох, өөрчлөх, ажилтанд олгох хоол, унааны зардал болон бусад нөхөх олговрын хэмжээг тогтоох” заалт зөрчигдөж байна.

Түүнчлэн, хамгаалалтын байруудад ус буцалгагчийг байруулсан боловч ундны болон ахуйн усны найдвартай эх үүсвэрээр хангагдаагүй зөөврөөр хэрэглэдэг нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж хэмжээ болох 1 хоногт хэрэглэх ундны усны хэмжээ, норм /15-25л/-д хүрэхгүй байна гэсэн зөрчлүүд гардаг.

Дипломат байгууллагуудын хамгаалалтанд ажиллаж байгаа албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулсанаар хамгаалалтын үйл ажиллагааны үр нөлөө дээшилж, зөрчил дутагдал гарах нь буурна гэж үзэж байна.

Тиймээс Дипломат байгууллагуудын хамгаалалтанд ажиллаж байгаа алба хаагчдын үйл ажиллагааг сайжруулах, хамгаалалтын чанар үр нөлөөг дээшлүүлэх үүднээс дараах хэдэн саналыг дэвшүүлж байна.

Үүнд:

1. Дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын хамгаалалтын стандартыг Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журам, зааварт нийцүүлэн шинэчлэн боловсруулах,

2. Шөнийн цагт ээлжийн үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдад хоолны мөнгө 1300 төгрөгийг олгож байгааг өөрчилж, зах зээлийн үнийн өөрчлөлт, хүнсний бүтээгдэхүүн өдрөөс өдөрт өссөж байгаатай уялдуулан Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хуулийн¹³ 18.1.1-д заасныг үндэслэн шинэчлэн тогтоох,

3. Д и п л о м а т байгууллагуудыг хамгаалж байгаа харуул хамгаалалтын байруудыг “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Дэлгэц бүхий тоног төхөөрөмжтэй ажиллах эрүүл ахуй, эргономиклийн ерөнхий шаардлага” MNS 5027:2001 стандартад “Нэг хүнд оногдох талбайн хэмжээ 6м², эзэлхүүн 20м³-аас багагүй байна” гэсэн тус стандартын шаардлагад нийцүүлэн шинэчилсэн стандарт загварын хамгаалалтын байрны төслийг шинэчлэн боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх зэрэг болно.

¹¹ Төрийн мэдээлэл. 1999. №25

¹² Төрийн мэдээлэл. 2001. № 2

¹³ Төрийн мэдээлэл. 2001. № 2





НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН ХЭЛБЭР, ТҮҮНИЙГ ШИНЖИХ НЬ

Ц.Адъяацэрэн

ХСИС-ийн Удирдлагын сургуулийн сонсогч, цагдаагийн хошууч



1980-аад оны эцсээр Монгол Улсад өрнөсөн ардчилсан хөдөлгөөний үр дүнд Монгол Улсын нийгмийн байгуулал бүхэлдээ өөрчлөгдөн шинэчлэгдэж, өнөөдөр дэлхий нийтийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн хөгжил дэвшлийн замаар хөгжиж байна.

Нутгийн өөрөө удирдах ёсны буюу нутгийн өөрөө удирдахбайгууллага нь хүн төрөлхтөний түүхтэй салшгүй холбоотой.

Орон нутгийн амьдрал олон талтай, аймаг, нийслэл, сум, дүүрэг бүрт өөр өөрийн гэсэн өвөрмөц асуудал өдий төдийгөөр үүсч гардаг. Түүнийг өөрөө удирдах ёсны субъект болохын хувьд тэндэхийн иргэд жилдээ биш, “өдөр тутам” шийдвэрлэх хэрэгцээ бий.

Гэвч аймгаараа, сумаараа цуглараад байх боломж үгүйн учир тэдэнд өөрсдийн төлөөлөгчдийн хийгээд түүнийг “хураангуйлсан” байгууллага, бас ажлын мэргэшсэн алба зайлшгүй хэрэгтэй болдог.

Энэхүү бодит шаардлагыг харгалзан Монгол Улсын Үндсэн хуулиар орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын гурван үндсэн хэлбэрийг тодорхойлсон.¹Үүнд:

а. Аймаг нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал,

б. Баг, хорооны иргэдийн нийтийн хурал,

с. ИТХ-ын болон ИНХ-ын Тэргүүлэгчид зэрэг болно.

Эдгээр нь орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага мөн гэдгийг Монгол Улсын Үндсэн хууль²-ийн 59-р зүйлийн 2 дахь хэсэгт бататган заажээ. Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Иргэдийн нийтийн хурал бол төрийн биш, олон нийтийн ч бус харин Үндсэн хуулийн биеэ даасан институт байгуулал мөн.

Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Иргэдийн нийтийн хурал нь нийтийн ажил хэргийг төрийн өмнөөс бус харин тухайн нутаг дэвсгэрийн нэгжийн иргэдийн өмнөөс эрхлэн шийдвэрлэж хэрэгжүүлдэг. Тиймээс ч Монгол Улсын Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлийн 2-т “Орон нутгийн өөрөө удирдах байгууллага” хэмээн заасан байна. Түүнчлэн, мөн хуулийн 62 дугаар зүйлийн 1-д хурал нь нутаг дэвсгэрийн

хэмжээний асуудлыг “бие дааж шийдвэрлэх”, улсын чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг “оролцуулах” гэсэн нь өөрөө удирдах ёсны болон төрийн чиг үүргийн заагийг тогтоосон хэрэг мөн. Бас орон нутагт төрийн үйлчилгээг үзүүлэхэд оролцох буюу түүнийг шилжүүлснээр энэ үүргийг биелүүлдэг.

Бид Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга болон Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын хамтран ажилласан 2013-2014 оны үйл ажиллагаанд нь дүн шинжилгээ хийх гэж оролдлоо.

2012 оны 11 дүгээр сарын 15-нд НИТХ-ын ээлжит бус тавдугаар хуралдаан болсон бөгөөд уг хуралдаанд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл “2013-2016 оны үйл ажиллагааныхаа хөтөлбөр”³-ийн төслийг танилцуулж батлуулсан байна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн мөрийн хөтөлбөр нь НИТХ-ын ээлжит сонгуульд нийслэлийн Ардчилсан намын боловсруулж орсон мөрийн хөтөлбөр дээр суурилжээ.

Үйл ажиллагааны хөтөлбөрийг Үндсэн хуульд заасанчлан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг

¹ Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. тэргүүн дэвтэр. УБ., 2002

² Төрийн мэдээлэл. 1992. №1

³ <http://ulaanbaatar.mn/content/show/3395>



хангах төрийн үүргийг сэргээн тогтоох үндсэн зорилготой гэдгийг Нийслэлийн Засаг дарга хуралдаан дээр танилцуулсан байна.

Юуны өмнө авлигын сүлжээг тасалж, нийслэлийн төр захиргааны байгууллагуудыг ил тод, нээлттэй болгох, аливаа шийдвэрийг иргэдийн оролцоонд тулгуурлаж гаргадаг тогтолцоонд шилжүүлэхэд үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтуудыг чиглүүлсэн нь мөрийн хөтөлбөрөөс харагдаж байна.

Уг хөтөлбөрийн 4 дүгээр хэсэгт “Аюулгүй, амгалан Улаанбаатар” гэсэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дараах үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн байна. Тухайлбал,

4.1. Хотын аюулгүй байдлыг ханган, хэв журмыг сахиулах чиглэлээр:

4.1.1 Архи, тамхи үйлдвэрлэх, худалдан борлуулахад тавих хяналтыг чангатгаж, хэрэглээний соёлыг төлөвшүүлнэ.

4.1.2 Төсвийн мөнгөөр архи, согтууруулах ундаа худалдаж авахыг хориглоно.

4.1.3 Гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээнд гардаг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн идэвхи санаачлагад суурилсан “хөршийн хамгаалалт” амгалан тайван байдлын тогтолцоо бүрдүүлнэ.

4.1.4 Хэв журам сахиулах, гэмт хэрэг ба захиргааны зөрчилтэй тэмцэх ажлыг хотын удирдлага шууд хариуцна.

4.1.5 Мансууруулах бодисын хорт нөлөөг таниулан, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.

4.1.6 Нийслэлийн хэмжээнд

гэмтхэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, нийслэлийн цагдаагийн байгууллагыг шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана.

4.1.7 Гэмт хэрэгтэй тэмцэхэд олон улсын туршлага, шинэ технологи, арга барилыг нэвтрүүлнэ.⁴

Эндээс уг хөтөлбөрийн 4.1.4-д тусгасан “Хэв журам сахиулах, гэмт хэрэг ба захиргааны зөрчилтэй тэмцэх ажлыг хотын удирдлага шууд хариуцна” гэсэн заалт онцгой анхаарал татаж байна.

Монгол Улсын Үндсэн хууль⁵-ийн 61.1-д “Засаг дарга тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг төрийн төлөөлөгчийн хувьд харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, дээд шатны Засаг даргын өмнө хариуцна” хэмээн тодорхойлсон байдаг билээ.

Тэгвэл Цагдаагийн албаны тухай хуулийн 6.5-д⁶ “Энэ хуулийн 6.4-г заасан хотын цагдаагийн байгууллагын даргыг цагдаагийн төв байгууллагын даргатай зөвшилцөн хотын захирагч томилно” гэсэн заалт байгаа нь нутгийн захиргааны удирдлагаас нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын даргыг томилохоор тусгасан нь нутгийн удирдлагын эрх мэдлийг цагдаагийн хуульд тусгасан анхны тохиолдол гэж үзэж болно.

Мөн хуулийн 13.5-д зааснаар “Нийтийн хэв журам

хамгаалах газар нь хуулийн 13.1-д зааснаас гадна бусад чиг үүргийн хүрээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах 13.5.5-д заасан “нутгийн захиргааны болон төрийн бус байгууллагаас зохион явуулж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах” арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Улаанбаатар хотын цагдаагийн байгууллага нь Монгол Улсын Засгийн газрын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2013 оны зорилт, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар санал боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлснээр Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэс, Багануур дүүргийн цагдаагийн хэлтсийн барилгыг шинээр барихад 7.5 тэрбум төгрөг, парк шинэчлэлтэд зориулж, эргүүлийн 75, жижүүрийн 37 автомашин худалдан авах 2.3 тэрбум, гудамж талбайг камержуулах 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлсэн байна.⁷

Энэ нь нутгийн захиргааны байгууллагаас нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын Цагдаагийн албаны тухай хуулиар⁸ хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгэх нөхцөл боломжийг хангаж байгаагийн нэг тод илрэл гэж үзэж болно.

Гэхдээ үүнд менежментийн

⁴ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хөтөлбөр. УБ. 2013. 5 дахь тал

⁵ Төрийн мэдээлэл. 1992. №1

⁶ Төрийн мэдээлэл. 2013. №29

⁷ Нийслэлийн цагдаагийн газрын 2013 оны үйл ажиллагааны тайлангаас хэсэгчилэн авав.

⁸ Төрийн мэдээлэл. 2013. №29



цогц бодлого дутагдаж байна гэж үзэж болох юм. Учир нь зөвхөн нийслэлийн хэмжээнд энэ ажил төсөв хөрөнгийн боломжтойгоор явагдаж байгаа бол хөдөө орон нутагт хөрөнгө мөнгөний хомсдолоос төдийлөн үр дүнтэй, өргөн хүрээг хамарсан хэлбэрээр явагдаж чаддаггүй билээ.

Нийслэлийн Засаг даргын 2012 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Улаанбаатар хотын авто замын ачааллыг зохицуулах нэмэлт зарим арга хэмжээ авах тухай” А/724 дугаар захирамжийг хэрэгжүүлэх чиглэлээр Энхтайвны өргөн чөлөөнд “Офицеруудын ордноос Таван шар”-ын автобусны зогсоол хүртэл хэв журмын болон замын хөдөлгөөний хянах хяналтын камерыг суурилуулж, угсрах 1.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий тендерт “Смарт слюшнз”, “Сек Тек сервис” ХХК-иудын түншлэл шалгарч, 22 автобусны буудал дээр хэв журмын нөхцөл байдлыг хянах, Саппорогийн тойрог, баруун, зүүн 4 замын уулзварууд дээр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хянах, Энхтайвны өргөн чөлөөнд зорчих хэсгийн нэгдүгээр эгнээний байрлал, замын хөдөлгөөнийг бүхэлд нь хянах, тээврийн хэрэгслийн дугаарыг санах зориулалт бүхий хяналтын камеруудыг суурилуулан, Улсын комисст хүлээлгэн өгсөн байна.⁹

Энэ нь “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль¹⁰-ийн 7 дугаар зүйлд заасан “бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн нутаг дэвсгэр дээр гарч байгаа гэмт хэрэг, түүний шалтгаан

нөхцөлийг арилгах талаар харьяа нутаг дэвсгэрт оршиж байгаа аж ахуйн нэгж, байгууллагаас зохиож байгаа ажлыг хэлэлцэн чиглэл өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг хянан батална” гэсэн заалт болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчын 2012-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн 4.1.6-д заасан “Нийслэлийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, нийслэлийн цагдаагийн байгууллагыг шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана” гэсэн заалтууд үр дүнтэй хэрэгжиж байна гэж үзэж байна.

Түүнчлэн, 2013-2014 онд Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нь тус цагдаагийн газрын парк шинэчлэлтэд зориулан хөдөлгөөнт эргүүлийн 75, жижүүрийн шуурхай албаны 24 автомашин худалдан авах 2 тэрбум 347.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шийдвэрлэж өгсөн бөгөөд уг шалгаруулалтын тендерт “Киа моторс Монгол” ХХК шалгарч, 2013 оны загварын “Киа Рио” маркийн суудлын 75 автомашиныг дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдэд хуваарилан өгч, хөдөлгөөнт эргүүлд ажиллуулсан байна.

Мөн жижүүрийн шуурхай албаны автомашин нийлүүлэх тендерт шалгарсан “Монгол Хьондай Автоматив” ХХК дунд оврын туулах чадвар сайтай Туссон жип маркийн 12 автомашин, хүн тээврийн зориулалттай 2013 оны загварын 12 хүний суудал бүхий Старекс маркийн 12 микроавтобусны

тусгай тоноглолыг хийж гүйцэтгэн, хүлээлгэн өгсөн, Чингэлтэй дүүргийн Засаг даргын 60 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тус дүүргийн цагдаагийн хэлтэс Киа Рио маркийн 2 ширхэг суудлын автомашин, бүрэн тоноглолтой УАЗ Фургон маркийн автомашин 1 ширхэгийг тендерт шалгарсан “Хурд авто” ХХК, “Киа автоматив” ХХК-иас худалдан авч, хүлээлгэн өгсөн байна.

Дээрхи хөрөнгө оруулалтаар шийдсэн ажлууд нь нутгийн захиргааны байгууллагаас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн¹¹ 7 дугаар зүйлд заасан үүргийн хүрээнд хэрэгжүүлж байгаа ажил бөгөөд энэ нь цагдаагийн байгууллагын нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллаж байгаагийн нэг том илрэл гэж үзэж болох бөгөөд зөвхөн нийслэлийн хөрөнгө оруулалт 2 тэрбум 347.0 сая, дүүргээс 60 сая, нийтдээ 2, 4 тэрбум гаран төгрөгт хүрсэн байдлаар нь харж болно.

Нийслэлийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 2014 онд Улаанбаатар цагдаагийн газартай маш өргөн хүрээнд хамтран ажилласан байна.

Нийслэлийн Засаг даргын 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.1-д заасан “Жуулчдыг гэмт халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, жуулчидтай холбоотой гарсан гэмт хэрэг зөрчлийг шуурхай шийдвэрлэх зорилгоор Нийслэлийн цагдаагийн газрын бүтцэд Жуулчны цагдаагийн нэгж байгуулна” гэсэн ажлын хүрээнд Нутгийн захиргааны байгууллага, нийслэлийн

⁹ Нийслэлийн цагдаагийн газрын 2013 оны үйл ажиллагааны тайлангаас хэсэгчилэн авав.

¹⁰ Төрийн мэдээлэл. 1998.№ 1

¹¹ Төрийн мэдээлэл. 1998.№ 1



харьяа агентлагуудаас авсан арга хэмжээний талаар санал, хүсэлтийн дагуу Нийслэлийн цагдаагийн газрын даргын 2014 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/183 тоот тушаалаар “Ажлын хэсэг” байгуулан ажиллаж, Монголын оюутны холбоотой зөвшилцөн “Оюутан цагдаа”-гаар ажиллах оюутнуудад тавигдах шаардлага, ажиллах журмыг боловсруулан, 2014 оны 7 дугаар сарын 5, 6-ны өдрүүдэд бүртгэлийн арга хэмжээг зохион байгуулж, шаардлага хангасан гадаад хэлний мэдлэг бүхий эрэгтэй-34, эмэгтэй-54, нийт 88 оюутныг Цагдаагийн ерөнхий газрын Сургалт дадлагын төвд холбогдох хууль, эрх зүйн анхан шатны мэдлэг болон хэрхэн аюулгүй байдлаа хангах, харилцааны соёлын талаар мэдлэг олгох 40 цагийн сургалтанд хамруулан, хөдөлмөрийн гэрээ байгуулж хамтран ажилласан нь нутгийн захиргааны байгууллага, цагдаагийн байгууллагын хамтран хэрэгжүүлсэн томоохон ажил болсон билээ.

Хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу оюутан-цагдаа нарын ажлын нэг цагийг 3500 төгрөгөөр тооцон өдөрт 4-6 цагаар ажиллуулж, цагийн тооцоог тухай бүр нэгтгэн холбогдох цагдаагийн хэлтсүүдээс нэгтгэн авч, Олон нийтийн цагдаагийн ажилтанд олгох төсөвлөгдсөн хөрөнгөнөөс нийт 57.013.530 / тавин долоон сая арван гурван мянга таван зуун гуч/ төгрөгний урамшууллыг шийдвэрлүүлэн олгожээ.

Энэ хугацаанд Үндэсний их баяр наадмын өдрүүдэд гадаадын иргэд жуулчдаас гэмт хэрэгт өртөж хохирсон 2 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх

онтой харьцуулахад 7 нэгжээр буюу 88.8 хувиар буурсан байна. Түүнчлэн, арга хэмжээ хэрэгжсэн хугацаа буюу 2014 оны 7, 8 дугаар сарыг өмнөх онуудын мөн үетэй харьцуулахад нийслэл хотын хэмжээнд гадаадын иргэдээс үйлдсэн гэмт хэрэг 3 буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6-10 нэгжээр тус бүр буурсан, гэмт хэрэгт өртөж хохирсон иргэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2012 оны мөн үеэс 2 нэгжээр буюу 6.5 хувиар буурсан, 2013 оны мөн үеэс 2 нэгжээр буюу 7.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.¹²

Тоон мэдээнээс харахад арга хэмжээ хэрэгжих үед гудамж талбай, олон нийтийн газарт гадаадын иргэд, жуулчдаас гэмт хэрэг халдлагад өртөж хохирсон тохиолдол 12 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4-7 нэгж буюу 25-36 хувиар буурсан, гэмт хэрэг үйлдсэн гадаадын иргэд 1 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1-2 нэгжээр буюу 33-50 хувиар буурсан үзүүлэлттэй гарч байна.

Энэ нь Монгол Улсад хүрэлцэн ирэх гадаадын иргэд, жуулчдын аюулгүй байдлыг хангах төдийгүй иргэд олон нийт, оюутан, сурагчдыг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулж тухайн арга хэмжээг уламжлан болгон өргөтгөн зохион байгуулж ажиллах боломж бололцоо бий байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, эдгээр үйл ажиллагааны зардлыг Нийслэлийн иргэдийн хурлын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зохицуулах зөвлөлийн нөөц

¹² Нийслэлийн цагдаагийн газрын 2014 оны үйл ажиллагааны тайлангаас хэсэгчилэн авав.

хөрөнгөнөөс гаргасан нь дээрхи 2 байгууллагын хамтын ажиллагаа зохих түвшинд явагдсан гэж үзэж болохоор байна.

Түүнчлэн, Нийслэлийн цагдаагийн газар нь 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.2-д заасан “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлнэ” гэсэн ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал,

2014 онд Олон нийтийн цагдаагийн ажилтан арга хэмжээний зардалд 956 сая төгрөг, Хууль зүйн яамнаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд 86 сая төгрөг, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах зөвлөлөөс “Лидер студент” сэтгүүл, “School police” арга хэмжээнд 34 сая төгрөгийг зарцуулжээ.

Мөн 2013 оны төсвийн хэмнэлтийн урамшуулал 126.8 сая төгрөг, хүү, торгуулийн орлогыг давуулан биелүүлсэний урамшуулал 16.7 сая төгрөг орж ирсэнийг зохих журмын дагуу зарцуулсан байна.

ЦЕГ-ын даргын 2014 оны 568 дугаар тушаалаар батлагдсан “Олон нийтийн цагдаагийн ажилтны дүрэм”-ийн хэрэгжилтийг хангахаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас төсөв хөрөнгийн шийдвэрлэж өгснөөр 2014 оны 7 дугаар сараас эхлэн дүүргүүдээс судлагдсан 190 иргэнийг эрүүл мэндийн нэгдсэн үзлэг, сэтгэл зүйн ярилцлага, сургалтад хамруулах ажлыг зохион байгуулж гэрчилгээ олгон 9 дүүргийн 17 цагдаагийн



хэлтэст 172 иргэнийг томилж, гэрээ байгуулан, хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэмт хувцсаар ханган ажиллуулсан байна.¹³

Дээрх дурдсан бүх ажлуудыг нэгтгэн авч үзээд нутгийн захиргааны байгууллага, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хамтын ажиллагааны хэлбэр дараах байдлаар илрэн гарч байна. Үүнд:

- Цагдаагийн байгууллага ажиллах нөхцөл байдлаа сайжруулах, техник хэрэгсэл авах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулахад шаардагдах төсөв хөрөнгийг нутгийн захиргааны байгууллагаас төсөвт суулгуулан замаар санхүүгийн эх үүсвэрээ шийдвэрлэдэг;

Энэ нь харилцан адилгүй байна. Улаанбаатар хотод хамгийн их буюу 2.4 тэрбум байгаа бол дүүрэгт 60 сая, хөдөө орон нутагт 10-20 сая орчим төгрөг дунджаар орон нутгийн төсөвт суулгаж ашигладаг байна.

- Засаг даргын дэргэдэх мэргэжлийн хяналтын байгууллагуудтай хамтарч төрөл бүрийн чиглэлээр шалгалтанд хамтарч оролцдог;

¹³ Нийслэлийн цагдаагийн газрын 2014 оны үйл ажиллагааны тайлангаас хэсэгчилэн авав.

Тухайлбал, худалдаа, үйлдвэр, үйлчилгээний үйл ажиллагаанд тавих хяналт, нохой устгал болон тодорхой аж ахуйн нэгж, байгууллагууд руу чиглэсэн хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх журмын хэрэгжилтанд тавих тусгай хяналт шалгалт гэх мэт.

- Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, харьяа төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулж буй олон талт арга хэмжээнд оролцох;

Тухайлбал гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцлийг арилгах чиглэлээрхи хурал, зөвлөлгөөн, уулзалт, хэлэлцүүлэг, спорт, урлагын арга хэмжээнд хамтран оролцдог байна.

- Нутгийн захиргааны байгууллага болон нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагаас төрөл бүрийн төсөл, хөтөлбөр боловсруулж, түүнийгээ эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар батлуулан хэрэгжүүлэх,

- Нутгийн өөрөө удирдах байгууллага буюу Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаас гаргасан нийтээр дагаж мөрдөх журмыг сахиулах ажилд оролцож, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах;

Харин удирдлага, зохион байгуулалтын тал дээр нутгийн

захиргааны байгууллага, цагдаагийн байгууллагын хамтын ажиллагаануудыг судалж үзэхэд ихэвчлэн нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг дарга удирдлага, зохион байгуулалтыг гардан удирдахаар эрх зүйн зохицуулалтандаа тусгасан байдаг.

Энэ нь хууль тогтоомждоо тусгасан байдгаас үүдэлтэй бөгөөд нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагаас нутгийн захиргааны байгууллагуудтай харилцан, хамтран ажиллах чиглэлээр санал, санаачлага гаргаж, түүнийг нь хамтран хэрэгжүүлэх байдлаар 2 байгууллагын хамтын ажиллагаа нь явагдаж ирсэн гэж үзэж болохоор байна.

Нөгөө талаараа нутгийн захиргааны байгууллага, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын хоорондын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын нэгдсэн менежментийн бодлого орон нутгийн онцлогоос хамаараад өөр өөр байгаа нь төрөөс тэдгээр байгууллагуудын хамтын ажиллагаанд нэгдсэн нэг бодлогоор хангаж байгаа мэт харагдаж байгаа боловч түүний хэрэгжилтэнд тавих хяналт зохистой үр дүнд хүрэхгүй байна гэж үзэж болохоор байна.



ТӨР, ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ**ЗАХИРГААНЫ ХУУЛЬ БУС АКТААС УЧИРСАН ГЭМ ХОРЫГ
АРИЛГУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ХЭРГИЙН ХАРЬАЛАЛ***Ц.Мөнхдэлгэр**Сутай дээд сургуулийн ахлах багш, өмгөөлөгч, магистр*

Захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус акт нь иргэн хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөж, эдийн болон эдийн бус хохирол учруулж байдаг бөгөөд Захиргааны хууль бус актын улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг Захиргааны хэргийн шүүх эсхүл Иргэний хэргийн шүүхэд хандаж гаргах уу гэдэг нь хэргийн харьяалалын нэг гол асуудал болдог. Сүүлийн жилүүдэд дээрхи Захиргааны хууль бус актаас учирсан гэм хорыг арилгуулахтай холбоотой хэргийн тоо өсөж харьяалалын талаар анхаарах шаардлага бий болж байна. Захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаан мөн эсэхийг тогтоох гол шалгуур нь нийтийн эрх зүйг хувийн эрх зүйгээс ялгаж ойлгох явдал юм. Хувийн эрх зүйн маргааныг ерөнхий харьяалалын шүүх, харин нийтийн эрх зүйн маргааныг захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэнэ.

Захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус ажилагааны улмаас учруулсан гэм хорыг иргэн, хуулийн этгээд арилгуулах эрх нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р дугаар зүйлийн 14-т “...бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх...” эрхтэй хэмээн заасан байдаг.¹ Энэхүү эрхээ хууль зүйн тодорхой зохицуулалтын дагуу эдэлдэг.

Гэм хор учруулсан гэх захиргааны актыг хууль бусад тооцуулах, хүчингүй болгуулах нь захиргааны маргаан бөгөөд үүнийг Захиргааны хэргийн шүүхээс харьяалан шийдвэрлэдэг. Харин тухайн хууль бус гэж тооцсон захиргааны актаас учирсан гэм хорыг арилгах, нөхөн төлүүлэх шаардлагын үр дагавараас хамаарч уг маргааныг захиргааны хэргийн эсхүл иргэний хэргийн шүүх шийдвэрлэх харьяалалтай байна.

Гэм хор үүсэх хууль зүйн факт нь олон шалтгаан нөхцөлтэй байж болно. Тухайлбал, хууль бус захиргааны актын улмаас, гэмт хэргийн улмаас, гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас г.м. Гэм хорыг арилгуулах асуудлыг шүүхээс авч хэлэлцэхдээ тухайн гэм хор үүсэх шалтгаан болсон факттай нь хамт шийдвэрлэхээр

¹ Монгол Улсын Үндсэн хууль 2 дугаар бүлэг 16 дугаар зүйлийн 14

хуулийн зохицуулалтанд тусгасан байдаг. Жишээ нь: Гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн хохирол хүлээсэн иргэн, хуулийн этгээд нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд тэрхүү нэхэмжлэлийг уг хэргийн хамт тухайн шүүхээс хянан шийдвэрлэдэг.

Харин эрүүгийн хэрэгт иргэний нэхэмжлэл гаргаагүй, эсхүл гаргасан нэхэмжлэлийг хэлэлцээгүй орхисон бол иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын дагуу хохирогч тал нэхэмжлэл гаргах эрх нээлттэй байдаг.

Харин захиргааны актаас учирсан гэм хорыг арилгуулах нэхэмжлэлийн шаардлагыг харьяалан шийдвэрлэхдээ үүнтэй төсөөтөй зарчмыг баримтлахаар хуульчилжээ. Үүнд:

1. ЗХХШТХ-ийн 32.5.3-д заасанчлан нэхэмжлэлд маргаан бүхий захиргааны акт нэхэмжлэгчийн ямар эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн болон түүнээс үүдэн гарсан хохирлын тухай тусгана.² Мөн энэ тухай 2009.3.10-ны өдрийн “Улсын дээд шүүхийн

² ЗХХШТХ-ийн 32.5.3



зөвлөмж”-д тусгажээ.

2. ЗХХШТХ-ийн 70.4-д шүүхийн шийдвэр гаргахдаа захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны улмаас нэхэмжлэгчид хохирол учирсан нь тогтоогдвол нөхөн төлүүлэх ба хохирлын хэмжээний талаар маргаан гарсан бол иргэний хэргийн шүүхээр шийдвэрлүүлнэ гэж зохицуулсан байна.³ Мөн энэ тухай 2005.4.6-ны өдрийн “Улсын дээд шүүхийн зөвлөмж”-д тусгажээ.

Дээрхи зохицуулалтыг дараах байдлаар ойлгож хэрэглэж болох талтай байна.

1. Захиргааны хууль бус актаас учирсан гэм хорыг арилгуулах шаардлага нь захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэлийн бие даасан шаардлага болж чадахгүй. Харин захиргааны тухайн акттай нь холбогдуулан хамтад нь авч хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх боломжтой байдаг.

2. Захиргааны хэргийн шүүх захиргааны актаас учирсан хохирлын талаар шийдвэр гаргах нөхцөл нь юуны өмнө хохирлын хэмжээний талаар талуудын хооронд маргаан гараагүй байх явдлаар тодорхойлогдож байна.

3. Захиргааны хэргийн шүүх уг асуудлыг шийдэх нөхцөл бүрдвэл нөхөн төлөх хохирлын хэмжээ, хэлбэр зэргийг тогтоохдоо Иргэний хуулийн “Гэм хорыг арилгах” 18-р бүлэг, “Гэм хор учруулснаас үүсэх үүрэг” 52-р бүлгийн заалтуудыг баримтлан шийдвэрлэнэ.

4. Захиргааны актаас учирсан хохирлын хэмжээний талаар маргаан гарсан бол холбогдох нэхэмжлэлийг иргэний хэргийн шүүхэд хандана. Захиргааны хэргийн

шүүхээс захиргааны тухайн актыг хууль бус гэж тооцсон шийдвэр гарсан тохиолдолд иргэний хэргийн шүүхээс зөвхөн хохирлын хэмжээ, түүнд холбогдох асуудлаар шийдвэр гаргана.

Захиргааны хууль бус актаас учирсан хохирлыг ердийн буюу иргэний хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх боломжтой юм. Ингэхдээ хохирлын хэмжээний тухай ямар нэг маргаан гараагүй тохиолдолд Захиргааны хэргийн шүүх шийддэг байна.

Захиргааны албан тушаалтны учруулсан гэм хорыг арилгуулахтай холбогдон үүссэн хэргийн харьяаллыг тогтооход дараах хүчин зүйлүүдийг анхааран үзэх шаардлагатай байна.

- Захиргааны албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэж байхдаа, эсхүл хувь этгээдийн хувьд эрх зүйн харилцаанд оролцож байгаад бусдад учруулсан гэм хорыг арилгуулах нэхэмжлэл нь хэргийн харьяаллын хувьд өөр өөр байна.

Захиргааны албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэж байхдаа бусдын нэр төр, алдар хүндийг хөндсөн акт гаргах, эсхүл захиргааны хууль бус актаас иргэн, хуулийн этгээдэд хохирол учруулах тохиолдлууд нь нийтийн эрх зүйн харилцаанд хамаарах тул хохирлын хэмжээний талаар маргаан гараагүй бол Захиргааны хэргийн шүүхээс шийдвэрлэнэ. Харин уг гэм хор учруулсан үйлдлийг захиргааны албан тушаалтан хувь хүний хувьд хийсэн, эсхүл хийхээс татгалзсан бол хувийн эрх зүйн харилцаа гэж үзэж хэргийн ерөнхий харьяалалтай шүүхээс шийдвэрлэнэ. Тухайлбал: Захиргааны албан

тушаалтан амралтын өдөр замын хөдөлгөөнд оролцож байгаад бусдад гэм хор учруулсан бол тухайн албан тушаалтан замын хөдөлгөөнд хувь этгээдийн үүднээс оролцож байгаа нь тодорхой тул хувийн эрх зүйн харилцаанд хамаарах тул маргаан гарвал иргэний хэргийн шүүхээс шийдвэрлэнэ.

- Захиргааны албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэж байхдаа, эсхүл хувь этгээдийн хувьд эрх зүйн харилцаанд оролцож байгаад бусдад учруулсан гэм хор нь захиргааны актаас учирсан бол түүнийг арилгуулах үүрэг хүлээлгэхдээ эрх зүйн зөрчлийн бүрэлдэхүүн бий эсэхийг зайлигүй тогтоох шаардлагатай юм.

Захиргааны байгууллага, албан тушаалтаны гэм хор учруулсан хууль бус үйл ажиллагаанд хариуцлага хүлээлгэхэд эрх зүйн зөрчлийн бүрэлдэхүүний асуудлыг зайлшгүй авч үзнэ. Гэм хор учруулсны хариуцлага хүлээх захиргааны байгууллага, албан тушаалтны гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй нь дараах ерөнхий болон тусгай бүрэлдэхүүнтэй байдаг.

Үйлдэл, эс үйлдэхүй, гэм хор буюу хохирол, шалтгаант холбоо, гэм буруу зэрэг нь бүрэлдэхүүний ерөнхий элемент байдаг бол, эрх зүйн байдал, үйл ажиллагаанд холбогдох нөхцөл нь тусгай элемент болдог. Захиргааны актаас учирсан гэм хорын асуудлыг харьяалан шийдвэрлэхдээ эдгээр бүрэлдэхүүн тус бүрд холбогдох нотлох баримтыг судлан тогтоосон байх шаардлагатай.

- Захиргааны байгууллагын хууль зөрчсөн үйл

³ ЗХХШТХ-ийн 70.4



ТӨР, ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, төрөөс иргэний эрхэд хуулийн дагуу халдсаны төлөө олгох нөхөх олговортой холбоотой хэргүүд хоорондоо ялгаатай юм.

Захиргааны байгууллага, албан тушаалтаны хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас бусдад хохирол учирч буй тул үүнийг эрх зүйн зөрчил гэж үзэж хэргийг

захиргааны хэргийн шүүх, эсхүл иргэний хэргийн шүүхээс харьяалан шийдвэрлэнэ.

Харин төрөөс иргэн, хуулийн этгээдийн эрхэд хуулийн дагуу халдсаны төлөө олгох нөхөх олговрын талаар үүссэн маргаан нь нийтийн эрх зүйн харилцаанд хамаарах тул Захиргааны хэргийн шүүхэд харьяалагдана. Уг маргаан нь эрх зүйн зөрчлөөс

хамаараагүй байдгаараа онцлогтой юм. Тухайлбал цагаатгагдсан этгээдэд төрөөс нөхөн олговор олгох, газрыг нөхөн олговортойгоор эзэмшигч, өмчлөгч иргэн, хуулийн этгээдээс төр эргүүлэн авах зэрэг харилцаа хамаарагдана.



**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД ОНОГДУУЛАХ ХАРИУЦЛАГА:
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

(Төрийн жинхэнэ албан хаагчид хүлээлгэх сахилгын шийтгэлийн тухайд)

*Н.Мөнхзул**ХСИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Эрх зүйн
онолын тэнхимийн ахлах багш, цагдаагийн ахмад*

1990 оноос эхлэн Монгол Улс ардчилсан эрх зүйт төрийг байгуулах замд эргэлт буцалтгүй орж, үүнийгээ 1992 оны шинэ ардчилсан Үндсэн хуулиараа баталгаажуулсан билээ. Шинэ Үндсэн хуулийн агуулга, ач холбогдлыг судлаачид дэлхий нийтийн хөгжингүй улс орнуудын жишгийг даган хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрч, түүнийг хэрэгжүүлэх баталгаа бий болгохын зэрэгцээ төрийн эрх мэдлийн тэнцвэрт байдлын үндсийг тогтоон, нутгийн удирдлагын тогтолцоог цоо шинээр бүрдүүлж, Үндсэн хуулийн биелэлтийг хангах механизмыг Монголд анхлан гаргаж ирсэн юм¹ гэж тодорхойлсон байдаг.

Ийнхүү төрөөс баримтлах үзэл бодлогын өөрчлөлттэй холбоотойгоор Монгол улс нь Төрийн албаны тухай хуулийг 1994 онд анх төрөлжсөн хуулийн түвшинд баталж, 2002 онд шинэчлэн найруулсан бөгөөд энэ хуулиар төрийн албаны ойлголт, ангиллыг тодорхойлж,

¹ Ж.Болдбаатар нар. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. Хамтын бүтээл. УБ., 2009. 7 дахь тал.

төрийн жинхэнэ алба хаагчдад оногдуулах хариуцлагын механизмыг тогтоож сануулах, албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах, төрийн албанаас халах шийтгэлийг оногдуулахаар заасан байдаг.

Монгол улс дахь эрх зүйн зохицуулалт боловсронгуй болохын хэрээр төрийн албан хаагчид оногдуулах хариуцлага дараах байдлаар төрөлжиж ирсэн байна. Үүнд:

- Эрүүгийн²
- Сахилгын³
- Эд хөрөнгийн хариуцлага.

Тэрчлэн албан тушаалтны хууль бус үйлдлийг хязгаарласан онцлог нэг зохицуулалт бол Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн “Шүүгчийн хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад аливаа хэлбэрээр нөлөөлөх, халдахыг оролдсон ... албан тушаалтан, төрийн ... байгууллага, ... д хариуцлага хүлээлгэхээр

² Эрүүгийн хууль

³ Дипломат албаны тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, хүний эрхийн үндэсний комиссын тухай, прокурорын байгууллагын тухай хууль, тагнуулын байгууллагын тухай, тахарын албаны тухай, шүүгчийн эрх зүйн байдлын тухай, шүүхийн захиргааны тухай, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай, шүүхийн шинжилгээний тухай, төрийн хяналт шалгалтын тухай зэрэг хуулиуд

зааж, төрийн байгууллагын албан тушаалтныг эрх бүхий байгууллага, албан тушаалтан албан тушаалаас нь чөлөөлөх буюу огцруулах арга хэмжээ авах, хэрвээ төрийн байгууллагын албан тушаалтныг албан тушаалаас нь чөлөөлөөгүй буюу огцруулаагүй бол шүүхийн журмаар албадан чөлөөлж, огцруулах бөгөөд энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлахаар заасан нь төр, түүний алба хаагчдын давуу байдлыг хязгаарлахыг оролдсон ч мөн л хэрэгжих механизм нь тодорхойгүй байгаа юм.

Харин эрүүгийн болон эд хөрөнгийн хариуцлага оногдуулах эрх зүйн зохицуулалт, механизм бүрдсэн байдаг бол сахилгын хариуцлагатай холбоотой маргаантай асуудлууд цөөнгүй байна.

Энэ утгаараа Монгол улсад 2002 онд хуулийг нь баталж, 2004 онд захиргааны хэргийн шүүх байгуулсан бөгөөд байгуулагдсан цагаас хойш 2013 оны байдлаар анхан шатандаа нийт 7442 хэрэг шийдвэрлэсэн бөгөөд үүнээс 3114 хэрэгт нэхэмжлэлийн шаардлагыг хангасан нь төдий тооны захиргааны хууль бус үйл ажиллагааг тогтоож, иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан гэсэн үг. Иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангасан



2062 шүүхийн шийдвэрийг удирдлага болгосон заалтаар нь авч үзвэл:

1. Захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэрийг хүчингүй болгосон – 1245 шийдвэр ЗХХШТХ-ийн 70.2.1

2. Захиргааны байгууллага, албан тушаалтан - иргэн, хуулийн этгээдийн хооронд эрх зүйн харилцаа байгаа гэж үзсэн - 6 шийдвэр, ЗХХШТХ-ийн 70.2.2

3. Захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа нь илт хүчин төгөлдөр бус болохыг хүлээн зөвшөөрсөн – 67 шийдвэр, ЗХХШТХ-ийн 70.2.3

4. Захиргааны байгууллага, албан тушаалтныг захиргааны шийдвэр гаргахыг даалгасан – 268 шийдвэр, ЗХХШТХ-ийн 70.2.4

5. Актын төлбөрийн хэмжээг багасгасан – 120 шийдвэр, ЗХХШТХ-ийн 70.2.5

6. Захиргааны байгууллага, албан тушаалтнаас иргэнд учруулсан хохирлыг гаргуулах, хохирлын хэмжээг өөрчилсөн, хассан– 5 шийдвэр, ЗХХШТХ-ийн 70.2.6

7. Захиргааны байгууллага, албан тушаалтнаас дахин шинэ акт гаргал захиргааны уг актыг түдгэлзүүлсэн – 114 шийдвэр, ЗХХШТХ-ийн 70.2.7

8. Захиргааны байгууллага, албан тушаалтан нь иргэн, хуулийн этгээдийн гаргасан шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, эвлэрсэн – 237 шийдвэрийг тус тус эзэлж байна. ЗХХШТХ-ийн 42, 43⁴

Дээрх тоон үзүүлэлтээс харахад Нийслэл болон дүүргийн Засаг дарга төрийн албан

тушаалтныг томилж чөлөөлөх эрх бүхий албан тушаалтан болох дүүргийн тамгын даргаас эхлээд сайд хүртэлх албан тушаалтнууд, ашигт малтмалын газрын геологи уул уурхайн кадастрын хэлтсийн дарга, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн байцаагч нараас гарсан 1409 шийдвэр хууль бусаар гарсан байна. Энэ нь шүүхээр шийдвэрлэгдэж хууль бус гэж үзэн хүчингүй болгосон шийдвэрийн 72 хувийг эзэлж байгаа юм. Гэсэн ч хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхгүй байгаа эрх зүйн зохицуулалт боловсронгуй бус байгаатай холбоотой юм.

Мөн шүүхээс гаргасан шийдвэрийг албадан биелүүлэх зохицуулалтыг ИХШХШТХ-иар зохицуулсан боловч иргэн, хуулийн этгээдээс хандсан 70 орчим шүүхийн шийдвэр биелэгдээгүй ба маргааны төрлөөр нь авч үзвэл:

- Газрын асуудлаар эрх бүхий албан тушаалтан захирамж, тушаал гаргахгүй, өргөдлийг шийдвэрлэхгүй байгаа
- Ашигт малтмалын лицензийг олгохгүй, өргөдлийг хүлээн авч шийдвэрлэхгүй, хугацааг сунгахгүй байгаа
- Төрийн албан хаагчийг ажилд эгүүлэн тогтоосон шийдвэр гаргахгүй байгаа гэсэн төрлүүд байна.

Шийдвэрийг биелүүлэхгүй байгаа албан тушаалтныг авч үзвэл нийслэлийн болон дүүргийн засаг дарга, Ашигт малтмалын газар, Геологи уул уурхайн кадастрын хэлтсийн дарга, Улсын бүртгэлийн ерөнхий газар, төрийн нарийн

бичгийн дарга, МХЕГ, НМХГ, яам, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Зэвсэгт хүчний жанжин штаб, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Татварын ерөнхий газрын дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Оюуны өмчийн газар, Санхүүгийн зохицуулах хороо, Дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс⁵ тус бүр 1-20 орчим шийдвэрийг биелүүлээгүй байна. Үүнтэй холбоотойгоор Шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шүүхийн шийдвэрийг биелүүлэхээр шүүх, цагдаагийн байгууллага, прокурор, Хууль зүйн сайд, Ерөнхийлөгчид хүртэл хандаж захиргааны шүүхийн шийдвэрийг биелүүлэхээр олон арван албан бичгийг /мэдэгдэл/ явуулж, шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа захиргааны албан тушаалтанд арга хэмжээ авахуулахаар дүүргийн шүүхэд хандахад “зөрчил гаргасан хүнээ авчир” гэдэг шаардлагыг тавьдагаас шийдвэр гүйцэтгэгч нар захиргааны арга хэмжээ авахуулж чаддаггүй байна. Мөн шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа хэд хэдэн албан тушаалтанд эрүүгийн хариуцлага ногдуулахаар шийдвэр гүйцэтгэгчээс дүүргийн Цагдаагийн хэлтэст хандсан боловч эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан байна. Үүний шалтгаан нь эрүүгийн хэрэг үүсгэн шалгагдаж байх явцад шүүхийн шийдвэрийг биелүүлдэг, биелүүлсэн гэж өөрсдөө үзэн гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж хаажээ. Зарим тохиолдолд шүүхийн шийдвэрийг биелүүлсэн дүр үзүүлдэг, биелүүлэхийг хүсдэггүй. Тухайлбал төрийн албан хаагчийг ажилд эгүүлэн

⁴ Л.Өлзийбаяр. “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн хэрэгжилт, тулгамдсан асуудал”. УБ.,

⁵ Захиргааны хэргийн шүүхийн 10 жилийн ойн хүрээнд хийгдсэн судалгаа. 2014 он



томилсон шийдвэр гаргасаны дараа албан тушаалыг бууруулсан тушаал гаргадаг, тухайн албан тушаалд өөр хүнийг томилсон бөгөөд орон тоо байхгүй гэдэг байна.

Хууль бус шийдвэрийг гаргасан, шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт боловсронгуй бус байгаатай холбоотой бөгөөд энэ нь эрх зүйт төр оршин хөгжихгүй, шүүх эрх мэдлийн гүйцэтгэх эрх мэдэлд тавих хяналт бодитой хэрэгжихгүй цаашилбал шүүхийн шийдвэр үнэгүйдэхэд хүргэж байгаа нь нууц биш болжээ. Нөгөө талаасаа захиргааны байгууллага хууль зөрчсөн шийдвэр гаргасныхаа төлөө хариуцлага хүлээх тогтолцоо сайн төлөвшөөгүй нь үүнд нөлөөлж байна.

Харин хохирлыг барагдуулахтай холбоотой зохицуулалтын хувьд иргэдэд чирэгдэл үүсэхгүйгээр шийдвэрлэх болсон ба энэ төрлийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хуулийн дагуухийгдэх болжээ. Гэхдээ захиргааны байгууллагын албан тушаалтан шүүхийн шийдвэрийн дагуу төрийн албан хаагчийг ажилд нь томилохгүй байгаагаас ажилгүй байсан хугацааны цалинд их хэмжээний төлбөрийг өгдөг байна. Тухайлбал нэгэн төрийн албан хаагч 2010 оны 10-р сараас хойш ажилгүй байсан хугацааны цалинд 17 сая төгрөгийг төрөөс гаргуулсан бөгөөд одоо үлдсэн 22 сая төгрөгийг төсвөөс гаргуулахаар иргэний шүүхийн шийдвэр гарчээ. Өөрөөр хэлбэл нэг албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас болж, төрөөс

39 сая төгрөгийг гаргуулахаар шийдвэрлээд байна. Иймд цаашид Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д зааснаар төр өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай албан тушаалтнаас гаргуулан авах хуулийн заалтыг хэрэгжүүлэх цаг болжээ. Түүнчлэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал, урамшууллыг иргэнээс гаргуулж хохироолгүй, шийдвэрийг биелүүлэхгүй байгаа албан тушаалтан, байгууллагаас гаргуулж байвал зүйтэй юм.

Нөгөөтэйгүүр төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдлыг Төрийн албаны тухай хуулиар зохицуулдаг бөгөөд зарим алба хаагчдын эрх зүйн байдлыг өөр хуулиар зохицуулдаг, зарим алба хаагчдын эрх зүйн байдлыг байгууллагын дотоод дүрэм, журмаар зохицуулдаг зэргээс хамаарч оногдуулж буй хариуцлага нь харилцан адилгүй, мөн Төрийн албаны хуулиас давсан хариуцлагын механизмыг бий болгож байгаа нь дарга нараас субъектив байдлаар хандах, хариуцлагын үр нөлөөг буруулах нөхцлийг бий болгож байна. Мөн төрийн албан хаагчид хариуцлага оногдуулдаг процедурыг хуульчлаагүйгээс энэ төрлийн маргаантай асуудалд захиргааны шийдвэр үгүйсгэгддэг нөхцөл байдал ч бас байна.

Дүгнэн хэлэхэд Монгол улсын нийгмийн байгууллын өөрчлөлттэй холбоотойгоор эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосоор ирсэн ч зохицуулалт нь ойлгомжгүй, хэрэгжих механизмыг тогтоогоогүй, албан тушаалтны эрх мэдлийг хязгаарлаагүй,

хариуцлага тооцох механизм бүрдээгүй зэрэг хүндрэл бэршээлүүд гарсаар байгааг дээрх баримтууд нотолж байна. Үүнээс үүдэн төрийн албан хаагчид оногдуулж хариуцлага үр нөлөөгүй, төрийн албан хаагчид гаргасан алдаагаа залруулах, хэрэглэж буй хууль, дүрэм журмыг боловсронгуй болгох тал дээр ч санаачлага гаргахгүй байна. Нэгэнт төрийн алба мэргэшсэн алба хаагчдаар бүрддэг тул тэдний хариуцлага өндөр, хариуцлагын механизм тодорхой, үр нөлөөтэй хэрэгждэг байх ёстой. Цаашид:

- Төрийн албаны тухай хуулийг өөрчилж сахилгын шийтгэлийн төрлийг судалгаатайгаар нэмэгдүүлэх энэ хуулийг баримтлах
- Тус хуулиар хариуцлага оногдуулах процедурыг тогтоох, ямар зөрчилд ямар төрлийн хариуцлага оногдуулахыг зааж өгөх
- Захиргааны шүүхийн шийдвэртэй холбоотойгоор хариуцлага оногдуулах механизмыг тодорхой болгох
- Төрд учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаас гаргуулах зохицуулалтыг хэрэгжүүлэх механизмыг бий болгох
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг Засгийн газрын бүтцээс гаргах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн захиргааны шийдвэр биелүүлэх ажиллагаатай холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.



**БНХАУ-ААС ХИЛИЙН ЧАНАДАД ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БҮСБАЙГУУЛЖ БУЙ ӨНӨӨГИЙН
НӨХЦӨЛБАЙДАЛ, СУДАЛГААНЫ АЧ ХОЛБОГДОЛ***Сүхбаатарын Оргил**/敖日格乐/**БНХАУ-ын Улс төр, хуулийн их сургуулийн
Олон улсын эрх зүйн сургуулийн докторант*

Хятадулс 2001 оноос Дэлхийн худалдааны байгууллагад элссэнээр гадаад худалдааны хурдацтай хөгжлийн эрин үед шилжиж, “хөрөнгө оруулалт татах” бодлогоос “хөрөнгө оруулалт татах” болон “хөрөнгө оруулах” бодлого руу шилжиж, гадаадад хөрөнгө оруулагч их гүрэн болж хувирсан.

Энэ нь Хятад улсад худалдааны илүүдлийг саармагжуулах, эдийн засгийн халалтыг багасгах, өсөн нэмэгдэж буй худалдааны болон хөрөнгийн урвуу хамаарал, их хэмжээний валютын нөөцийг зөв зарцуулах арга замыг тодорхойлох шинэ сорилт тулгарсантай холбоотой.

2000 онд БНХАУ-ын Засгийн газраас албан ёсоор гадаадад “хөрөнгө оруулах” бодлогыг төрийн стратегийн төвшинд хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд голлох арга нь хилийн чанадад худалдаа, эдийн засгийн чөлөөт бүс байгуулах явдал байв. Улмаар 2006 онд албан ёсоор анхны худалдаа, эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулжээ.

Хилийн чанад дахь худалдаа, эдийн засгийн хамтын

ажиллагааны бүс гэдэг нь Хятадын төрийн хяналт дор дотоодын аж ахуй нэгжүүд гадаадад барилга угсралт, дэд бүтцийн бүтээн байгуулалтад оролцож, үйлдвэрлэлийн сүлжээ бий болгох, харьцангуй нөлөө ихтэй аж үйлдвэрийн бүс, шинжлэх ухааны үйлдвэрлэлийн парк зэрэг олон төрлийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах ойлголт болно.

Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нь нэг төрлийн эдийн засгийн хамтын ажиллагааны тогтолцоо бөгөөд Хятадын аж ахуй нэгжүүд бусад улсын засгийн газартай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, тус гэрээнд хамаарах газар нутаг, хамрах хүрээг тодорхойлж, харилцан хөрөнгө оруулах замаар худалдаа үйлчилгээ эрхэлнэ. Хятадын аж ахуй нэгж худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүсэд гол субъект нь байхаар тооцож, худалдааны үйл ажиллагааг үндэслэн харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг байгуулах нөхцөл бүрдвэл Хятадын маш олон аж ахуй нэгжүүд хүлээн авагч улсад ирж барилга байгууламж, үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт хийх ба тухайн

улсын татварын орлого, ажлын байр, гадаад валютын урсгалыг нэмэгдүүлдэг. Ингэснээр хүлээн авагч улсын техник технологийн төвшин дээшилж, эдийн засгийн хамтын ажиллагаа хөгждөг.

Хятадын өнөөгийн гадаад улстай байгуулж буй худалдаа, эдийн засгийн бүсийн хамтын ажиллагааг дөрвөн төрөлд хувааж болно. Үүнд:

Нэгдүгээрт - Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хамтын ажиллагааны бүс. Тухайлбал, Пакистан улс дахь Haier группын “Ruba” эдийн засгийн бүс.

Хоёрдугаарт - Хүлээн авагч улсын нөөц баялагт тулгуурлан хөнгөн, хүнд үйлдвэр барих хамтын ажиллагааны бүс. Жишээ нь: ОХУ-ын Томск хотын модны аж үйлдвэр, худалдааны хамтын ажиллагааны бүс.

Гуравдугаарт - Хятадын уламжлалт үйлдвэрлэлийн олон талт эдийн засгийн хамтын ажиллагааны бүс. Тухайлбал, Мауритус улс дахь “Tian Li” эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны бүс.

Дөрөвдүгээрт - Хятадын гадаад хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн бүтцийг чиглэл болгосон техник, менежментийн чиглэлийн хөрөнгө оруулалт хийх худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс. Тухайлбал, БНСУ-Хятадын олон



улсын үйлдвэрлэлийн хүрээлэнг дурдаж болно.

БНХАУ-ын Худалдааны яамнаас 2006 оны 6 сар, 2007 оны 7 сард хоёр удаа хамтын ажиллагааны бүсийн тендер зохион байгуулж, хилийн чанадад хөрөнгө оруулалт хийж, худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах

19 төсөл шалгаруулж, 15 улс оронд хэрэгжүүлэхээр болсон.

Улмаар 2006 оны 11 сард нэмж 8 улсад эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах шийдвэр гаргаж, ажил хэрэг болгосон байна.

Өнөөгийн байдлаар 3 дахь удаагийн гадаад худалдаа хамтын ажиллагааны бүсийн

тендерийн сонгон шалгаруулалт явуулахаар судлаж, тендерийн хугацааг тогтоохоор ажиллаж байна.

Хятадаас гадаад улс орнуудад байгуулсан 19 худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн товч танилцуулгыг Хүснэгт №1-д үзүүлэв.

Хүснэгт №1

№	Газрын нэр	Хүлээн авагч улс	Хятадаас хөрөнгө оруулсан ААН	Гол эрхлэх хүрээ, зорилго
1	Haier-Ruba эдийн засгийн бүс	Пакистан	Haier корпораци /ШаньДун/	Гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, дагалдах үйлдвэр, түүхий эд, бэлэнбүтээгдэхүүний тээвэр
2	“Kang Ji” худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс	ОХУ Уссурийск	Kang Ji групп, Ji Xin групп	Хятадын гутлын үйлдвэрлэлийг дэлхийн Брэнд болгох, бүс нутгийн үйлдвэрлэлийн бааз болох
3	“Tianli” эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны бүс	Мауритиус улсын нийслэл Порт Луис хот	“Tianli”аж үйлдвэрийн групп	Африкийн бүс нутгуудад Хятадын аж ахуйн нэгжүүдийн удирдлагын төвийг байгуулах, санхүүгийн төлбөр тооцоо, техникийн дэмжлэг үзүүлэх, дахин экспортлох, түүхий эдийн худалдаа явуулах
4	Замби, Хятадын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс	Замби Copperbelt муж	Хятадын өнгөт метал, уул уурхайн групп	Зэс, кобальт олборлох, Зэс, кобальт хайлуулах, өнгөт металлуул уурхай, металлургийн үйл ажиллагаа явуулах
5	“Luo Yong”, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа бүс	Тайланд улсБора хот	“Hua Li”групп	БНХАУ-ын Авто эд анги, машин механизм, барилгын материал, гэр ахуйн цахилгаан бараа үйлдвэрлэлийн салбарын шилдэг үйлдэрлэгч
6	“Taihu”Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны бүс	Камбож улс Sihanoukville хот	“Hong Du”групп	Хөнгөн аж үйлдвэр, нэхмэл болон хувцасны бизнес аж үйлдвэрийн шинэ хот
7	Guandong худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс	Нигери улс	“Xinguang”олон улсын групп	Xinguang тавилга, керамик барилгын материал, тоног төхөөрөмж, эмийн үйлдвэрлэл
8	ОХУ-ын Балтийн тэнгисийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс	ОХУ, Санкт-Петербург хот	Шаньхай гадаад хөрөнгө оруулалтын компани	Үл хөдлөх хөрөнгийн худалдаа, зочид буудал, оффис, зоогийн газар, соёл, амралтын болон бусад байгууламжийн худалдаа



ТӨР, ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

9	Хятад - Нигер худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс	Нигери улсын Лагос хот	Хойд азийнолон улсын хөрөнгө оруулалтын Хятад, Туркийн хамтарсанкомпани	Африкийн бүс нутагт хамгийн орчин үеийн бүтээн байгуулалтыг бий болгох, үйлдвэрлэл, борлуулалт, импорт экспортын худалдаа, амралт, аялал жуулчлалыг цогцоор хөгжүүлэх
10	Томск модны үйлдвэр худалдааны хамтын ажиллагааны бүс	ОХУ Томск хот	“Yantai”баруун хойд ойн үйлдвэрлэлийн компани	Модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт
11	Этиоп - Дорнын аж үйлдвэрийн парк	Этиоп улс	“Jiangsu Yonggang” групп	Металлурги, барилгын материал, тоног төхөөрөмж
12	Хятадын “Longjiang” худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс	Вьетнам улс	“Hailiang” групп	Нэхмэлийн хөнгөн аж үйлдвэр, машин, электроникийн, барилгын материал, химийн бодис болон бусад өрсөлдөх чадвартай салбар
13	Мексик - Хятадын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны (Ningbo) Jiliaж үйлдвэрийн бүс	Мексик улс Aguascalientes муж	“Jili Holding” групп	Аж үйлдвэр, худалдааны цогц хамтын ажиллагааны бүс
14	Венесуэлийн шинжлэх ухаан, технологи, аж үйлдвэрийнпарк	Венесуэл улс	“Langchao” групп	Электрон хэрэгсэл, гэр ахуйн бараа, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл
15	БНСУ -Хятадын Олон улсын аж үйлдвэрийн парк	БНСУ Muan Jeolla аймаг	“Dongtai Huaan” хамтарсан хувьцаат групп	Шинжлэх ухаан, технологи, соёл, аялал жуулчлал зэрэг олон талын онцлогтой өндөр технологийн парк
16	Египетийн Суэц худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс	Египетулс Суэц	“TianjingTaida”хөрөнгө оруулалтын холдинг компани	Нэхмэл сүлжмэл хувцас, газрын тосны тоног төхөөрөмжийн голлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл, машины сэлбэг, цахилгаан тоног төхөөрөмж, хүчдэл багатай цахилгаан хэрэгслийн үйлдвэрлэл
17	“Guangxi”Хятад – Индонезийн худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны бүс	Индонези	“Guangxi” фермийн аж үйлдвэрлэлийн групп	Түүхий эд материал, химийн бодис, барилгын материал, эмийн сангийн болон бусад салбарын аж үйлдвэрлэл
18	“Jiangling”АлжирХят адынхудалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааныбүс	Алжир улс	“Zhongding Jiangling” автомашины групп	Машин,барилгынматериалболон бусад холбогдох 100 аж ахуйн нэгжийг төлөвлөгөөны үндсэн оролцуулах
19	Вьетнам, Хятад (Shenzhen) худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааныбүс	Вьетнам улс	Хятадын агаар тээврийн корпораци, ШэньЖэн Олон улсын компани	Цахим мэдээлэл, хувцас үйлдвэрлэл

(Эх сурвалж: Хятадын Худалдааны газрын вэб сайт)



Хятад улсын эдийн засаг, хамтын ажиллагааны бүс байгуулах үе шат:

1. **Нээлттэй тендер хэрэгжүүлэх байгууллага, тендерийг сонгох үе шат:** Эхлээд Худалдааны яам тендерийн үндсэн бодлогыг баталж, нээлттэй тендер явуулах арга болон хэрэгжүүлэх төрийн байгууллагыг сонгож, тендерийн бичиг баримтыг хүргүүлж, оролцох сонирхолтой аж ахуйн нэгжүүдэд мэдээлэдэг.

2. **Аж ахуйн нэгжүүдээс тендерийн санал авах үе шат:** Худалдааны яамны шаардлагын дагуу бүх муж, хотын засгийн газрын холбогдох байгууллагууд томоохон аж ахуйн нэгж корпорациудаас ирүүлсэн хилийн чанадад худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах саналыг хүлээн авна.

3. **Шалгаруулсан аж ахуйн нэгжийг нийтэд мэдээлэх үе шат:** Худалдааны яамнаас гадаад эдийн засаг хамтын ажиллаганы бүсийн нэрсийг нарийвчлан үзэж, шалгасны үндсэн дээр баталдаг бөгөөд хамгийн гол нь төслийн чанар, тендер оролцогчийн хөрөнгө оруулалт хийх чадвар, удирдлагын

чадвар, гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны орчинзэргийг нарийвчлан хянаж үздэг.

4. **Аж ахуй нэгжийн бүтээн байгуулалтын үе шат:** Худалдааны яамны шалгуурыг давж, батлагдсан аж ахуйн нэгжийг Засгийн газраас дэмждэг. Аж ахуй нэгжийн удирдлага хүлээн авагч улсын засгийн газартай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах хэлэлцээр байгуулж, бүтээн байгуулалтын төлөвлөгөөний дагуу зах зээлийн зарчмаар дотоодын аж ахуйн нэгжүүдтэй хамтран хэрэгжүүлдэг.

5. **Засгийн газрын үнэлгээний үе шат:** Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг байгуулах, хөгжүүлэхэд Худалдааны яамнаас бүтээн босгох хугацаа тогтоон өгч, шаардлагатай хяналт шалгалт явуулах зэрэг үе шатаас бүрддэг.

Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах явцад БНХАУ-ын засгийн газраас буцалтгүй мөнгөн тусламж үзүүлж, төрийн бодлогоор дэмждэг. Санхүүжүүлэх хэлбэрийн

хувьд Худалдааны яамны төлөвлөгөөний дагуу хамтын ажиллагааны бүс тус бүрт 200-300 сая юанийн санхүүжилт өгдөг. Дунд, урт хугацааны зээлийн хувьд ихэнхдээ 2 тэрбум юань байдаг. БНХАУ-ын Худалдааны яам санхүү, даатгал, хилээр нэвтрэх, татвар хураах зэрэг үйл ажиллагааны гадаадад хөрөнгө оруулалтын цогц бодлого хэрэгжүүлдэг. Мэдээллийн үйлчилгээний тал дээр улсаас өөр улс орон, бүс нутгийн хөрөнгө оруулалтын орчин бусад холбогдох мэдээлэл, тайлан гаргаж, бүхий л аж ахуй нэгж, байгууллага, нийгмийн ажилтнуудад үнэгүй түгээдэг.

Төрийн баталгааны тухайд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах асуудал нь Засгийн газар хоорондын дээд төвшний эдийн засгийн хамтын ажиллагааны шинжтэй бөгөөд Засгийн газрын хүчтэй дэмжлэг дор БНХАУ-ын аж ахуй нэгж гадаадад хөрөнгө оруулалт хийж байгаа нь улс төрийн хамгаалалт төдийгүй, эрсдэл бий болохоос урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдүүлдэг ач холбогдолтой хэмээн хятадын тал үздэг.





ТАНЫ ЧӨЛӨӨТ ЦАГТ

ЦАХИМ ҮЕРХЭЛ БА ӨШӨӨ АВАЛТ

2013 онд Мичиган мужийн оршин суугч, 29 настай Хилэ өөрийн бүтэлгүй онлайн дурлалаасаа болж, 5 жилийн хорих ял шийтгэгджээ.

Брайн Куртис Хилэ 2011 онд нэгэн эмэгтэйг найз залуугийн хамтаар хөнөөх зорилготойгоор Мичиганаас Сан-Диего хот руу явсан бөгөөд хосууд өөрсдийгөө Хилэгийн хайр дурлалын явдалтай орооцолдсон болохыг мэдээгүй байна.

Хилэ нь олон нийтийн сүлжээ ашиглан хуурамч аккаунт үүсгэж, өөр хүний дүрд хувирч хүмүүстэй танилцдаг хүний урхинд орсон бөгөөд 2 жил интернэтээр үерхсэн эмэгтэйтэйгээ эрэгтэй хүн гэдгийг мэдэлгүй илэн далангүй харьцаж, олон төрлийн зураг, романтик мессэж илгээдэг байжээ. Гэтэл харилцдаг эмэгтэйгээ Өмнөд Африкт амьдардаг, эрэгтэй хүн гэдгийг мэдсэний дараагаар Хилэ ихэд уурласан бөгөөд өөрийг нь мэхэлсэн Африк эр болон уг хэрэгт “үүрэг гүйцэтгэсэн” эмэгтэй хоёрыг заавал олно хэмээн өөртөө амлалт өгчээ.

“Энэ тохиолдолд тус эмэгтэй хоёр удаа хохирогч болсон” хэмээн Сан Диего хотын Цагдаагийн хэлтсийн төлөөлөгч Ким хэлсэн. Цахим гэмт хэрэгтэй тэмцэх багийн төлөөлөгч Кимийн хэлж буйгаар – Хэдийгээр бүсгүй 18 настай байхдаа хувийн хэрэгцээндээ

зориулж нүцгэн зургаа авсан боловч хэсэг хугацааны дараагаар түүний онлайн аккаунтад байсан эдгээр зураг нь алга болсон байна. Алга болсныг мэдсэн боловч чухам ямар зориулалтаар ашиглагдаж байсныг бүсгүй мэдээгүй байжээ.

Хилэгийн өшөө авах гол бай нь түүнийг энэ бүх хугацаанд хуурч байсан Африк эр боловч Өмнөд Африк хэтэрхий хол байсан тул Хилэ эмэгтэйг уг хэрэгтэй огт холбоогүй гэдгийг мэдэж байсан боловч тэр эмэгтэйн зураг өөрт нь тохиолдсон уг хэрэгтэй холбоотой учраас бүсгүйг ямар нэгэн байдлаар хариуцлага хүлээх ёстой хэмээн эмэгтэйн араас явжээ.

Интернэт болон компьютер тоглоомын хорхойтон Хилэ эмэгтэйг хэн болохыг олж тогтоохоор шийдэж, интернэтээр маш их хайлт хийж, хууль бус нэвтрэх хэрэгсэл хүртэл ашигласны үр дүнд нь тэрээр бүсгүйн и-мэйл аккаунтыг хакердаж бүсгүйн талаарх хувийн мэдээлэл, гэр бүл найз нөхөд, найз залуугийнх нь мэдээлийг олж авчээ.

Бүсгүйн гэрийн хаягийг олсон Хилэ өшөөгөө авахын тулд Мичиганаас Сан Диего орох автобусны билет авчээ. Хилэгийн гэрийнхэн түүнийг ямар нэгэн юм сэдэж байгааг мэдэж, эрх бүхий газарт сэрэмжлүүлсний дүнд Хилэ

бүсгүйн гэрээс 1 км-ийн зайтай байхад баривчилж, Сан Диегод цагдан хорьжээ.

Хилэг баривчлах үед тэрэнд эмэгтэйн гэрийн хаяг, утасны дугаар, дуртай зоогийн газрын нэрс г.м хувийн мэдээлэл бүгд байснаас гадна скоч, олс, мөн хутга, хлороформ зэрэг зүйлс биедээ авч явжээ.

Төлөөлөгч Кимийн хэлж буйгаар хэрэгтэн хохирогчдыг гэмтээж эсвэл алж болох байсан бөгөөд 2013 оны 8 сард Сан Диегогийн Шүүхээс Хилэг гэм буруутайд тооцож, ял оногдуулсан байна.

Уг хэрэг бусад хүмүүст сануулга болно хэмээн төлөөлөгч Ким найдаж байгаа бөгөөд тэрээр “Хүмүүс интернэтээр хэнтэй харьцаж байгаагаа маш сайн мэдэх хэрэгтэй, хэрэв эсрэг хүнээ сайн мэдэхгүй бол хувийн мэдээлэл болон зургаа илгээхгүй байх”-ыг сануулж, “Интернэт бол маш гайхамшигтай боловч бас аймшигтай зүйл” хэмээн хэлжээ.

Маш олон залуучууд нэн ялангуяа өсвөр насны охид цахим гэмт хэрэг болох секс сүрдүүлгийн хохирогч болж байна. Иймд интернэт болон олон нийтийн сүлжээ ашиглахдаа сонор сэрэмжтэй байх хэрэгтэй.

Охид, залуучууд гэрэл зургаа илгээх нь ноцтой хор уршиг дагуулахыг ухамсарлахгүйгээс гадна нэгэнт интернэт, и-мэйлээр



эсвэл олон нийтийн сүлжээ сайт мэдээлэл нь эргээд хакеруудад
ашиглан явуулсан зураг байнга ашиглагдаж болох юм.
байдаг гэдгийг мэддэггүй.

Олон нийтийн сүлжээ, сайт
болон аккаунт дээрээ хувийн
мэдээллээ тавихгүй байх
хэрэгтэй. Аюулгүй мэт санагдах
боловч танд юу таалагддаг
(Likes) болон таалагддаггүй зэрэг

Эх сурвалж:

- <http://www.fbi.gov/п>

Орчуулсан: Баярсайханы
Энхжин

